



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

# МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ

# 2017

WHITE PAPER ON CRIME

УЛААН БААТАР ХОТ  
2018 ОН

## Гүйцэтгэгч байгууллага:



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБОО

## Дэмжигч байгууллага:



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

## Хамтран ажилласан байгууллага:

- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Улсын ерөнхий прокурорын газар
- Авлигатай тэмцэх газар
- Үндэсний статистикийн хороо
- Цагдаагийн ерөнхий газар
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
- Хууль сахиулах их сургууль

## СУДАЛГААНЫ БАГ

### ЗӨВЛӨХ:

Г.Эрдэнэбат  
Л.Нямгэрэл

Ж.Болдбаатар

Д.Зүмбэрэллхам  
Б.Батзориг  
Б.Хишигсайхан

Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч  
Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх  
ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D),  
профессор  
Хууль зүйн доктор (Ph.D), профессор  
Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор  
Нээлттэй нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн  
менежер

### ГИШҮҮД:

#### Багийн ахлагч

Хууль зүйн доктор (Ph.D) Б.Мөнхдорж

#### Судлаачид

Б.Ариунтуяа  
Б.Баяндүүрэн  
Ц.Гантулгабат  
Ц.Дулмаа  
О.Мөнхцэцэг  
Б.Мөнхсэргэлэн  
Г.Оюунболд  
М.Цэдэвсүрэн  
Б.Энхболд  
О.Уулзахжаргал

## ХАМТРАН АЖИЛЛАСАН

Ц.Мандах	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн судалгааны хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор
Б.Отгон	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн судалгааны хүрээлэнгийн Судалгааны ахлах ажилтан
Э.Ганцэцэг	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн судалгааны хүрээлэнгийн Судалгааны референт
Б.Бат-Орших	Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, УЕПГ-ын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга,
У.Эрдэнэтуяа	Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, УЕПГ-ын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн прокурор
Ц.Бадам	Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан
О.Зоригт	Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга, хууль зүйн доктор (Ph.D)
П.Батбаатар	Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн дарга
С.Энхбаатар	Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн
Ч.Батболд	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны ахлах мэргэжилтэн
Ц.Ганчимэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх албаны ахлах мэргэжилтэн
М.Эрдэнэжаргал	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын шинжээч



## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас санаачлан, гэмт хэргийн цагаан номыг 2016 онд анх удаа эрхлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгосон.

Энэ удаад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оны гэмт хэргийн цагаан номыг гаргаж, та бүхний өмнө дэлгэн барьж байна.

Өнгөрсөн жилийн тухайд улсын хэмжээний гэмт хэргийн мэдээ, мэдээллийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэн судалгаа хийж, судлаачдын дүгнэлтэд тулгуурлан санал дэвшүүлэх байдлаар Цагаан ном хийгдсэн бол энэ удаад цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улмаар Нэгдсэн үндэстний байгууллагын олон улсын гэмт хэргийн ангилалтай харьцуулагдаж буй байдлыг илэрхийлэх, мөн нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцоолж, гэмт хэргийг тодорхой төрөл, үйлдэгдсэн онцлог, нутаг дэвсгэрийн гэмт хэргийн нөхцөл байдлыг ойлгомжтой хэлбэрээр системчлэн оруулах, судлаачдын санал, дүгнэлтээс зайлсхийж гэмт хэргийн нөхцөл байдлыг тоон хэлээр байгаа түвшинд нь бодитойгоор харуулахыг зорьсон нь Цагаан ном-2017 товхимлын онцлог боллоо.

Нөгөөтэйгүүр, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны статистикийг байгууллага тус бүрээр нь ангилан хавсралт болгож оруулсанаар эдгээр байгууллагуудын тоон үзүүлэлтийг хооронд нь харьцуулах боломжийг бий болгож, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөх, үр дүнд нь үнэлэлт дүгнэлт өгөхөд чухал ач холбогдолтой гэж харж байна.

Мөн тус зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас улсын хэмжээний гэмт хэргийн статистик тоо мэдээллийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, зарим төрлийн гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн, эрүү, криминологийн чиглэлийн судалгааны цахим санг үүсгэх, гэмт хэргийн цагаан номыг цахим хэлбэрт оруулж, багш, оюутан, судлаач, практикийн ажилтан хэн бүхэнд ашиглах боломжийг бүрдүүлэх гэх мэт тодорхой ажлууд хийгдэж байгаа талаар дурдах нь зүйтэй.

Ингээд “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэж, үр дүнг нэгтгэн, товхимол хэлбэрээр эрхлэн гаргахад хамтран ажилласан Монголын криминологичдын холбоо, Нээлттэй нийгэм форум, Хууль сахиулахын их сургууль, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Үндэсний статистикийн хорооны холбогдох нэгжийн удирдлага, алба хаагч, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач нарт гүн талархал илэрхийлье.

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА                      Л.НЯМГЭРЭЛ

# АГУУЛГА

<b>Товчилсон үгийн жагсаалт .....</b>	<b>8</b>
<b>Нэгдүгээр бүлэг. Гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ.....</b>	<b>11</b>
1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг .....	12
1.2 Прокурорын хяналт .....	20
1.3 Шүүхийн шийдвэрлэлт .....	22
1.4 Дүгнэлт .....	23
<b>Хоёрдугаар бүлэг. Монгол улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаагаар тооцсон нь .....</b>	<b>25</b>
2.1. Нуугдмал гэмт хэргийн түвшинг судлах шаардлага, үндэслэл .....	26
2.2. Судалгааны арга зүй.....	26
2.3. Нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцсон нь.....	29
2.4. Дүгнэлт .....	32
<b>Гуравдугаар бүлэг. Гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэх нь .....</b>	<b>33</b>
3.1. Удиртгал.....	34
3.2. Гэмт хэргийн статистикийн мэдээллийн олон улсад харьцуулагдах байдал .....	36
3.2.1 НҮБ-ын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэл цуглуулалт.....	43
3.2.2 Гэмт хэргийн статистикийн мета мэдээлэл, мэдээллийн сангийн өнөөгийн байдал .....	56
3.3. Гэмт хэргийн статистикийг олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ, шаардлага .....	60
3.3.1 Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг хэрэгжүүлэх нь.....	60
3.3.2 Гэмт хэргийн хохирогчийн судалгааг явуулах хэрэгцээ, шаардлага.....	62
3.3.3 Тогтвортой хөгжлийн холбогдох үзүүлэлтүүдийг буй болгох хэрэгцээ, шаардлага.....	63
3.3.3.1 “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөр.....	63
3.3.3.2 Гэмт хэргийн статистик ба тогтвортой хөгжил.....	64
3.3.3.3 Гэмт хэргийн статистикийн мэдээллийн хамрах хүрээ, нээлттэй байдал.....	65
3.4. Санал, зөвлөмж .....	68
<b>Дөрөвдүгээр бүлэг. Тодорхой төрлийн гэмт хэрэг, гэмт хэргийн зарим онцлог .....</b>	<b>69</b>
4.1.1 Хүнийг алах гэмт хэрэг .....	70
4.1.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг.....	72
4.1.3 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг.....	75
4.1.4 Хүчиндэх гэмт хэрэг .....	78
4.1.5 Хүн худалдаалах гэмт хэрэг.....	81
4.1.6 Хулгайлах гэмт хэрэг.....	82
4.1.7 Дээрэмдэх гэмт хэрэг .....	86
4.1.8 Залилах гэмт хэрэг .....	89
4.1.10 Мөнгө угаах гэмт хэрэг.....	93
4.1.11. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэрэг.....	94
4.1.12 Албан тушаалын эсрэг гэмт хэрэг .....	97
4.1.13 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг .....	102
4.1.14 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг.....	105

4.1.15 Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг .....	107
4.2 Гэмт хэргийн зарим онцлог.....	110
4.2.1 Хүүхэд ба гэмт хэрэг.....	110
4.2.2 Эмэгтэйчүүд ба гэмт хэрэг.....	113
4.2.3 Согтуурал ба гэмт хэрэг.....	116

**Тавдугаар бүлэг. Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг ..... 119**

5.1. Улаанбаатар хот .....	121
5.2. Баянгол дүүрэг .....	124
5.3. Баянзүрх дүүрэг.....	127
5.4. Сонгинохайрхан дүүрэг .....	130
5.5. Сүхбаатар дүүрэг.....	133
5.6. Хан-уул дүүрэг .....	136
5.7. Чингэлтэй дүүрэг .....	139
5.8. Багануур дүүрэг .....	142
5.9. Багахангай, налайх дүүрэг .....	145
5.10. Орон нутаг.....	149
5.11. Архангай аймаг.....	153
5.12. Баян-өлгий аймаг .....	156
5.13. Баянхонгор аймаг.....	159
5.14. Булган аймаг.....	162
5.15. Говь-алтай аймаг.....	165
5.16. Говьсүмбэр аймаг.....	168
5.17. Дархан-Уул аймаг.....	171
5.18. Дорноговь аймаг.....	174
5.19. Дорнод аймаг .....	177
5.20. Дундговь аймаг.....	180
5.21. Завхан аймаг.....	183
5.22. Орхон аймаг.....	186
5.23. Өвөрхангай аймаг.....	189
5.24. Өмнөговь аймаг.....	192
5.25. Сүхбаатар аймаг.....	195
5.26. Сэлэнгэ аймаг.....	198
5.27. Төв аймаг .....	201
5.28. Увс аймаг .....	204
5.29. Ховд аймаг .....	207
5.30. Хөвсгөл аймаг .....	212
5.31. Хэнтий аймаг .....	213
5.32. Бусад нутаг дэвсгэр болон зарим салбар.....	216

**Зургаадугаар бүлэг. Улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр нөлөө .....219**

6.1 Улсын хэмжээний ерөнхий бодлого, үйл ажиллагаа .....	219
6.2 Урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, зарцуулсан төсөв, түүний гүйцэтгэл .....	221
6.3 Урьдчилан сэргийлэх ажилд нэвтрүүлсэн шинэ санаа, инноваци, үр дүн, дэвшилтэт талууд .....	223
6.4 Алдаа, дутагдал, анхаарах асуудлууд.....	227


**Хавсралт .....229**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ


БХЖЭ- Байгаль хамгаалах журмын эсрэг  
ГХ- Гэмт хэрэг  
ГХМБТГ- Гэмт хэрэг, мансуурах бодистой тэмцэх газар  
ГХСОУА- Гэмт хэргийн статистикийн Олон Улсын ангилал  
ГХУСАЗЗ- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл  
ГХЧХС- Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа  
ЕЭЗК- Европын Эдийн засгийн комисс  
МАХН- Монгол ардын хувьсгалт нам  
МБ- Мөрдөн байцаалт  
МУ- Монгол Улс  
НҮБ- Нэгдсэн Үндэстний байгууллага  
ПГ- Прокурорын газар  
ТПГ- Тээврийн прокурорын газар  
ТХЗ- Тогтвортой хөгжлийн зорилго  
ТХҮБ- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал  
ТХХАБ,АЖ-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам  
ТХХАБАЖЭ-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг  
УЕПГ- Улсын ерөнхий прокурорын газар  
ҮСХ- Үндэсний статистикийн хороо  
ХАБТХАЖЭ- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг  
ХБ- Хэрэг бүртгэлт  
ХБОЭ- Хүрээлэн байгаа орчны эсрэг  
ХЗДХЯ- Хууль зүй дотоод хэргийн яам  
ХСИС- Хууль сахиулахын их сургууль  
ЦЕГ- Цагдаагийн ерөнхий газар  
ШШҮХ- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн  
ЭБШХ- Эрүүгийн байцаан шийтгэх хууль  
ЭХ- Эрүүгийн хууль  
ЭХҮ- Эрүүгийн хэрэг үүсгэх  
ЭХХШТХ- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль  
ЭШХХ- Эрдэм шинжилгээ хөгжлийн хүрээлэн



## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, 10000 ХҮНД НОГДОХООР



## ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ, 18 ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ 10000 ХҮНД НОГДОХООР





# 1

## Бүлэг

### ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ<sup>1</sup>

Цагдаагийн байгууллага 2017 онд иргэд, хуулийн этгээдээс 192618 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас 78722 буюу 40.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 113896 буюу 59.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгажээ.

Харин прокурорын байгууллага нь 36574 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6419 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, хяналт тавьж ажилласан бол Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 10390 хэргийг хүлээн авч, 9019 хүнд ял шийтгэл хүлээлгэсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий бүдүүвч



<sup>1</sup> Цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шинжилгээ, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистикийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

## 1.1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн бөгөөд зарим төрлийн гэмт хэрэг буюу өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4,840 (36.3%), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 842 (9.7%), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 189 буюу 49.2% хувиар тус тус өссөн статистик тоон үзүүлэлттэй байна. Гэмт хэрэг өсөхөд шинээр батлагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад ямар шалтгаан, нөхцөл нөлөөлснийг бодитоор тогтоох, үнэлэх шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийлээ<sup>2</sup>.

Гэмт хэргийн өсөлт бууралт, шийдвэрлэлтийг судлах зорилгоор 2016, 2017 он бүтэн жилээр, 2016 оны сүүлийн хагасаас 2017 оны сүүлийн хагас, 2017 оны I улирлаас 2018 оны I улирлыг харьцуулан тус тус харьцуулан судаллаа. Судалгаа явуулахдаа цагдаа, прокурор, шүүхийн хэмжээнд 2016, 2017, 2018 оны гаргасан тайлан, мэдээг нэгтгэж дүгнэсэн юм.

### Гэмт хэргийн тархалт

Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 21947 буюу 68 хувь нь Улаанбаатар хотод, 10273 буюу 31.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Үзүүлэлт	Улсын хэмжээнд		Улаанбаатарт		Орон нутагт	
	2016	2017	2016	2017	2016	2017
Тоо	27167	32259	17909	21947	9222	10273
Өсөлт, бууралт	18.7%		22.5%		11.4%	

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргээс харахад дээрэмдэх гэмт хэрэг 2.6<sup>3</sup> дахин, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 2.3 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2.0 дахин өссөн байна.

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь
		2016	2017		
1	Хүнийг алах	174	189	8.6	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8248	8812	6.8	27.3
3	Хүчиндэх	290	376	29.7	1.2
4	Хулгайлах	9065	12222	34.8	37.9
5	Дээрэмдэх	474	1233	2.6 дахин	3.8
6	Залилах	2165	2996	38.4	9.3
7	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	1449	727	-49.8	2.3
8	ХАБ,ТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг	1783	1525	-14.5	4.7
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	165	330	2.0 дахин	1.0
10	Бусдыг амиа хорлоход хүргэх	206	470	2.3 дахин	1.5
11	Бусад	2826	3010	-6.5	9.3

Хэдийгээр гэмт хэрэг өссөн үзүүлэлттэй байгаа боловч гэмт хэргийн статистик үзүүлэлт, цагдаагийн байгууллагын танилцуулгаас үзвэл гэмт хэргийн шинжтэй тохиолдол бүрийг бүртгэж, шинээр гэмт хэрэгт тооцогдсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хулгайлах, гэмтэл учруулах гэмт хэргийн шинжийг тодорхой болгож, нуугдмал гэмт үйлдлээ ил гаргаж тэмцэж

<sup>2</sup> Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

<sup>3</sup> 2015 онд батлагдсан Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-д 2002 оны Эрүүгийн хуульд байсан Булаах гэмт хэргийг Дээрэмдэх гэмт хэрэгт хамтатган хуульчилсантай холбоотойгоор 2017 онд бүртгэгдсэн Дээрэмдэх гэмт хэргийн тоо ийнхүү өсөлттэй гарахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн.

эхэлсэнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хуулийн шинэчлэлээс хамаарч нуугдмал гэмт хэргийн гаралтыг бодитоор үнэлж, түүнтэй үр дүнтэй тэмцэх бодлого үнэн зөв тодорхойлох боломжийг олгож байгаа нь сайн тал юм.

Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэргийн гаралт нэмэгдсэн харагдаж байгаа нь хэрэг бүртгэлтийн хэргийн тоо нэмэгдсэн болон нуугдмал гэмт явдлыг гэмт хэрэг, зөрчилд тооцсонтой холбоотой байна.

### Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт 18131 хүн холбогдон шалгагдсан бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад 23.8 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоон үзүүлэлт, зарим онцлогийг харуулах статистикийг үзүүлбэл:

№	Үзүүлэлт	2016	2017	Өсөлт, бууралт
1	Нийт шалгагдсан хүн	23805	18131	-23.8 хувь
2	Эрэгтэй	20213	15599	-29.5 хувь
3	Эмэгтэй	3592	2532	-22.8 хувь
4	Хүүхэд	1165	1066	-8.5 хувь

Шалгагдсан нийт 18131 хүний 15599 буюу 86 хувийг эрэгтэй, 2532 буюу 14 хувийг эмэгтэй, 1066 буюу 5.9 хувийг хүүхэд тус тус эзэлж байна. Ийнхүү 32000 орчим гэмт хэрэг бүртгэгдсэн атлаа 18131 хүн холбогдон шалгагдсан нь шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн яллагдагчтай холбоотой зохицуулалтаас болсон байна. Өөрөөр хэлбэл, "сэжигтэн" хэмээх хууль зүйн ойлголт өөрчлөгдөж, хүнийг яллагдагчаар татахын өмнөхөн хийгддэг богино хугацааны ажиллагаа болсонтой холбоотой юм.

### Гэмт хэргийн хохирогч, хохирол

Улсын хэмжээнд 37173 иргэн, 86 хуулийн этгээд хохирсон байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол түүнд хамаарах статистикийг харуулбал:

Хохирогч бүгд		Иргэн		Үүнээс				Хуулийн этгээд		Учирсан хохирол бүгд (сая.төг)		Нөхөн төлүүлсэн (сая.төг)	
2016	2017	2016	2017	Нас барсан		Гэмтсэн		2016	2017	2016	2017	2016	2017
27773	37259	27689	37173	880	1129	11257	10513	84	86	162909.4	198073.2	43964.0	74508.2

Прокурорын байгууллагын мэдээнээс үзвэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 онд **198.1 тэрбум төгрөг**, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ **74.5 тэрбум төгрөг** болж, өмнөх оноос учирсан хохирол 35.2 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 30.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээнээс үзвэл амь хохирсон хүний тоо өмнөх оноос 63 хүнээр буюу 11.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 663 хүн хүнд гэмтэл, 904 хүн хүндэвтэр гэмтэл, 3105 хүн хөнгөн гэмтсэн бөгөөд өнгөрсөн онтой харцуулбал хөнгөн гэмтэл авсан хүний тоо 2.5 дахин өсчээ.

Улсын хэмжээнд 2017 онд шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээ **84.8 тэрбум төгрөг** байна. Үүнээс улсад учирсан хохирол **3.8 тэрбум төгрөг**, аж ахуйн нэгжид учирсан хохирол 11 тэрбум 955.5 сая төгрөг, иргэнд учирсан хохирол 69.3 тэрбум төгрөг байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээг өнгөрсөн онтой харьцуулбал **69.5 тэрбум төгрөгөөр** буюу 5.6 дахин өссөн дүнтэй гарсан байна.

Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршгийг арилгах талаар зохицуулсан Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйл гэмт хэргийн хохирол, хор уршиг, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл болох Гэм буруугаа хүлээсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаархи зүйл, хэсэг заалтууд нь бодитоор хэрэгжиж эхэлсэний эерэг үр дагавар гэж дүгнэж болохоор байна.

Цагдаагийн байгууллагад 2017 онд 1327017 зөрчил бүртгэгдэж, 1289466<sup>4</sup> иргэн, 44 албан тушаалтан, 823 хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан байна<sup>5</sup>.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчил, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааг хүснэгтээр харуулбал:

Улсын хэмжээнд	2016	2017	Өсөлт, бууралтын хувь
Бүртгэгдсэн зөрчил, Үүнээс:	1038050	1327017	27.8
Иргэн	1001379	1289466	28.7
Албан тушаалтан	107	44	-2.4
Хуулийн этгээд	1167	823	-29.4
Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан	1031467	1314831	27.4
Шүүгч шийтгэл оногдуулсан, Үүнээс:	6583	12186	85.1
Торгох (тэрбум төгрөг)	30.6	40.3	31.6
Баривчлах	5380	11345	2.1
Торгож, эрх хасах	30017	25339	-15.5
Согтууруулах ундааны зүйл хэрэглэж саатуулагдсан хүн, Үүнээс:	87357	86497	-0.9
Эмэгтэй	4925	5521	12.1
Хүүхэд	279	271	-2.8
Сайн дурын эмчилгээнд хамрагдсан хүн	755	2668	3.5

### Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралт

Судалгааг Монгол Улсын хэмжээнд сүүлийн 2 жилд гарсан гэмт хэргийн статистик, тоон мэдээлэлд үндэслэв. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны гэмт хэргийн статистик мэдээллээс үзвэл Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш үйлдэгдэн гарсан хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан гэмт хэрэг 2016 оныг 2017 онтой харьцуулахад 18.7 хувиар, 2017 оны эхний улирлыг 2018 оны мөн улирлын байдлаар харьцуулахад 56.5 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Харин гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоон үзүүлэлт өмнөх 3 жилийн дундаж хэмжээнээс нэмэгдээгүй байна. Тухайлбал:

Утга	2016	2016 III-IV улирал	2017	2017 III-IV улирал	2017 I улирал	2018 I улирал
Нийт гэмт хэрэг	27167	32259	13609	30032	6869	10753
Өсөлт, бууралт	+5092 гэмт хэрэг буюу 18.7%-иар өссөн		+6423 гэмт хэрэг буюу 47.2%-иар өссөн		+3884 гэмт хэрэг буюу 56.5%-иар өссөн	

Дээрх хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг өссөн байх бөгөөд Цагдаагийн байгууллага 2017 оны гэмт хэргийн статистик мэдээг шинээр хэрэгжиж эхэлсэн 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 оны Эрүүгийн хууль гэсэн хоёр байдлаар гаргажээ.

Эрүүгийн хууль 2017 оноос (шинэчилсэн найруулга) үйлчилж эхэлснээс өмнө ба хойшх хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн үзүүлэлтийг жил, улирал тус бүрээр харьцуулж үзвэл хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 518-аас 731 гэмт хэргээр буюу 21.2-30 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 62-97 гэмт хэргээр буюу 69 хувиас 2 дахин, хулгайлах гэмт хэрэг 1697-3990 гэмт хэргээр буюу 2 дахин, дээрэмдэх гэмт хэрэг 365-691 гэмт хэргээр буюу 3.2-4 дахин, Залилах гэмт хэрэг 804-941 гэмт хэргээр буюу 86.4 хувиас 2.4 дахин, авлига албан тушаалын гэмт хэрэг болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2-3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Үүнээс үзвэл голчлон үйлдэгдэн гардаг 5 төрлийн гэмт хэргийн өсөлт 2017 болон 2018 оны гэмт хэргийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, бусдын биед

<sup>4</sup> Давхардсан тоогоор буюу нэг хүн хэдэн удаа зөрчил гаргасныг нэгтгэж дүгнэсэн тоон мэдээ болно.

<sup>5</sup> Цаашид зөрчлийн статистикийг цагаан номонд дэлгэрэнгүй оруулж байх нь зүйтэй гэсэн саналтай байна.

гэмтэл учруулах, хулгайлах, дээрэмдэх, хүчиндэх гэмт хэргүүд тухайн онд өссөн нийт гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлжээ.

Мөн дараах 9 төрлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан гэмт хэрэг нийт хэргийн өсөлтөд шууд нөлөөлсөн эсэхийг Прокурорын байгууллагын гэмт хэргийн цахим бүртгэлийн мэдээлэлтэй тулган үзвэл прокурорын бүртгэл мэдээлэл, цахим системд 2018 онд өөрчлөлт орсон, түүнчлэн тоон мэдээ өсөн нэмэгдэх дүнгээр гардаг учир цагдаагийн гэмт хэргийн мэдээтэй харьцуулах, нарийвчилан судлах боломжгүй байв.

Зүйлчлэл	2016 III-IV улирал	2017 III-IV улирал	Өсөлт, бууралт	2017 I улирал	2018 I улирал	Өсөлт, бууралт
11.6.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	3554	4185	<b>21.2%</b>	1763	2281	<b>29.4%</b>
11.7.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		223			106	
12.1.Хүчиндэх	143	240	<b>67.8%</b>	63	125	<b>98.4%</b>
17.1.Хулгайлах	3938	7928	<b>2 дахин</b>	2175	3999	<b>2 дахин</b>
17.2.Дээрэмдэх	316	1007	<b>3.2 дахин</b>	123	488	<b>4 дахин</b>
17.3.Залилах	1089	2030	<b>86.4%</b>	563	1367	<b>2.4 дахин</b>
17.5.Андуурсан илгээмж, алдаатай гүйлгээ, гээгдэл эд зүйл завших		+432			+383	
22 дугаар бүлэг. Авлигын гэмт хэрэг	52	106	<b>2 дахин</b>	27	8	
24 дүгээр бүлэг. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	79	240	<b>3 дахин</b>	48	67	<b>39.6%</b>

Цагдаа, прокурор, шүүхийн гэмт хэргийн статистик болон шийдвэрлэлтийн хувь хэмжээг тооцох аргачлал тус бүртээ өөр, тухайн онд гарсан гэмт хэргийн нөхцлийг цагдаагийн байгууллагын мэдээнд тулгуурлан дүгнэхээр байлаа. Иймд дээрх Цагдаагийн байгууллагын статистик тоо, мэдээ үнэн бодит эсэхийг прокурор болон шүүхээс гаргасан статистик тоо мэдээллийн боломжит үзүүлэлтүүдтэй харьцуулан тулгаж судлахыг эрмэлзлээ.

### Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл

Цагдаагийн байгууллага нь 2014-2017 онд жилд дунджаар 94990 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 65 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэр гаргуулахаар прокурорт шилжүүлсэн тоон үзүүлэлттэй байв.

Гэмт хэргийн статистикийг бүртгэлийн эхний үе шатнаас буюу цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтээс үзвэл эдийн засаг, нийгэм, хувь хүн болон бусад хүчин зүйлээс гэмт хэрэг бодитоор өссөн байж болох шалтгаан, нөхцөл ажиглагдаагүй бөгөөд зарим гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн статистик мэдээлээс үзвэл 2014-2017 онд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн дотор бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл нийт мэдээллийн 28 орчим хувийг эзэлж байжээ.

Үзүүлэлт	2014	2015	2016	2017
Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	93984	96661	94324	78050
Үүнээс: Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн тоо	63245	65885	65709	44393
Эзлэх хувь	67%	68%	70%	57%
Хулгайлах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	20662	23716	27070	28991
Эзлэх хувь	22%	24,5%	28,6%	37%

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг хэрэг бүртгэлтэд тооцсон бөгөөд цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик үзүүлэлт гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзжээ. Гэтэл хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд шалгах явцад тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй байх, эсхүл зөрчил байх боломжтой тул бүхэлд гэмт хэрэг гэж үзэх нь учиртай дутагдалтай юм.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл		ЭХҮ-ээс татгалзсан	
<b>2002 оны ЭБШХ-иар хуулиар шийдвэрлэсэн</b>			
2016 I-VI улирал 99455	2017 I-VI улирал 45177	2016 I-VI улирал 65669	2017 I-VI улирал 28710
		<b>65%</b>	
<b>2017 оны ЭХХШХ-иар хуулиар шийдвэрлэсэн</b>		<b>Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан</b>	<b>Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан</b>
2017 III-IV улирал 40104	2017 1-5 сар хүртэл 34588	15179+10848	7406+6956
		<b>34.5%</b>	<b>19%</b>

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаар “мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэрэг бүртгэлт”<sup>6</sup> гэж томъёолсон боловч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хуульд заасан 5 хоногт шалгаад үргэлжүүлэн “хэрэг бүртгэлтийн хэрэг нээж” шалгасныг “гэмт хэрэг гарсан” гэж үзэн гэмт хэргийн статистикт бүртгэж, үзүүлэлтийг гаргажээ. Өнөөгийн байдлаар прокурорын байгууллагын хэмжээнд хэрэг бүртгэлтийн хэргийг гэмт хэрэг гарсан гэж шууд үзэх бус харин гэмт гарсан эсэхийг шалгаж тогтоох ажиллагаа гэж ойлгож, хяналт тавьж байгаа болно.

Энэ нь дээр дурдсан хулгайлах, дээрэмдэх болон хүний биед хөнгөн хохирол учруулах хэргүүд өссөн үзүүлэлтэй гарах нэг шалтгаан болсон гэж үзэж болох юм.

Судалгааны дагуу Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхлэхээс өмнө болон хэрэгжиж эхэлснээс хойш хагас жилийн байдлыг сар, улирал байдлаар тус тус харьцуулж үзвэл гэмт хэргийн талаарх гомдлын тоо харьцангуй тогтвортой буюу 500-1000 гомдол, мэдээллээр өссөн дүнтэй, харин хагас жил, шинэ хууль хэрэгжиж эхлэхээс хойшхи 10 сарын байдлаар харьцуулж<sup>7</sup> үзвэл цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас гаргасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо буурсан байна.


Хуучин хуулиар	Гомдол, мэдээлэл	ЭХҮ-ээс татгалзсан		Эрүүгийн хэрэг үүсгэсэн	Ажиллагаанд байгаа	Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн
2016	99455	65669		29607	4425	5985
		<b>66%</b>		<b>30%</b>	<b>10.7%</b>	<b>14.4%</b>
2017 I-VI	45177	28710		14272	4225	4420
Эзлэх хувь		<b>63.6%</b>		<b>31.5%</b>	<b>19%</b>	<b>20%</b>
Шинэ хуулиар	Гомдол, мэдээлэл	ХБ-ийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан	ЭХҮ-гэж мөрдөн байцаалт явуулсан	Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд байгаа	
2016 III-IV улирал	40104	15179	7406	1095	1674	5715
		<b>38%</b>	<b>18.4%</b>			
2018 V сар	34588	10848	6956	639	1891	5764
Эзлэх хувь		<b>31.3%</b>	<b>20%</b>			

<sup>6</sup> ЭХХШТХ-ийн 30.1 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт

<sup>7</sup> Энэ судалгааг хийх үеийн тоон мэдээллийг ашигласан болно.



Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас шинээр батлагдсан Эрүүгийн хууль, тогтоомж мөрдөгдөж эхэлсэн тохиолдолд МУ-д бүртгэгдэх гэмт хэрэг жилд дунджаар 10000 орчмоор өсөх магадлал, тооцооллыг гаргаж, ХЗДХЯ-нд танилцуулж байжээ. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл шалгах ажиллагаа хэрэг бүртгэлт гэдэг ойлголтод тооцогдсон, мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай ойлголт шинэ хуулиар өөрчлөгдөж, хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах гэсэн 2 өөр шийдвэр гаргах болсонтой холбоотойгоор гэмт хэргийн статистик үзүүлэлт өсөхөд шууд нөлөөлөхөөр байсан.<sup>8</sup>



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш өмнөх ба дараах үеийг 2016.07.01-нээс 2017.05.31-ийг хүртэл, 2017.07.01-ээс 2018.05.31-ийг хүртэлх байдлаар харьцуулан үзвэл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо 94731-ээс 67087 болж 29.2 хувиар буурсан байна.

Дээрх хугацаанд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтын дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тоотой нэгтгэн харьцуулж үзвэл, 65.2 хувиас 53.6 хүртэл хувиар буурсан байна.

2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 67087 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн 38947 буюу 58 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 26561 буюу 38 орчим хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлж, 2689 тохиолдол буюу 4 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, үлдэх 2 хувийг харьяаллын дагуу шилжүүлжээ.

Судалгааны явцад хийсэн бүлгийн ярилцлагаас<sup>9</sup> үзвэл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах 5 хоногт бүрэн гүйцэт ажиллагаа хийх боломжгүй, зөвхөн үйл баримтыг үнэлэх, үндэслэл бүхий сэжиг байгаа эсэхийг тогтоож гэмт хэргийн шинжтэй л бол тохиолдол бүрт хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, шалгаж байгаагаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан гэмт хэрэг 20-30 хувиар өссөн дүн мэдээ гарч байгаа бөгөөд цаашид “гэмт хэрэг үйлдэгдэн гарсан болохыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн үеэс биш эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулсан тоогоор тооцдог болох нь зүйтэй” гэсэн хувь судлаачийн санал байна. Өөрөөр хэлбэл, шинээр хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг хэрэг бүртгэлтэд хамааруулахаар заасан.

<sup>8</sup> “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” судалгааны тайлангаас, ХСИС.2012 он

<sup>9</sup> Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн мөрдөн байцаагч нартай сургалтын явцад хийсэн ярилцлага

### Гэмт хэргийн өсөлтөнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас шалтгаалсан зарим хүчин зүйл

Монгол Улсад 2014-2017 оны байдлаар “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэрэг жилд дунджаар 10000 орчим бүртгэгдэж, нийт хэргийн 32.4 хувийг эзэлж байжээ.

Үзүүлэлт	2014	2015	2016	2017
Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	27318	27757	27167	32259
Бусдын эд хөрөнгийг хулгайлах	8424	9169	9065	11771
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	<b>30.8%</b>	<b>33.0%</b>	<b>33.4%</b>	<b>36.4%</b>
Бусдын эд хөрөнгийг булаах	245	216	176	56
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	0.9%	0.8%	0.6%	0.1%
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг	1076	1356	1449	1294
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	<b>3.9%</b>	<b>4.9%</b>	<b>5.3%</b>	<b>4.7%</b>

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн хөтлөх журам”-ын код 701-ийн 701.7.1-д Эрүүгийн хэргийн дугаар авах гэсэн хэсэгт: (ЦЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 24-ний А/301 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан)

- “Үйлдэл бүр дээр эрүүгийн хэргийн дугаарыг шинээр авна”... гэж заасан заалтыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн дугаар авахдаа хамааруулан тооцож байгаагаас шалтгаалан олон үйлдэлтэй хулгайлах, дээрэмдэх зэрэг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэсэн хэргийн тоо өсчээ.
- Мөн уг журмын “Хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн хэргийн бүртгэл” маягыг хөтөлнө. гэж заасан боловч хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс хаасан, хэрэгсэхгүй болгосон, мөн түүнээс эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалт явуулсан гэж ялгах боломжгүй учраас гэмт хэргийн статистик үзүүлэлт мөн өсөхөд нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Үзүүлэлт	2016 III-IV улирал	2017 III-IV улирал
Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	13609	20032
Бусдын эд хөрөнгийг хулгайлах	3938	7928
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	29.1%	39.5%
Бусдын эд хөрөнгийг булаах (дээрэмдэх)	316	1007
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	2.3%	5%
Гэр бүлийн хүчирхийллийн үйлдэх гэмт хэрэг		223
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь		1%

Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцсон, үйлдлийн шинжийг нэгтгэсэн гэмт хэргийн талаар

Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд 26 төрлийн гэмт хэргийн шинжийг шинээр томъёолж, нийт гэмт хэргийн 70 гэмт хэргийн шинжийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар тусгажээ. Үүнд:

Эрүүгийн хуулийн 11.7-д заасан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 223, 17.5-д заасан Андуурсан илгээмж, алдаатай гүйлгээ, гээгдэл эд зүйл завших гэмт хэрэг 432, Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 240 тус тус бүртгэгдсэн нь “тухайн жилд дунджаар 1000 орчим хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг нэмэгдсэнийг” харуулж байна.

Мөн Эрүүгийн хуульд зарим гэмт хэргийн шинжийг нэгтгэн шинээр томъёолсонтой холбоотой өссөн дүнтэй гарсан гэж үзэхээр байна. Тухайлбал: 2002 оны Эрүүгийн хуулиар тодорхойлж байсан “булаах гэмт хэрэг” болон “дээрэмдэх” гэмт хэргийн шинжийг 2015 оны Эрүүгийн хуулиар “Дээрэмдэх” гэсэн нэг гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинж болгож тодорхойлсон учир тухайн гэмт хэрэг 2017 онд 3-4 дахин өссөн үзүүлэлттэй гарчээ.

Танхайрах үйлдлийг гэмт хэргээс хасч зөвхөн Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцсоноос хамааран гэмт хэргийн тоо 500-600 гэмт хэргээр багассан боловч түүнтэй үйлдлийн хувьд ижилгэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгддэг зарим гэмт хэрэг өсчээ. Тухайлбал, Улсын хэмжээнд 2014 оноос 2016 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 4497 бүртгэгдэж (жилд дунджаар 1499) нийт зөрчлийн 0.1 хувийг эзэлж байв. Энэ үйлдлүүдийн дийлэнх нь Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг болон Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг болж бүртгэгдэж эхэлсэн байна.

Үзүүлэлт	2014	2015	2016	Нийт	3 жилийн дундаж
Бүртгэгдсэн захиргааны зөрчил	681222	1423088	1038050	3142360	1047453
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил	1178	1453	1866	4497	1499
Эзлэх хувь	0.2	0.1	0.2	0.1	0.1

Үүнээс гадна 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш хагас жилийн байдлаар нийт 500 мянган зөрчил бүртгэгдээд байгаа нь урьд бүртгэж байсан зөрчлийн тооноос даруй 10 дахин нэмэгдсэн үзүүлэлтэй байгаа бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа зөрчлийн тоог бодитой хянаж эхэлсэн, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулах зөрчлийн хэрэг бүтгэлтэд хяналт тавьж, бүртгэж эхэлсэнтэй холбоотой юм.

Цагдаагийн байгууллагын бүтцэд 2018 оны 4 дүгээр сараас эхлэн “Хэрэг бүртгэх алба”-ыг шинээр байгуулсан ба энэ алба цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсанаас хойш 2015 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг буюу “Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийг харьяалан шалгаж эхэлсэн. Уг албыг байгуулснаас хойш тухайн төрлийн гэмт хэргийн бүртгэл нэмэгдэж, илрүүлэлт өссөн дүн мэдээ 2018 оны эхний улирлын байдлаар ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн өсөлт бууралттай холбоотой мэдээ нь цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанаас хамаарч байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн бүлгийг 2015 оны Эрүүгийн хуульд шинээр томъёолж хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар тусгажээ. 2002 оны Эрүүгийн хуульд байсан гэмт хэргийн шинж дээр нэмж 6 хэргийг тусгасан ба шинэ хуулийн үйлчлэлээс хойш Авлигатай тэмцэх газраас шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн тоо 2 дахин өсчээ.

Авлигатай тэмцэх газар 2017 онд гэмт хэргийн шинжтэй 658 гомдол, мэдээллийг хүлээн авсан бөгөөд төрлөөр нь авч үзвэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан 337, хахууль авсан 63, хахууль өгсөн 76, албан тушаалтан өмч хөрөнгө завшсан 82, хөрөнгө нуусан буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн 51, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 48, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан 50, бусад 6 байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 174 буюу 26.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх (эрүүгийн хэрэг үүсгэх), 375 буюу 58 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах (эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах), 93 буюу 14.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай харьяа прокурор шилжүүлэн шийдвэрлэж одоо 16 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна. Хуульд заасан харьяаллын 1301 үйлдэлтэй, 654 холбогдогчтой, 427 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.<sup>10</sup> Гэтэл хамтран ажиллах журмын дагуу АТГ нь цагдаагийн байгууллагын мэдээллийн санд гэмт хэргийн талаарх холбогдох мэдээллийг оруулж, статистикийн мэдээлэлд тусгуулдаг бөгөөд ЦЕГ-аас эрхлэн гаргасан улсын хэмжээний гэмт хэргийн статистикийн мэдээлэлд АТГ нь 2017 онд гэмт хэрэгт холбогдсон 14 хүн, бүртгэсэн 184 гэмт хэрэг байгаа статистик үзүүлэлтээс<sup>11</sup> харахад АТГ-ын статистикийн мэдээлэл улсын хэмжээний гэмт хэргийн нэгдсэн статистикийн мэдээнд бүрэн тусаагүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

<sup>10</sup> АТГ. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдал-2017

<sup>11</sup> ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистикийн мэдээлэл

## 1.2 ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурорын байгууллагын бүртгэл, статистикийн үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалууд хэд хэдэн удаа өөрчлөгдөж цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээтэй тулгаж үзэхэд зарим үзүүлэлт зөрөх байдал ажиглагдаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар эрүүгийн хэрэг түдгэлзүүлэх тухай зохицуулалт өөрчлөгдсөнөөс шалтгаалж түдгэлзүүлсэн хэргийн үзүүлэлт эрс багасаж, 2016 онд 5503 хэргийг түдгэлзүүлж байсан бол 2017 онд 77 хэргийг түдгэлзүүлжээ. Хуулийн зохицуулалтаар хэргийг түдгэлзүүлэхгүйгээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаанд нь хэрэг бүртгэлтээр шалгадаг болжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлнээс хойш хэрэг бүртгэлтийн хэрэг татгалзаж хаах (хуучин хуулиар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж хаах) тохиолдол 30 хүртэл хувиар буурч, үүнтэй урвуу хамаарлаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээх шалгасан үзүүлэлт 30 хувиар өссөн байна. хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо 10 хүртэл хувиар буюу 1092 хэргээр нэмэгджээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байсан хохирогчтой эвлэрснээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байсан зохицуулалт өөрчлөгдсөнөөр шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо нэмэгдсэн байна. Тухайлбал, 2016 онд прокуророос 21712 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан бол 2017 онд 612 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн илрүүлэлтийн талаар тоон мэдээнээс харвал илэрсэн гэмт хэрэг 8856, прокурорын цахим бүртгэлээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийн тоо 8864 буюу 8 хэргээр зөрүүтэй байгаа статистик үзүүлэлттэй байна.

2017 онд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	ЭХХШТХ-н 30.15-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар	5395
	ЭХХШТХ-н 30.17-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар	1278
Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг		8864

Прокурорын байгууллагын хянасан, бүртгэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн гэмт хэргийн тоон мэдээ нь Цагдаагийн байгууллагын бүртгэсэн гэмт хэргийн тоон мэдээтэй зөрүүтэй гарч байгаа нь прокурорын байгууллагын гэмт хэргийн талаарх гаргаж байгаа тоон мэдээ, статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал нь өөр, өсөн нэмэгдэх үзүүлэлтээр тус тусын үндсэн ажлын үзүүлэлтээр болон шийдвэр гаргалтын байдал, шийдвэрээр бүртгэдэг, зарим үйлдлийг, өргөдлийг нэгтгэж шалгах болон тайлан мэдээ гаргах хугацаа зөрдөгөөс шалтгаалсан гэж үзэхээр байна.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурорын байгууллагын бүртгэл, статистикийн үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалууд хэд, хэдэн удаа өөрчлөгдөж цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээтэй тулгаж үзэхэд хүндрэл бэрхшээлтэй байв.

Тухайлбал, прокурорын байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэлээс 2016 онд хэрэг бүртгэлт явуулсан хэрэг, мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн тоог үзвэл 41130 байх ба энэ өмнөх оны үлдэгдэл болон тухайн онд шалгагдан, хянаж байгаа нийт эрүүгийн хэргийн нийт тоог хамарчээ.

Үзүүлэлт	Цагдаагийн байгууллага	Авлигатай тэмцэх газар	ТЕГ-ын МБА
Өмнөх оны тайлангийн үлдэгдэл хэрэг	2010	70	19
Урьд оны хэргийг сэргээж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг, Үүнээс:			
Түдгэлзүүлснээс	5858	11	11
Хэрэгсэхгүй болгосноос	240	6	
Өмнөх онд шүүхэд шилжүүлсэн хэргээс прокурорт буцааж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг	367	8	
Тайлангийн хугацаанд эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг	29654	104	54
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг	41130	84	84

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх гомдлын тоо 94324 гэж гарсан бол прокурорын байгууллагын тоон мэдээгээр 94213, үүнээс ЭХҮ-гээс татгалзсан тохиолдол цагдаагийн байгууллагын мэдээгээр 65709, прокурорын байгууллагын тоон мэдээгээр 65293 зэргээр зөрүүтэй гарсан байна. Энэ нь гэмт хэргийн үйлдлийн тоо, эсхүл хэдэн өргөдөл гомдлыг нэгтгэж шалгасан байдал, мөн мөрдөгчөөс ЭХҮ-гэж татгалзах саналтай ирүүлснийг үндэслэлгүй гэж үзэж буцаасан зэргээс хамаараад прокурорын шийдвэр гаргасан статистик үзүүлэлтээс шалтгаалж зөрүүтэй гарч, өөрчлөгдөхөд хүргэдэг байна.

Үзүүлэлт	2016	Эзлэх хувь	2017 I-II улирал	
ГХ-ийн талаарх гомдол мэдээллийн тоо	99455		45177	<b>63.6%</b>
<b>ГХТГМ-ийн шийдвэрлэлт, Үүнээс:</b>				
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн	65669	<b>66%</b>	28710	<b>31.5%</b>
Эрүүгийн хэрэг үүсгэсэн	29607	<b>30%</b>	14272	
Харьяаллын дагуу шилжүүлсэн	1001		617	
<b>Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, Үүнээс:</b>				
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан	41413		22468	
ХБ, МБ-ыг түдгэлзүүлсэн	5503	<b>13.2%</b>	3218	<b>14.3%</b>
Хэрэгсэхгүй болгосон	21712	<b>52.4%</b>	8841	<b>39.3%</b>
Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн	5985	<b>14.4%</b>	4420	<b>20%</b>
Ажиллагаанд байгаа	4425	<b>10.7%</b>	4225	<b>19%</b>

Үзүүлэлт	2017 III-IV улирал		2018 I-V сар	
ГХ-ийн талаарх гомдол мэдээллийн тоо	40104		34588	
<b>ГХТГМ-ийн шийдвэрлэлт, Үүнээс:</b>				
Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	15179	<b>38%</b>	10848	<b>31.3%</b>
Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	21979		21841	
Хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан	7406	<b>18.4%</b>	6956	<b>20%</b>
ЭХҮ-гэж мөрдөн байцаалт явуулсан	1095		639	
Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд байгаа	45252		31893	
<b>Эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалт явуулснаас</b>				
Ял сонгож яллагдагчаар татсан	10364		10197	
Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн	77		85	
Ажиллагаанд шалгаж байгаа	1674		1891	
Яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн	5715		5764	

Прокурорын байгууллагын хянасан, бүртгэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн гэмт хэргийн тоон мэдээ нь цагдаагийн байгууллагын бүртгэсэн гэмт хэргийн тоон мэдээтэй зөрүүтэй гарч байгаа нь:

- Цагдаагийн, Прокурорын байгууллагын гэмт хэргийн талаар гаргаж байгаа тоон мэдээ, статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал өөр өөр байдагтай холбоотой. Тухайлбал, цагдаагийн байгууллагаас анх бүртгэсэн хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нэгтгэсэн, тусгаарласан, хэрэг бүртгэлтийн хэрэг гэмт хэргийн шинжгүй гэж үзэж хаасан зэргийг мэдээнд тусгадаггүйгээс өөр хоорондоо зөрдөг байна.
- Тус тусын үндсэн ажил дүгнэх үзүүлэлт болон гаргасан шийдвэрээр бүртгэдэг. Тухайлбал, Цагдаагийн байгууллага гэмт хэргийн шинжгүй гэж үзэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тохиолдлыг гэмт хэргийн шинжгүй гэж хааж нийт гэмт хэргээс хасч бүртгэдэг байхад дээрх тоо мэдээ нь прокурорын хяналтын явцад гаргасан шийдвэрээс хамаарч өөрчлөгддөг. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага нь мөрдөгч, хэрэг бүртгэгчийн гаргадаг шийдвэрийн хэлбэрээс хамаарч бүртгэлээ хийдэг.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад зарим үйлдлийг, эсхүл гэмт хэргийн шинжтэй өргөдлийг нэгтгэж шалгасан тохиолдлыг прокурорын байгууллагын тоо мэдээнд тусгадаг. Мөн тайлан мэдээ гаргах хугацаа зөрдөгөөс тоон үзүүлэлт зөрөхөд хүргэдэг. Тухайлбал; цагдаагийн байгууллага сар болгоны 25-нд гаргадаг бол прокурорын байгууллага тухайн сарын 1-нд багтаж тоо, мэдээгээ гаргадаг.
- Прокурорын байгууллага нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийг нэг бүрчлэн тулгаж Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр мэдээ гаргадаггүй бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэсэн, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хаасан, яллах дүгнэлт үйлдсэн зэргээр прокурорын шийдвэр гаргалтын хэлбэрээр мэдээг гаргадаг.
- Мөн 2002 оноос өмнө хэрэгжиж ЭБШХ-д хохирогчтой эвлэрснээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байсан заалтыг өөрчилж, нотлогдсон гэмт хэргийг заавал шүүхээр шийдвэрлэж гэм буруу, хохирлын асуудлыг эцэслэн шийдвэрлэж байна. Тухайлбал, 2016 онд прокуророос 21712 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан бол 2017 онд 612 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэн, 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш бүх эрүүгийн хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж байна. Иймээс Эрүүгийн шүүхийн ачаалал 3 дахин нэмэгдсэн тоон мэдээ гарч байна гэж дүгнэж болох юм.

### 1.3 ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Анхан шатны шүүх 2017 онд эрүүгийн 8839 хэрэг шийдвэрлэж, 12675 зөрчил, зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулжээ. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оны мөн үеэс 53.4%-иар өссөн дүнтэй гарсан гэмт хэргийн статистик үзүүлэлтэй хамааралгүй байх бөгөөд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулж байсан хөнгөн гэмт хэргийн хохирогчтой эвлэрснээр хэрэгсэхгүй болгохтой холбоотой зохицуулалт өөрчлөгдөж, нотлогдсон бүх эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгддэг болсонтой холбоотой байна. Тухайлбал:

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр ял шийтгүүлэгчдийн тоо 37.4 хувиар өссөн байна.

Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргээс дараах төрлийн гэмт хэрэг өссөн байна. Тодруулбал, залилах, хүнийг алах, хулгайлах, дээрэмдэх гэмт хэрэг их хэмжээгээр өссөн дүнтэй байна.

- хүнийг алах гэмт хэрэг 44 хэргээр буюу 28.9 хувиар,
- хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг 23 хэргээр буюу 7.3 хувиар,
- хулгайлах гэмт хэрэг 261 хэргээр буюу 22.6 хувиар,

- дээрэмдэх гэмт хэрэг 32 хэргээр буюу 20.9 хувиар,
- улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 33 хэргээр буюу 2.4 дахин,
- авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 97 хэргээр буюу 15.3 хувиар,
- залилах гэмт хэрэг 130 хэргээр буюу 90.9 хувиар,
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 11 хэргээр буюу 4.9 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүн шүүхээр ял шийтгүүлж буй нөхцөл байдлыг судлан үзвэл хорих ял оногдуулах, түүнийг биечлэн эдлүүлэх үзүүлэлт 3 дахин багассан ба энэ нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, ял оногдуулахгүйгээр тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх зэрэг Эрүүгийн хуулийн 6.7, 7.1 дүгээр зүйлүүдэд заасан ялын уян хатан зохицуулалт, хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэж эхэлсэнтэй холбоотой байна. Тодруулж үзвэл, 2016 онд анхан шатны шүүхээр 4267 хүнд хорих ял оногдуулж шийдвэрлэж байсан бол 2017 онд анхан шатны 1314 хэрэгт хорих ял оногдуулж, хорих ял оногдуулахгүйгээр 639 хүнийг тэнсэж, ял оногдуулахгүйгээр 370 хүнийг тэнсэж, албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргажээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15 хувь буюу нийт 30 гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар заасан ба нийт оногдуулж буй ялын 1/3-ийг тэнсэж, 1/3-т хорихоос өөр төрлийн ял оногдуулж шийдвэрлэжээ.

Харин олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг 162 хэргээр буюу 29.9 хувиар, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 1 хэргээр буюу 50 хувиар тус тус буурсан байна. Шүүхийн энэхүү статистик үзүүлэлт нь өссөн зарим гэмт хэргийн өсөлтийн бодит илрэл байж болох талтай байна.

## ДҮГНЭЛТ

Гэмт хэргийн өсөлт, бууралтын шалтгаан нөхцөл болон эрүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгаагаар дараах дүгнэлтийг хийж болохоор байна:

- Монгол Улсад 2017 онд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан 32259 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн дүнтэй гарсан байна.
- Судалгаагаар Эрүүгийн хуульд шинэчлэн томъёолж тусгагдсан 26 гэмт хэрэг нь нийт өссөн гэмт хэргийн 20 хувийг, мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 2.8 хувийг эзэлж байна.
- Шүүхийн статистик, мэдээгээр олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг, эдийн засгийн эсрэг гэмт хэрэг тус тус өссөн нь бодит үзүүлэлт байж болохоор байна. Энэ нь нийт өссөн гэмт хэргийн 2 орчим хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, дээр дурдсаны дагуу буурсан эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэдэг байсан 30% гаруй хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаж байгаагаас гэмт хэргийн тоон үзүүлэлт өссөн дүн гарахад шууд нөлөөлсөн байна гэж үзэх үндэслэлтэй юм.
- Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо өссөн дүнгүй, зарим улирлын байдлаар тогтмол, харин хагас жил, сүүлийн 10 сарын байдлаар харьцуулж үзвэл буурчээ.
- Бүртгэгдсэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэрэг өссөн нь тухайн болсон үйл баримт, хүлээн авсан гомдол, мэдээллийг шалгаж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгадаг болсонтой холбоотой байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаас хамаарч хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, зөрчил гэж үзэн харьяаллын дагуу шилжүүлэх болсон тул өмнө байсан гэмт хэргээс өссөн гэж дүгнэхтэй холбон үзвэл зүйтэй. Жишээлбэл: Нийт гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн дийлэнх хувь

буюу 36-40 хувийг хулгайлах хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэрэг эзэлж байсан ба 300.000 төгрөгийн хохирол учирсан тохиолдолд (хуучин хуулиар 240.000 төгрөг байсан) гэмт хэргийн шинжийг хангахаар заасан.


- Хулгайлах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хуульд заасан 5 хоногийн дотор үнэлгээ хийлгэх, тодорхой ажиллагаа явуулж шалгах хугацаа хязгаарлагдмал байгаа тул хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаад хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, зөрчил гэж үзэн зөрчлийн хэрэг бүртгэлт рүү шилжүүлэх шийдвэр гаргасан гэж үзэхээр байна. Учир нь 2017 онд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэрэг өссөн гол шалтгааны нэг нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах хугацаа өөрчлөгдсөн явдал юм. Зөрчлийн тухай хуулиар гэмт хэргээс зөрчилд, зөрчлөөс гэмт хэрэгт тооцон бүртгэгдэж байгаа тоон үзүүлэлтийг гаргах, хянаж харьцуулан судлах бололцоогүй байна.
- Мөн зарим гэмт хэргийн шинжийг нэгтгэснээс тухайлбал булаах, дээрэмдэх гэмт хэргийн үйлдлийн шинжийг нэг гэмт хэргийн зүйлчлэлд оруулан дүгнэж эхэлсэн тул уг гэмт хэрэг 3 дахин өссөн дүнтэй гарч, алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, мал завших гэсэн гэмт хэргүүд шинээр Эрүүгийн хуульд нэмэгджээ.
- Прокурорын байгууллагын гэмт хэргийн бүртгэл мэдээллийн систем нь өсөн нэмэгдэх дүнгээр гардаг, бүртгэх аргачлал өөр, өмнөх оны үлдэгдэл хэрэг зэрэг прокурорын хяналтын ажлын төрлөөр гаргадаг учир цагдаагийн байгууллагын тоон мэдээтэй тулгах, түүнийг хянах бололцоогүй байв. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн талаарх гомдлын тоо, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан, хэрэг бүртгэлтийн хэрэг хэрэгсэхгүй болгосон гэх шийдвэрүүдийн тулгахад зөрүүтэй мэдээ гарч байна.
- Энэ нь Прокурорын байгууллагаас хяналт тавьж шийдвэр гаргасан, хянасан, бүртгэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн гэмт хэргийн тоон мэдээ нь Цагдаагийн байгууллагын бүртгэсэн гэмт хэргийн тоон мэдээтэй зөрүүтэй гарч байгаа нь прокурорын байгууллагын гаргаж байгаа тоон мэдээ, статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал нь өөр, өсөн нэмэгдэх үзүүлэлтээр тус тусын үндсэн ажлын үзүүлэлтээр болон шийдвэр гаргалтын байдал, шийдвэрээр бүртгэдэг, зарим үйлдлийг, өргөдлийг нэгтгэж шалгах мөн тайлан мэдээ гаргах хугацаа зөрдөгөөс шалтгаалсан гэж үзэхээр байна.
- Цаашид хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн систем боловсронгуй болгон хөгжүүлснээр цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын статистикийн мэдээллийн үзүүлэлтийг харьцуулан ашиглах, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх боломж бүрдэх юм. Эдгээр тоон мэдээллийн үндсэн дээр гэмт хэрэгтэй тэмцэх, зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар тэдгээрээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх боломжтой болно хэмээн дүгнэж байна.



## МОНГОЛ УЛС ДАХЬ НУУГДМАЛ ГЭМТ ЯВДЛЫН ТҮВШИНГ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЯВДЛЫН СУДАЛГААГААР ТООЦСОН НЬ<sup>1</sup>

Гэмт хэргийн индекс гаргадаг Олон Улсын байгууллагын судалгаагаар 2016 онд Монгол Улс дахь иргэдийн аюулгүй байдлын түвшин 42.2 хувь, иргэд гэмт хэрэгт өртөх эрсдэл буюу гэмт хэргийн түвшин **57.8** хувьтай байгаа нь дэлхийн 118 улсаас 23 дугаарт байрт орж байсан бол 2017 оны эцсийн байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 32.4 хувь, гэмт хэргийн түвшин **67.6** хувьтай болж өмнөх жилтэй харьцуулахад нөхцөл байдал хүндэрч 12 дугаар байрт оржээ.

### Улс орнуудын гэмт хэргийн индекс, 2017



Эх сурвалж: <https://www.numbeo.com/crime>

<sup>1</sup> Энэхүү бүлгийг хууль зүйн доктор (Ph.D) Б.Энхболд хариуцан гүйцэтгэв.

## НЭГ. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ТҮВШИНГ СУДЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Гэмт хэргийн индекс гаргадаг Олон Улсын байгууллагын судалгаагаар 2016 онд Монгол Улс дахь иргэдийн аюулгүй байдлын түвшин 42.2 хувь, иргэд гэмт хэрэгт өртөх эрсдэл буюу гэмт хэргийн түвшин 57.6 хувьтай байгаа нь дэлхийн 118 улсаас 23 дугаарт байрт орж байсан бол 2017 оны эцсийн байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 32.8 хувь, гэмт хэргийн түвшин 66.6 хувьтай болж өмнөх жилтэй харьцуулахад нөхцөл байдал хүндэрч 12 дугаар байрт оржээ.

Харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд Монголчуудын 71.1 хувь нь ойрын 3 жилийн хугацаанд гэмт хэрэг өснө гэж санаа зовниж байгаа бол эд хөрөнгөө хулгайд алдана, бусдын халдлагад өртөнө гэхээс 64.8 хувь нь түгшиж байна гэжээ<sup>1</sup>.

Дээрх судалгааны дүнгээс иргэдийн аюулгүй байдлыг хангах шаардлага зүй ёсоор гарч байгаа ба үүнд Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлж, нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцох шаардлага урган гарч байна.

Судалгааны ажлын зорилго нь Монгол Улс дахь нуугдмал гэмт хэргийн түвшинг хохирогчоор дамжуулан тооцоход оршино.

### ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

#### Түүвэрлэлтийн техник

Хоёр шатанд энгийн санамсаргүй түүврийн аргыг түүврийн загварт хэрэглэсэн. Түүвэрлэлтийн эхний шатанд хүн амынх нь тоотой шууд хамааралтайгаар Улаанбаатар хотын 9 дүүргээс 8 дүүргийг, 21 аймгаас 14 аймгийг сонгон авсан. Түүвэрлэлтийн хоёр дахь шатанд төлөөлөх чадварыг хангах үүднээс дүүрэг тус бүрээс дунджаар 66 иргэн, аймаг тус бүрээс дунджаар 65 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар тус тус сонгосон болно.

Түүвэр олонлогийн хэмжээг түүврийн зайлшгүй хэрэгцээт тоог тодорхойлох хувийн жингийн аргаар дараах томъёоны тусламжтай тодорхойлов. Үүнд:

$$n = QP \left( \frac{Z_{(1-\alpha/2)}}{e^2} \right)^2 ;$$

$n$  - Түүврийн зайлшгүй хэрэгцээт тоо

$e$  - Түүврийн алдаа буюу байж болох алдааны түвшин

$P$  - 17-с дээш насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин

$Z_{(1-\alpha/2)}$  - Хүсэж буй итгэлтэй түвшин дэх статистик хэвийн тархалтын утга

Хүснэгт 1. Нийт хүн амд 17-с дээш насны хүн амын эзлэх хувь, 2017

Байршил	Нийт хүн ам		17-с дээш насны хүн ам	
		Хувийн жин		Хувийн жин
Улаанбаатар хот	1380792	54.9	930166	67.4
Хөдөө	1682776	45.1	1103025	65.7
Улсын дүн	3063568	100	2033191	66.7

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), ҮСХ, 2017

Хүснэгт 1-ийн үзүүлэлтүүдийг ашиглаад дээрх томъёоллын дагуу түүврийнхээ хэмжээг тодорхойлохын тулд эхлээд томъёонд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлов.

- $z$ -ийн 99.9 хувийн ач холбогдлын түвшин дэх  $t$ - статистикийн тархалтын утга 3.29

<sup>1</sup> "Монгол Улс дахь гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа-2017" ХСИС, УБ., 2018.

- Р-17-с дээш насны хүн амын хувийн жин улсын дүнгээр 66.7 %
- е-таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авдаг бөгөөд практикт 5-15 хувийн алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд харьцангуй алдаа 5%)

Хүснэгт 2. Түүврийн тооцоолол

Байршил	z	p	Q=100-p	e	n
Улсын дүн	3.29	66.7	33.3	5	962


Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Эдгээр мэдээлэл болон дээрх томъёог ашиглан түүвэр олонлогийн оновчтой хэмжээг 962 иргэн гэж тодорхойллоо. Түүврийн бус алдаа болон кластерийн нөлөөг хамгийн бага байлгах үүднээс эх олонлогоос нийт 1449 иргэнийг түүвэр судалгаанд хамруулсан.

**Түүврийн хэмжээ**

Нуугдмал гэмт хэргийг тодорхойлох зорилгоор явуулсан судалгаанд Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Дундговь, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймгийн иргэд болон Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Багахангай, Сүхбаатар, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх зэрэг 8 дүүргийн иргэдийг оролцуулан нийт **1449** иргэн оролцсоноос 916 буюу 63.2 хувь орон нутгаас, 533 буюу 36.8 хувь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын 660 буюу 45.5 хувь эрэгтэй, 789 буюу 54.5 хувь нь эмэгтэй байна. Дээрх иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 21 хувь нь 18-25 нас, 37 хувь нь 26-35 нас, 24 хувь нь 36-45 нас, 12 хувь нь 46-55 насны иргэд байна. (График 1)

График 1. Судалгаанд хамрагдагчид, насны бүлгээр



Боловсролын түвшинээр нь авч үзвэл, 59 буюу 4.1 хувь нь боловсрол эзэмшээгүй, 210 буюу 14.5 хувь нь бүрэн бус дунд, 463 буюу 32 хувь нь бүрэн дунд 690 буюу 47.6 хувь нь дээд боловсролтой иргэд байна. (Хүснэгт №3)

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдагчид, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Тоо	Хувь
Боловсрол эзэмшээгүй	59	4.1%
Бүрэн бус дунд боловсролтой	210	14.5%
Бүрэн дунд боловсролтой	463	32.0%
Дээд боловсролтой	690	47.6%
<b>Нийт</b>	<b>1449</b>	<b>100.0%</b>

Судалгааны түүврийн хэмжээ, оролцогчдын хүн ам зүйн шинжээс үзвэл судалж буй асуудлын талаар бодитой мэдээлэл өгөх боломжтой нийгмийн гишүүдийн төлөөлөл оролцсон байна.

**Судалгаанд ашигласан мэдээлэл ба асуулт**

НҮБ-ын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх хорооноос гаргасан “Гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг тооцох” (National crime victimization survey) аргачлалын зарчимд тулгуурласан. Гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг тооцох гэдэг нь гэмт хэрэг, халдлагад

өртсөн боловч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байгаа нуугдмал гэмт хэргийн түвшинг хохирогчоор дамжуулан тодорхойлох аргачлал юм.

Энэхүү судалгааг Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, судлаачдын хамтарсан баг 2017 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 20-ны хооронд түүвэрт багтсан аймаг, нийслэлийн дүүргийн иргэдийн дунд явуулсан “Монгол улс дахь гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа” суурь судалгааны тайлангийн мэдээллийн сангаас дараах асуултуудыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд, “Та өнгөрсөн 1 жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болж байсан уу?”, “Өнгөрсөн 1 жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?”, “Хэрэв хохирогч болж байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу?” гэсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд чиглэгдсэн өргөн хүрээний асуултууд багтсан.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны оны гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтээс тодорхой төрлийн гэмт хэргийн үзүүлэлтийг авсан болно.

### Үр дүнг тооцсон аргачлал

Үр дүнг тооцохдоо дараах шалгуур баримталсан. Үүнд,

1. Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 13 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асуулгын аргаар тодорхойлсон бөгөөд хариултыг 1=Тийм, 2=Үгүй гэсэн сонголттой байхаар тооцсон; (Хүснэгт №4)
2. Гэмт хэрэгт хохирсон гэж хариулсан оролцогчдын тоог 100 хувь гэж үзвэл тэдний хэдэн хувь нь цагдаагийн байгууллагад энэ талаараа мэдээлэлж байсныг тооцоолсон; (Хүснэгт №5)
3. Судалгааны үр дүнгийн бодит байдлын шалгуурыг түүвэрлэлтийн техник, хэмжээ, оролцогчдын шинж байдал, томъёоллоор тодорхойлсон;
4. Нуугдмал гэмт хэргийн түвшинг улсын хэмжээнд болон тодорхой төрлийн гэмт хэргийн жишээн дээр гаргахдаа дараах томъёоллыг ашиглан тооцоолсон.

**Томьёо 1.** 
$$Y = X \left( \frac{1}{K} - 1 \right)$$

**X** - Цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг

**Y** - Нийт бүртгэгдсэн байх магадлалтай гэмт хэрэг

**K** - Гэмт хэрэгт өртөөд цагдаагийн байгууллагад мэдэгдсэн коэффициент, “K”-г тодорхойлохдоо гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны асуулгад хохирсон гэж хариулт өгөөд, тэднээс цагдаад мэдэгдсэн хүмүүсийн хувь хэмжээгээр (0-1) үнэлгээгээр тодорхойлно.

**Томьёо 2.**

$$S = Y - X$$

**S** - Цэвэр нуугдмал байх гэмт хэргийн тоо

Судалгааны мэдээллийг SPSS.21 програм ашиглан боловсруулсан бөгөөд судалгааны үр дүн, дүгнэлт нь зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэгдсэн болно

## ГУРАВ. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ТҮВШИНГ ТООЦСОН НЬ

### 3.1 Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 13 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 4-т гэмт хэргийн улмаас сүүлийн 1 жилийн хугацаанд хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмбэлэн харуулав.

Судалгаанд оролцсон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол хоёрдугаарт 257 буюу 17.8 хувь нь эд хөрөнгөө залилан мэхлүүлэх замаар хохирсон гэж тус тус хариулжээ. Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хууль бусаар мөрдөх гэмт хэргүүд орж байна.

Хүснэгт 4. Гэмт хэрэгт шууд хохирсон байдал

№	Гэмт хэргийн төрөл	Тийм	Үгүй
1	Эд хөрөнгөө хулгайд алдаж	32.0%	68.0%
2	Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	17.8%	82.2%
3	Гүтгэгдэж, доромжлогдож	16.3%	83.7%
4	Зам тээврийн осолд өртөж	15.1%	84.9%
5	Эд хөрөнгөө дээрэмдүүлж	14.5%	85.5%
6	Бусдын халдлагад өртөж	14.3%	85.7%
7	Авилгын улмаас эрх ашиг хөндөгдөж	10.1%	89.9%
8	Цахим гэмт хэрэгт өртөж	8.0%	92.0%
9	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж	6.5%	93.5%
10	Хилсээр хэрэгт шийтгэгдэж	6.3%	93.7%
11	Хүн барьцаалагдаж эсвэл хулгайлагдаж	5.4%	94.6%
12	Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	4.8%	95.2%
13	Хууль бус мөрдлөгийн улмаас	4.7%	95.3%

*Эх сурвалж: Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа, ХСИС, УБ., 2017*

Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлоход шууд бусаар хохирсон байдлыг тодруулах нь ач холбогдолтой байдаг. Иймээс судалгаанд оролцогчдоос “Өнгөрсөн нэг жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?” гэсэн асуулт тавихад бие махбодын хувьд хохирсон гэж 17.6 хувь нь, авилгын улмаас хохирсон гэж 8.5 хувь нь, эд хөрөнгийн хувьд хохирсон гэж 29.9 хувь нь, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж хохирсон гэж 4.9 хувь нь тус тус хариулжээ. (График 2)

График 2. Шууд бусаар гэмт хохирсон байдал



Судалгааны үр дүнгээс харахад бусдын эд хөрөнгийг хулгайлах, бие махбодын хувьд хохирох гэмт хэргийн нуугдмал байх магадлал өндөр байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд авилга, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг өсч байгаа талаар эрдэмтэн судлаачид мэдээлэл хийж байгаа боловч энэ судалгааны үр дүнгээр тийм ч өндөр үзүүлэлттэй биш.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүс ямар арга хэмжээ авсан талаар тодруулах зорилгоор “Хэрэв та өөрөө эсвэл таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг Хүснэгт 5-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 5. Гэмт хэрэгт хохироод мэдээлсэн байдал

№	Гэмт хэргийн төрөл	Судалгаанд оролцсон иргэд	Хохирсон иргэдийн тоо	Үүнээс:		Нуугдмал байх магадлал, хувиар
				Хуулийн байгууллагад мэдэгдсэн	Хувь	
1	Эд хөрөнгөө хулгайд алдаж	1449	463	184	39.7	60.3
2	Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	1449	257	62	24.1	75.9
3	Гүтгэгдэж, доромжлогдож	1449	236	38	16.1	83.9
4	Зам тээврийн осолд өртөж	1449	218	119	54.5	45.5
5	Эд хөрөнгөө дээрэмдүүлж	1449	210	89	42.2	47.8
6	Бие махбодын халдлагад өртөж	1449	207	44	21.1	78.9
7	Авилгын улмаас эрх ашиг хөндөгдөж	1449	146	17	11.7	88.3
8	Цахим гэмт хэрэгт өртөж	1449	115	22	19.2	80.2
9	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж	1449	94	13	13.6	86.4
10	Хилсээр хэрэгт шийтгэгдэж	1449	91	53	58.1	41.9
11	Хүн барьцаалагдаж эсвэл хулгайлагдаж	1449	78	58	74.7	25.3
12	Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	1449	69	10	14.5	85.5
13	Хууль бус мөрдлөгийн улмаас	1449	68	12	18.1	81.9
<b>Улсын дундаж</b>		<b>1449</b>	<b>175</b>	<b>55</b>	<b>31.3</b>	<b>68.7</b>

Эх сурвалж: Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа, УБ., 2017

Судалгаанаас харахад гэмт хэрэгт хохирсон хүмүүсээс дөнгөж 31.3 хувь цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байгаа нь нэг талаас нийт гэмт хэргийн 68.7 хувь нь нуугдмал байгааг илэрхийлж байгаа бол нуугдмал байх хамгийн өндөр магадлалтай гэмт хэргүүдэд авилга, мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, бэлгийн халдашгүй байдал, гүтгэх, доромжлох гэмт хэрэг, зөрчил хамаарч байна. Харин хамгийн бага түвшинд байгаа гэмт хэргүүдэд хүн барьцаалах, зам тээврийн осол, хилсээр шийдэгдэх, дээрэмдэх зэрэг гэмт хэргүүд хамаарч байна.

Хүснэгт 6-д үзүүлсэн нуугдмал байх магадлалын хувийг 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтэд үндэслэн нуугдмал байх гэмт хэргийн тоон үзүүлэлт, бүртгэгдсэн гэмт хэргээс хэд дахин их байгааг харьцуулан дүн шинжилгээ хийв. Хүснэгт 6-д үзүүлснээр 2017 онд улсын хэмжээнд нийт 20032 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийгэмд бодитоор үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 31.3 хувь гэж дээрх аргачлалын дагуу тооцож болно. Хэрэв 20032 нь нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 31.3 хувь бол 100 хувь нь хэдэн гэмт байх бэ? гэсэн тоон үзүүлэлтийг пропорцын аргаар тооцож, гарсан тооноос бүртгэгдсэн гэмт хэргийг хасах байдлаар нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлсон болно.

Хүснэгт 6. Гэмт хэргийн нуугдмал байх магадлал

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэрэг, 2017	Нийт үйлдэгдсэн байж болох гэмт хэрэг	Нуугдмал байх магадлал, хувиар	Бүртгэгдсэнээс хэд дахин их
1	Хулгайлах (ЭХТА 17.1, 17.12)	8379	21105	12726	1.5
2	Залилах (ЭХТА-ийн 17.3/	2020	8381	6361	3.1
3	Авто тээврийн хэрэгслийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (ЭХТА-ийн 27.10)	754	1383	629	0.8
4	Дээрэмдэх (ЭХТА-ийн 17.2)	1007	2106	1099	1.0
5	Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг (ЭХТА-ийн 10.1, 11.1, 11.5, 11.6 дүгээр)	5040	23886	18846	3.7
6	Авилгын гэмт хэрэг (ЭХТА-ийн 22.1 22.4, 22.5)	18	153	135	7.5
7	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (ЭХТА-ийн 26 дугаар бүлэг)	39	203	164	4.2
8	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэрэг (ЭХТА-ийн 20.7, 20.8)	101	742	641	6.3
9	Хилсээр хэрэгт шийтгэгдэх (ЭХТА-ийн 21.12, 21.14)	74	127	53	0.7
10	Хүн барьцаалах, хулгайлах (ЭХТА-ийн ЭХТА-ийн 13.2, 13.3, 13.4)	8	11	3	0.3
11	Хүчиндэх, бэлгийн мөлжлөг (ЭХТА-ийн 12.1, 12.2, 12.3)	269	1855	1586	5.8
12	Хууль бусаар мөрдөж мөшгих (ЭХТА-ийн 13.12)	2	11	9	4.5
<b>Улсын дундаж</b>		<b>20032</b>	<b>64000</b>	<b>43968</b>	<b>2.2</b>

## ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Аюулгүй орчинд амьдрах эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 1 дахь хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, мөн 38 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” нь засгийн газрын үүрэг мөн гэж тодорхойлсон нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжүүлэх, үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоох шаардлагатай холбогдоно.
2. Цаг хугацаа орон зайн хүрээнд нийгэмд аюултай үзэгдэл болох нийгмийн болон эрүүгийн эрх зүйн шинжийг агуулсан тодорхой нөхцөлд үүсэж бий болсон төрийн бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн нэг хэсгийг нуугдмал гэмт хэрэг гэж тодорхойлж болно. Нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байх тусам, иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, нийгмийн дэг журам алдагдаж, иргэд гэмт хэргээс түгших хандлага нэмэгдэж байна.
3. Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор 1449 иргэнээс авсан судалгааны дүнгээс үзэхэд Улсын хэмжээнд нуугдмал байх гэмт хэргийн тоо 45862 гэсэн үзүүлэлт гарч байгаа нь өнөөгийн гэмт хэргийн түвшингээс 2.2 дахин их байгааг илтгэж байна. Монгол Улс дахь гэмт хэргийн нуугдмал байх шинжийг

харгалзан гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны асуудлыг шинэчлэн тогтоох шаардлагатай.

4. Тодорхой төрлийн гэмт хэргийн нуугдмал байх магадлал авлигын гэмт хэрэг 7.5 дахин, хүчиндэх, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 5.8 дахин, мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 6.3 дахин, хууль бусаар мөрдөн мөшгих гэмт хэрэг 4.5 дахин, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4.2 дахин их байгаа нь анхаарал татаж байна.
5. Монгол Улсын нийт гэмт хэргийн бүтцэд 41.8 хувийг эзэлж байгаа хулгайлах гэмт хэргийн нуугдмал байх магадлал 12726 буюу бүртгэгдсэн гэмт хэргээс 1.5 дахин их, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нуугдмал байх магадлал 18846 буюу бүртгэгдсэн гэмт хэргээс 3.7 дахин их байх боломжтой байна.
6. Хүн барьцаалах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргүүд нуугдмал байх магадлал харьцангуй бага байна.


### Эх сурвалжийн жагсаалт

1. Сазонован.В. "Понятие латентной преступности" Уголовное право и современность: Межвуз. Сб. Науч.тр. Вып. 6. Красноярск: Сибюи МВД, 2002.-С.8-180-184.
2. Д.Мягмарцэрэн "Нуугдмал гэмт хэрэг, ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал", хууль сахиулахуй сэтгүүл, УБ., 2015 №1
3. Ли.Д.А.Уголовно-статистический учёт: структурно-функциональные закономерности: моногр. М.Русский мир, 1997. 21 хуудас.
4. Roberson Wallace, introduction to criminology., New York, 2009
5. Цагдаагийн Ерөнхий Газар. "Монгол улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2017", УБ. 2018 он.
6. Цагдаагийн Ерөнхий Газар. "Монгол Улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2003-2013", УБ. 2017 он.
7. Хууль сахиулахын их сургуулийн судалгааны баг, "Монгол улс дахь гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа-2017", УБ., 2018 он
8. [www.1212.mn](http://www.1212.mn), ҮСХ, 2017



## ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭХ НЬ

Статистикийн мэдээллийн хяналтын Олон Улсын байгууллага “Open data whatch”-оос 2017 онд улс орнуудын гэмт хэргийн статистикт өгсөн үнэлгээ, оноогоор (эхний 12 улс)



Эх сурвалж: <http://odin.opendatawatch.com/>

<sup>1</sup> Энэхүү бүлгийг хууль зүйн доктор (Ph.D) Б.Энхболд хариуцан гүйцэтгэв.

## НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үүсэл, хөгжлийг Их засаг хууль буй болсон үеэс бий болсон гэж үзэж болно. 1206 онд Чингисийн эзэнт гүрний их хуралдааны үед Их засаг хуулийг анх зарлан тунхагласнаар уг хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуулийн заалтыг зөрчиж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлж, ял, шийтгэл ногдуулах, торгууль, алба гувчуур оногдуулах зэрэгт тоо мэдээллийг ашиглаж, их эзэн хааны зарлигийн хэрэгжилтийг тоогоор илэрхийлэн танилцуулж байсан нь түүхэнд бичигдсэн байдаг. XIII зууны үед хүчирхэг төр улсыг байгуулсан монголчууд байлдан дагуулсан улс орныхоо хүн амыг тоолж, түүнд үндэслэн албан татвар ногдуулж байсан тухай түүхийн баримт бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. МЭӨ 174-163 онд Хүннү гүрэн Лаошань Шаньюйн үед улсын албан татварыг цэгцтэй болгож хүн, малаа тоолж, мод хэрчин тэмдэглэж байсан тухай тэмдэглэл түүхэнд үлдсэн байдаг.

1993 онд батлагдсан “Цагдаагийн байгууллагын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд Цагдаагийн төв байгууллагын харьяанд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно, мөн хуулийн 28 дугаар зүйлд Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж, ашиглана гэж заасан нь өнөөгийн Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “Статистик, мэдээллийн хэлтэс”-ийн эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн түүхтэй.

Манай улсад гэмт хэргийн мэдээлэл 1980-аад оноос улам өргөжин мэдээлэл технологийн дэвшилтэт арга технологийг ашиглах болж, улмаар “Гэмт хэргийн статистикийн мэдээллийн сан”-г бүрдүүлж эхэлсэн байна.

1993 онд батлагдсан “Шүүхийн тухай” хуулийн 55 дугаар зүйлд “Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистикийн тоо, мэдээллийг нэгтгэн дүгнэж, санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” гэж заасан нь одоогийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн үндэс суурийг тавьсан түүхтэй.

Олон улсын түвшинд гэмт хэргийн статистик нь 2 эх үүсвэрээс бүрддэг гэж үздэг. Үүнд:


- Гэмт хэргийн статистикийн албан болон захиргааны статистикийн мэдээлэл
- Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгаа

Олон улсын хэмжээнд гэмт хэргийн статистикт олон улсын дараахь аргачлал, ангилал, гарын авлага, зөвлөмжийг ашиглаж байна. Үүнд:

- Гэмт хэрэг, хууль сахиулахын статистикийг боловсронгуй болгох нь гарын авлага, НҮБ-ын СК, 2003 он
- Хохирогчийн судалгааны гарын авлага, НҮБ-ын ГХМБТГ, ЕЭЗК, 2010 он
- Лисбоны хэлэлцээр, Мансууруулах бодисын статистикийн үзүүлэлт, 2000 он
- Насанд хүрээгүй хүнийг шүүн таслах ажиллагааны үзүүлэлтүүд, НҮБ-ын ГХМБТГ, НҮБ-ын ХС, 2006 он
- Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангилал, НҮБ-ын ГХМБТГ, ЕЭЗК, 2015 он
- “Эрүүгийн эрх зүйн мэдээллийг үнэлэх арга хэрэгсэл” НҮБ-ын ГХМБТГ, 2006 он

Үндэсний статистикийн хороо нь одоогоор Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн дагуу хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудаас (Цагдаагийн ерөнхий газар(108), Шүүхийн ерөнхий зөвлөл(60), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар(40), Авлигатай тэмцэх газар(11)) нийт 200 гаруй үзүүлэлтээр улс, бүс, аймаг, нийслэл, сумаар жил улирал, сарын давтамжтайгаар мэдээллийг цуглуулж, боловсруулж нийтэд тархааж байна. Түүнчлэн жил тутам НҮБ-ын Гэмт хэрэг мансууруулах бодистой тэмцэх газарт мэдээлэх ёстой **267** үзүүлэлтээс одоогоор **148** орчим үзүүлэлтийг боловсруулж хүргүүлж байна.

Зураг 1. Гэмт хэргийн статистикийн мэдээлэл цуглуулалт, тархаалтын зураглал



## ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ОЛОН УЛСАД ХАРЬЦУУЛАГДАХ БАЙДАЛ

### 2.1 НҮБ-ЫН ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГЫН СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

НҮБ-ын гэмт хэргийн чиг хандлагын судалгаа нь 2016 оноос гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, ангиллын 11 категорийн дагуу мэдээллээ цуглуулж эхэлсэн. Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангилалд нийцсэн Гэмт хэргийн статистикийн үндэсний ангилал боловсруулж, батлуулж, мөрдүүлээгүй учраас Монгол Улс НҮБ-ын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны 267 үзүүлэлтүүдээс одоогоор 148 үзүүлэлт (55.4%)-ийг гаргаж хүргүүлж байна. НҮБ-ын ГХЧХС нь өгөгдлийн файл болон мета өгөгдлийн файлаас бүрдэнэ.

#### 1.1 Санаатай аллагын мэдээлэл

ГАРДАГ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-91  
ГАРДАГГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-21  
НИЙТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-112

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
	<b>Хүний аминд хүрсэн болон хүрэхийг завдсан гэмт хэрэг</b>	ЦЕГ	
1	Санаатай аллагын гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
2	Санаатай аллагын гэмт хэрэг үйлдэхийг завдсан гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарахгүй
	<b>Санаатай аллагын гэмт хэргийн хохирогчийн тоо, хүйсээр</b>	ЦЕГ	
3	Санаатай аллагын гэмт хэргийн нийт хохирогчийн тоо	ЦЕГ	гарна
4	Санаатай аллагын хохирогч эрэгтэй	ЦЕГ	гарна
5	Санаатай аллагын хохирогч эмэгтэй	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын гэмт хэргийн хохирогч, хохирогч, гэмт хэрэгтний хамаарал, хүйсээр</b>	ЦЕГ	
6	Гэр бүл, ойр дотнын хамтрагч, хүйсээр	ЦЕГ	гарна
7	Ойр дотнын хамтрагч, хүйсээр	ЦЕГ	гарна
8	Гэр бүлийн гишүүн, хүйсээр	ЦЕГ	гарна
9	Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн, хүйсээр	ЦЕГ	гарна
10	Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн, хүйсээр	ЦЕГ	гарна
11	Гэмт хэрэгтэн нь тодорхойгүй хамаарал нь тодорхой бус хэрэг	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын хохирогч, үйлдэгдсэн байдал, хүйсээр</b>	ЦЕГ	
12	Зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн	ЦЕГ	гарахгүй
13	Бусад эрүүгийн үйлдлээр	ЦЕГ	гарахгүй
14	Хувь хүмүүс хоорондын аллага	ЦЕГ	гарахгүй
15	Нийгэм, улс төрийн аллага	ЦЕГ	гарахгүй
16	Террорист аллага	ЦЕГ	гарахгүй
17	Бусад төрлийн аллага	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын хохирогч, аллага үйлдсэн арга хэрэгслээр</b>	ЦЕГ	
18	Галт зэвсэг, тэсрэх бодисоор	ЦЕГ	гарахгүй
19	Галт зэвсгээр	ЦЕГ	гарна
20	Бусад зэвсгээр	ЦЕГ	гарахгүй
21	Хурц иртэй зүйлээр	ЦЕГ	гарна
22	Ямар ч зэвсэггүй, бусад арга хэрэгслээр	ЦЕГ	гарна
23	Тодорхой бус аргаар	ЦЕГ	гарахгүй

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
	<b>Санаатай аллагын хохирогч, хүйс ба насны ангиллаар</b>	ЦЕГ	
24	Эрэгтэй	ЦЕГ	гарна
25	0-9	ЦЕГ	гарна
26	10-14	ЦЕГ	гарна
27	15-17	ЦЕГ	гарна
28	18-19	ЦЕГ	гарна
29	20-24	ЦЕГ	гарна
30	25-29	ЦЕГ	гарна
31	30-44	ЦЕГ	гарна
32	45-59	ЦЕГ	гарна
33	60 түүнээс дээш	ЦЕГ	гарна
34	Тодорхой бус	ЦЕГ	гарна
35	Эмэгтэй	ЦЕГ	гарна
36	0-9	ЦЕГ	гарна
37	10-14	ЦЕГ	гарна
38	15-17	ЦЕГ	гарна
39	18-19	ЦЕГ	гарна
40	20-24	ЦЕГ	гарна
41	25-29	ЦЕГ	гарна
42	30-44	ЦЕГ	гарна
43	45-59	ЦЕГ	гарна
44	60 түүнээс дээш	ЦЕГ	гарна
45	Тодорхой бус	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын хохирогч, иргэншлээр, хүйсээр</b>	ЦЕГ	
46	МУ-ын иргэн, хүйсээр	ЦЕГ	гарна
47	Гадаадын иргэн, хүйсээр	ЦЕГ	гарна
	<b>3 том хотын санаатай аллагын хохирогч</b>	ЦЕГ	
48	1-р хот	ЦЕГ	гарна
49	2-р хот	ЦЕГ	гарна
50	3-р хот	ЦЕГ	гарна
	<b>Хотын хүн амын тоогоор</b>	ЦЕГ	
51	1-р хот	ЦЕГ	гарна
52	2-р хот	ЦЕГ	гарна
53	3-р хот	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын гэмт хэрэгтэн, хүйс, насны ангиллаар</b>	ЦЕГ	
54	Санаатай аллагын гэмт хэрэгтэн, эрэгтэй	ЦЕГ	гарна
55	0-9	ЦЕГ	гарна
56	10-14	ЦЕГ	гарна
57	15-17	ЦЕГ	гарна
58	18-19	ЦЕГ	гарна
59	20-24	ЦЕГ	гарна
60	25-29	ЦЕГ	гарна
61	30-44	ЦЕГ	гарна
62	45-59	ЦЕГ	гарна
63	60 түүнээс дээш	ЦЕГ	гарна
64	Тодорхой бус	ЦЕГ	гарна
65	Санаатай аллагын гэмт хэрэгтэн, эмэгтэй	ЦЕГ	гарна
66	0-9	ЦЕГ	гарна
67	10-14	ЦЕГ	гарна
68	15-17	ЦЕГ	гарна
69	18-19	ЦЕГ	гарна
70	20-24	ЦЕГ	гарна
71	25-29	ЦЕГ	гарна

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
72	30-44	ЦЕГ	гарна
73	45-59	ЦЕГ	гарна
74	60 түүнээс дээш	ЦЕГ	гарна
75	Тодорхой бус	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын гэмт хэрэгтэн, иргэншлээр, хүйсээр</b>	ЦЕГ	
76	МУ-ын иргэн, хүйсээр	ЦЕГ	гарна
77	Гадаадын иргэн, хүйсээр	ЦЕГ	гарна
	<b>Санаатай аллагын гэмт хэргийг давтан үйлдэгч, хүйсээр</b>	ЦЕГ	
78	Өмнө нь ямар нэг төрлийн гэмт хэргээс болж шийтгэгдэж байсан	ЦЕГ	гарна
79	Өмнө нь ямар нэг төрлийн гэмт хэргээр ял шийтгэгдэж байгаагүй	ЦЕГ	гарна
80	Өмнө нь хэзээ ч ял шийтгэгдсэн нь тогтоогдоогүй	ЦЕГ	гарахгүй

## 1.2 Хүчирхийллийн гэмт хэргийн мэдээлэл

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
	<b>Хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан гэмт хэрэг</b>	ЦЕГ	
81	Хүнд хэлбэрийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
82	Хүн хулгайлах гэмт хэрэг	ЦЕГ	гарна
	<b>Хүний биед бэлгийн шинж чанартай хохирол учруулсан гэмт хэрэг</b>	ЦЕГ	
83	Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
84	Хүчингийн хэргийн тоо	ЦЕГ	гарна
85	Бэлгийн дарамтын хэргийн тоо	ЦЕГ	гарахгүй
86	Бэлгийн хүчирхийллийн бусад төрөл	ЦЕГ	гарахгүй
	<b>Хүнийг айлган сүрдүүлж, хүчирхийлж өмч хөрөнгөнд нь халдах</b>		
87	Дээрмийн гэмт хэрэг	ЦЕГ	гарна
	<b>Хүнд хэлбэрийн хүчирхийллийн хохирогч, хохирогч гэмт хэрэгтний хамаарлаар, хүйсээр</b>		
88	Гэр бүл, ойр дотнын хамтрагч, хүйсээр	ЦЕГ	гарахгүй
89	Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн, хүйсээр	ЦЕГ	гарахгүй
90	Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн, хүйсээр	ЦЕГ	гарахгүй
91	Гэмт хэрэгтэн нь тодорхойгүй хамаарал нь тодорхой бус хэрэг, хүйсээр	ЦЕГ	гарахгүй
	<b>Бэлгийн хүчирхийллийн хохирогч, гэмт хэрэгтний хамаарал ба хүйсээр</b>		
92	Гэр бүл, ойр дотнын хамтрагч, хүйсээр	ЦЕГ	гарна
93	Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн, хүйсээр	ЦЕГ	гарна
94	Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн, хүйсээр	ЦЕГ	гарна
95	Гэмт хэрэгтэн нь тодорхойгүй хамаарал нь тодорхой бус хэрэг, хүйсээр	ЦЕГ	гарна

## 1.3 Бусад гэмт хэргийн мэдээлэл

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
	<b>Хяналтанд байдаг мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бусад бодистой холбоотой гэмт хэрэг</b>		
96	Хяналтанд байдаг мансууруулах бодис, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэг	ЦЕГ	гарна
97	Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар эзэмших, худалдан авах, хэрэглэх, тариалах эсвэл боловсруулах	ЦЕГ	гарна
98	Хяналтанд байдаг мансууруулах бодисыг бусдын хэрэглээнд хууль бусаар худалдаалах, тариалах эсвэл борлуулах	ЦЕГ	гарахгүй
	<b>Залилан, хууран мэхлэх, авлигын гэмт хэрэг</b>		
99	Авлигын гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
100	Хээл хахуулын гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
101	Бусад төрлийн авлигын гэмт хэрэг	ЦЕГ	гарахгүй
	<b>Нийтийн хэв журам, засаг захиргаа, төрийн хууль, журмын эсрэг гэмт хэрэг</b>		
102	Цагаачдыг хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн хэрэг	ЦЕГ	гарахгүй

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
<b>Төрийн хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг</b>			
103	Тэсэрч дэлбэрэх бодис, зэвсэг худалдах	ЦЕГ	гарахгүй
104	Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэг оролцсон хэрэг	ЦЕГ	гарахгүй
105	Террорист бүлэг оролцсон гэмт хэрэг	ЦЕГ	гарахгүй
106	Терроризмыг санхүүжүүлэх	ЦЕГ	гарахгүй
<b>Зөвхөн өмчийн эсрэг гэмт хэрэг</b>			
107	Орон байрны хулгайн гэмт хэрэг	ЦЕГ	гарна
108	Хулгайн гэмт хэрэг	ЦЕГ	гарна
109	Тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэрэг	ЦЕГ	гарна
<b>Залилан, хууран мэхлэх, авлигын гэмт хэрэг</b>			
110	Залилангийн гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
111	Цахим гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна
112	Мөнгө угаах гэмт хэргийн тоо	ЦЕГ	гарна

## 2.1 Эрүүгийн эрх зүйн системийн үйл ажиллагаа

ГАРДАГ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-16  
ГАРДАГГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-4  
НИЙТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-20

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх	
Эрүүгийн эрх зүйн системийн үйл ажиллагаа, гэмт хэргийн олон улсын ангиллаар				
1	Санаатай аллага (0101)	ЦЕГ	гарна	
2	Хүчингийн гэмт хэрэг (03011)	ЦЕГ	гарна	
3	Хээл хахуулын гэмт хэрэг (07031)	ЦЕГ	гарна	
4	Цагдаад сэжигтнээр баривчлагдсан хүний тоо	Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар эзэмших, худалдан авах, хэрэглэх, тариалах эсвэл борлуулах гэмт хэрэг (06011)	ЦЕГ	гарна
5		Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар худалдаалах, тариалах эсвэл борлуулах (06012)	ЦЕГ	гарахгүй
1	Санаатай аллага (0101)	УЕПГ	гарна	
2	Хүчингийн гэмт хэрэг (03011)	УЕПГ	гарна	
3	Хээл хахуулын гэмт хэрэг (07031)	УЕПГ	гарна	
4	Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хүний тоо	Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар эзэмших, худалдан авах, хэрэглэх, тариалах эсвэл борлуулах гэмт хэрэг (06011)	УЕПГ	гарна
5		Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар худалдаалах, тариалах эсвэл борлуулах (06012)	УЕПГ	гарна
1	Санаатай аллага (0101)	ШЕЗ	гарна	
2	Хүчингийн гэмт хэрэг (03011)	ШЕЗ	гарна	
3	Хээл хахуулын гэмт хэрэг (07031)	ШЕЗ	гарна	
4	Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо	Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар эзэмших, худалдан авах, хэрэглэх, тариалах эсвэл борлуулах гэмт хэрэг (06011)	ШЕЗ	гарна
5		Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар худалдаалах, тариалах эсвэл борлуулах (06012)	ШЕЗ	гарахгүй
1	Санаатай аллага (0101)	ШШГЕГ	гарахгүй	
2	Хүчингийн гэмт хэрэг (03011)	ШШГЕГ	гарна	
3	Хээл хахуулын гэмт хэрэг (07031)	ШШГЕГ	гарна	
4	Хоригдлын тоо	Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар эзэмших, худалдан авах, хэрэглэх, тариалах эсвэл борлуулах гэмт хэрэг (06011)	ШШГЕГ	гарна
5		Хяналтанд байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар худалдаалах, тариалах эсвэл борлуулах (06012)	ШШГЕГ	гарахгүй

#### 4.1 Гэмт хэргийн олон улсын ангиллын 1-р түвшний 11 категорын дагуу

ГАРДАГ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-0  
 ГАРДАГГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-55  
 НИЙТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-55

№	Үзүүлэлтийн нэр	Цагдаа		Прокурор	Шүүх	Хорих
		Нийт гэмт хэргийн тоо	Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо	Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хүний тоо	Ял шийтгүүлсэн хүний тоо	Хоригдлын тоо
1	Хүний аминд хүрсэн болон хүрэхийг завдсан үйлдэл					
2	Хувь хүнд гэмтэл, хохирол учруулсан, учруулахыг завдсан үйлдэл					
3	Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл					
4	Хүний эсрэг хүчирхийлэл, заналхийлэлтэй холбоотой өмчийн эсрэг хэрэг					
5	Зөвхөн өмчийн эсрэг гэмт хэрэг					
6	Хяналтанд байдаг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг					
7	Залилан, хууран мэхлэх болон авилгын хэрэг					
8	Төрийн эрх мэдэл, нийгмийн дэг журмын эсрэг гэмт хэрэг					
9	Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг					
10	Байгаль орчны эсрэг үйлдэл					
11	Өөр ангилалд ороогүй бусад хэрэг					

Тайлбар: монгол улс гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үндэсний хэмжээнд мөрдөх гэмт хэргийн ангиллаа боловсруулж, батлуулж мөрдүүлээгүйн улмаас дээрх бүх үзүүлэлтүүд гарахгүй байна.

#### 5.1 Хоригдсон хүн, хүйс, насны ангилал, иргэншлээр

ГАРДАГ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-10  
 ГАРДАГГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-1  
 НИЙТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-11

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
	Нийт хоригдсон хүний тоо		
1	Насанд хүрсэн хүн, хүйсээр	ШШГЕГ	гарна
2	Насанд хүрээгүй хүн, хүйсээр	ШШГЕГ	гарна
3	МУ-ын иргэн	ШШГЕГ	гарна
4	Гадаадын иргэн	ШШГЕГ	гарна
	Хоригдсон хүн, ял эдэлсэн байдал, хүйсээр		
1	Ял шийтгүүлэхээс өмнө хоригдсон хүн, хүйсээр	ШШГЕГ	гарна
2	Ял эдэлсэн хүн, хүйсээр	ШШГЕГ	гарна
3	Ял эдлэх шийдвэр дууссан	ШШГЕГ	гарна
4	Ял эдлэх шийдвэр эцэслээгүй	ШШГЕГ	гарахгүй
	Ял шийтгүүлэхээс өмнө хоригдсон хүний тоо, цагдан хоригдсон хугацаагаар		
1	12 сараас дээш хугацаагаар	ШШГЕГ	гарна
2	12 сараас доош хугацаагаар	ШШГЕГ	гарна
3	6 сараас доош хугацаагаар	ШШГЕГ	гарна



**6.1 Эрүүгийн эрх зүйн системийн хүний нөөц, хүчин чадал**

ГАРДАГ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-15  
 ГАРДАГГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-5  
 НИЙТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-20

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
<b>Цагдаагийн бие бүрэлдхүүн, хүйс, чиг үүргээр</b>			
1	Цагдаагийн нийт бие бүрэлдхүүн, хүйсээр	ЦЕГ	гарна
2	Цагдаагийн ажилтан, хариуцах чиглэлээр	ЦЕГ	гарна
3	Урьдчлан сэргийлэх	ЦЕГ	гарна
4	Илрүүлэх	ЦЕГ	гарна
5	Захиргааны / бусад	ЦЕГ	гарна
<b>Прокурорын боловсон хүчин, хүйсээр</b>			
1	Прокурорын нийт албан хаагчдын тоо	УЕПГ	гарна
2	Прокурорын нийт албан хаагчдын тоо, хүйсээр	УЕПГ	гарна
<b>Магистрийн зэрэгтэй, мэргэжлийн шүүгч, хүйсээр</b>			
1	Магистрийн зэрэгтэй нийт мэргэжлийн шүүгчийн тоо	ШЕЗ	гарна
2	Магистрийн зэрэгтэй нийт мэргэжлийн шүүгчийн тоо, хүйсээр	ШЕЗ	гарна
<b>Хорих ангийн албан хаагчид, чиг үүргээр, хүйсээр</b>			
1	Хорих ангийн нийт албан хаагчид, хүйсээр	ШШГЕГ	гарна
2	Хорих ангийн нийт ажилтан, чиг үүргээр	ШШГЕГ	гарахгүй
3	Хяналтын	ШШГЕГ	гарахгүй
4	Боловсрол/сургалт/ эрүүл мэндийн	ШШГЕГ	гарахгүй
5	Захиргаа/менежмент	ШШГЕГ	гарахгүй
6	Бусад	ШШГЕГ	гарахгүй
<b>Хорих ангийн албан ёсны хүчин чадал, хүйс, насны ангиллаар</b>			
1	Насанд хүрэгчид	ШШГЕГ	гарна
2	Өсвөр насныхан	ШШГЕГ	гарна
3	Бүх насны	ШШГЕГ	гарна
4	Хорих ангийн албан ёсны хүчин чадал, хүйсээр	ШШГЕГ	гарна
5	Хорих ангийн тоо	ШШГЕГ	гарна

**7.1 Хохирогчийн судалгаа**

ГАРДАГ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-0  
 ГАРДАГГҮЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-32  
 НИЙТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО-32

№	Үзүүлэлтийн нэр	Эх үүсвэр	Үзүүлэлт гардаг эсэх
<b>Тархах түвшин</b>			
1	Өөрийн амьдарч буй орчиндоо ганцаараа алхахдаа аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь		гарахгүй
2	Орон байрны хулгайн гэмт хэрэг		гарахгүй
3	Тээврийн хэрэгсэл болон түүний эд ангийн хулгай		гарахгүй
4	Хээл хахуулын гэмт хэрэг, хүйсээр		гарахгүй
5	Хээл хахуулын гэмт хэрэг-бүгд		гарахгүй
6	Бизнес эрхлэгчдийн дундах хээл хахууль		гарахгүй
7	Бие махбодийн хүчирхийлэл-бүгд		гарахгүй
8	Бие махбодийн хүчирхийлэл, хүйсээр		гарахгүй
9	Дээрэмдэх гэмт хэрэг		гарахгүй
10	Бие махбодийн дарамт		гарахгүй
11	Бэлгийн хүчирхийлэл-бүгд		гарахгүй
12	Бэлгийн хүчирхийлэл, хүйсээр		гарахгүй
13	Бэлгийн дарамт		гарахгүй
14	Хүчиндэх гэмт хэрэг		гарахгүй
15	Сэтгэл санааны хүчирхийллийн гэмт хэрэг-бүгд		гарахгүй


16	Сэтгэл санааны хүчирхийллийн гэмт хэрэг, хүйсээр	гарахгүй
17	Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл-бүгд	гарахгүй
18	Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл, хүйсээр	гарахгүй
19	Сэтгэл санаа, бие махбод, бэлгийн хүчирхийлэл-бүгд	гарахгүй
20	Сэтгэл санаа, бие махбод, бэлгийн хүчирхийлэл, хүйсээр	гарахгүй
21	Бие махбод, бэлгийн дарамт-бүгд	гарахгүй
22	Бие махбод, бэлгийн дарамт, хүйсээр	гарахгүй

**Цагдаагийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн түвшин**

23	Бие махбодийн хүчирхийллийн гэмт хэрэг-бүгд	гарахгүй
24	Бие махбодийн хүчирхийлэл, хүйсээр	гарахгүй
25	Дээрэмдэх гэмт хэрэг	гарахгүй
26	Бие махбодийн дарамт	гарахгүй
27	Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг-бүгд	гарахгүй
28	Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг, хүйсээр	гарахгүй
29	Бэлгийн дарамт	гарахгүй
30	Хүчиндэх гэмт хэрэг	гарахгүй
31	Бие махбод, бэлгийн хүчирхийлэл-бүгд	гарахгүй
32	Бие махбод, бэлгийн хүчирхийлэл, хүйсээр	гарахгүй

Тайлбар: Монгол улс одоогоор өрхөд суурилсан хохирогчийн суалгааг явуулаагүй учраас дээрх үзүүлэлтүүд бүгд гарахгүй байна.

ЗУРАГ-2. НҮБ-ЫН ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГЫН СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, схемээр



## НҮБ-ЫН ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГЫН СУДАЛГАА, 2014-2016 оны байдлаар

1-Санаатай аллагын мэдээлэл 1-(Intentional homicide data)		Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага Police or other law enforcement				
Жилийн үзүүлэлт Annual variables						
Үзүүлэлт (Indicators)		2014	2015	2016	Нэмэлт тайлбар Additional comments	
<b>1.1</b>	<b>Хүний аминд хүрсэн болон хүрэхийг завдсан хэрэг Acts leading to death or intending to cause death</b>					
1.1.1	Санаатай аллага (0101), гэмт хэргийн тоо Intentional homicide (0101) number of offences	211	204	174		
1.1.2	Санаатай аллага үйлдэхийг завдсан (0102), гэмт хэргийн тоо Attempted intentional homicide (0102) number of offences	0	0	0		
<b>1.2</b>	<b>Санаатай аллагын ХОХИРОГЧ, хүйсээр (SV) Intentional homicide VICTIMS by sex(SV)</b>					
1.2.1	Санаатай аллагын нийт хохирогч (0101) Total victims of intentional homicide(0101)	218	214	184		
1.2.1a	Санаатай аллагын эрэгтэй хохирогч (0101) Male victims of intentional homicide(0101)	164	163	145		
1.2.1b	Санаатай аллагын эмэгтэй хохирогч (0101) Female victims of intentional homicide(0101)	54	51	39		
<b>1.3</b>	<b>Санаатай аллагын ХОХИРОГЧ, гэмт хэрэгтэн, хохирогчийн хамаарал болон хүйсээр (ViP/SV) Intentional homicide VICTIMS by victim-perpetrator relationship and sex(ViP/SV)</b>					
1.3.1	Санаатай аллагын хохирогч (0101) хөнөөсөн хүнээр: Victims of intentional homicide(0101) killed by	Ойр дотны хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүн (IPFM) Intimate partner or family member(IPFM)	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	18	23	15
1.3.1a			Эрэгтэй/Male	9	15	6
1.3.1b			Эмэгтэй/Female	9	8	9
1.3.1.1		Ойр дотны хамтрагч Intimate partner	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	2	17	12
1.3.1.1a			Эрэгтэй/Male	1	13	5
1.3.1.1b			Эмэгтэй/Female	1	4	7
1.3.1.2		Гэр бүлийн гишүүн Family member	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	16	6	3
1.3.1.2a			Эрэгтэй/Male	7	2	1
1.3.1.2b			Эмэгтэй/Female	9	4	2
1.3.2		Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн Other perpetrator know to the victim	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	45	41	2
1.3.2a			Эрэгтэй/Male	26	24	39
1.3.2b			Эмэгтэй/Female	19	17	24
1.3.		Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн Perpetrator unknow to the victim	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	41	65	59
1.3.3a			Эрэгтэй/Male	6	50	38
1.3.3b		Эмэгтэй/Female	35	15	21	
<b>1.4</b>	<b>Санаатай аллагын ХОХИРОГЧ, орчин, нөхцөл болон хүйсээр (SiC/SV) Intentional homicide VICTIMS by situational context and sex (SiC/SV)</b>					
1.4.1.1	Санаатай аллагын хохирогч (0101) холбогдох:	Зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн Organized criminal groups	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	0	0	0
1.4.1.1a			Эрэгтэй/Male	0	0	0
1.4.1.1b			Эмэгтэй/Female	0	0	0
1.4.1.2		Бусад эрүүгийн үйлдлээр Other criminal activities	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	0	0	0
1.4.1.2a			Эрэгтэй/Male	0	0	0
1.4.1.2b			Эмэгтэй/Female	0	0	0
1.4.2		Хувь хүмүүс хоорондын аллага Interpersonal homicide	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	0	0	0
1.4.2a			Эрэгтэй/Male	0	0	0
1.4.2b			Эмэгтэй/Female	0	0	0
1.4.3		Нийгэм-улс төрийн аллага Socio-political homicide	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	0	0	0
1.4.3a			Эрэгтэй/Male	0	0	0
1.4.3b			Эмэгтэй/Female	0	0	0
1.4.3.1		Алан хядах үйл ажиллагаа Terrorist offences	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	0	0	0
1.4.3.1a			Эрэгтэй/Male	0	0	0
1.4.3.1b		Эмэгтэй/Female	0	0	0	

1.4.4		Аллагын мэдэхгүй төрлүүд Unknown types of homicide	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	0	0	184
1.4.4a			Эрэгтэй/Male	0	0	145
1.4.4b			Эмэгтэй/Female	0	0	39
<b>1.5</b>	<b>Санаатай аллагын хохирогч, аллага үйлдсэн арга хэрэгслээр (We) Intentional homicide VICTIMS by mechanism of killing (We)</b>					
1.5.1		Галт зэвсэг эсвэл тэсэрч дэлбэрэх бодис Firearms or explosives		0	0	0
1.5.1.1	Санаатай аллагын хохирогчид (0101) халдсан: VICTIMS of intentional homicide(0101) attacked with;	Галт зэвсэг Firearm		8	3	3
1.5.2		Бусад буу зэвсэг Another weapon		0	0	0
1.5.2.1		Хурц иртэй зэвсэг Sharp object		76	73	65
1.5.3		Ямар ч зэвсэггүй/бусад механизм Without a weapon/ Other mechanism		10	81	55
1.5.4		Тодорхойгүй аргаар Unspecified		0	0	0

Солигддог үзүүлэлт  
Rotating variables

				2014	2015	2016	Нэмэлт тайлбар Additional comments
<b>1.6</b>	<b>Санаатай аллагын ХОХИРОГЧ, нас, хүйсээр (SV/AV) Intentional homicide victims by sex and age(SV/AV)</b>						
1.6.1a	Санаатай аллагын хохирогч (0101): Victims of intentional homicide	Эрэгтэй, насаар Males aged	0-9 настай 0 to 9	0	0	2	
1.6.2a			10-14 настай 10 to 14	0	0	3	
1.6.3a			15-17 настай 15 to 17	0	0	15	
1.6.4a			18-19 настай 18 to 19	0	0	20	
1.6.5a			20-24 настай 20 to 24	0	0	19	
1.6.6a			25-29 настай 25 to 29	0	0	20	
1.6.7a			30-44 настай 30 to 44	69	58	27	
1.6.8a			45-59 настай 45 to 49	47	47	29	
1.6.9a			60, түүнээс дээш 60 and older	9	8	10	
1.6.1b		Эмэгтэй, насаар Females aged	0-9 настай 0 to 9	0	0	1	
1.6.2b			10-14 настай 10 to 14	0	0	2	
1.6.3b			15-17 настай 15 to 17	0	0	5	
1.6.4b			18-19 настай 18 to 19	0	0		
1.6.5b			20-24 настай 20 to 24	0	0	5	
1.6.6b			25-29 настай 25 to 29	0	0	2	
1.6.7b			30-44 настай 30 to 44	26	15	7	
1.6.8b			45-59 настай 45 to 49	11	13	8	
1.6.9b			60, түүнээс дээш 60 and older	2	3	9	

<b>1.7 Санаатай аллагын ХОХИРОГЧ, харьяалал болон хүйсээр (Cit/SV)</b>							
<b>Intentional homicide victims by citizenship and sex</b>							
1.7.1a	Санаатай аллагын хохирогч (0101): Victims of intentional homicide	Дотоодын иргэн National citizens	Эрэгтэй Male	0	0	144	
1.7.1b			Эмэгтэй Female	0	0	39	
1.7.2a		Гадаадын иргэн Foreign citizens	Эрэгтэй Male	0	0	1	
1.7.2b			Эмэгтэй Female	0	0	0	
<b>1.8 Санаатай аллагын ХОХИРОГЧ, 3 том хотоор (Geo)</b>							
<b>Intentional homicide victims in three largest cities (Geo)</b>							
1.8.1	Санаатай аллагын хохирогч (0101): Victims of intentional homicide (0101)	Эхний том хот 1st largest city		114	113	87	
1.8.2		Хоёр дах том хот 2nd largest city		7	32	7	
1.8.3		Гурав дах том хот 3rd largest city		8	21	7	
1.8.1p	Хотын хүн амын тоо: Size of city population in:	Эхний том хот 1st largest city		0	0	1,380,792	Эхний том хотын нэр Name of 1st largest city
1.8.2p		Хоёр дах том хот 2nd largest city		0	0	97,646	Хоёр дах том хотын нэр Name of 2nd largest city
1.8.3p		Гурав дах том хот 3rd largest city		0	0	16,491	Гурав дах том хотын нэр Name of 3rd largest city
<b>1.9 Санаатай аллагын ХЭРЭГТЭН, нас, хүйсээр (SP/AP)</b>							
<b>Intentional homicide perpetrators by sex and age (SP/AP)</b>							
1.9.1a	Санаатай аллагын хэрэгт холбогдсон хүн (0101): Persons brought into formal Contact for intentional homicide:	Эрэгтэй, насаар Males aged	0-9 настай 0 to 9	0	0	0	
1.9.2a			10-14 настай 10 to 14	0	0	2	
1.9.3a			15-17 настай 15 to 17	0	5	17	
1.9.4a			18-19 настай 18 to 19	0	0	41	
1.9.5a			20-24 настай 20 to 24	0	0	24	
1.9.6a			25-29 настай 25 to 29	38	42	31	
1.9.7a			30-44 настай 30 to 44	90	94	22	
1.9.8a			45-59 настай 45 to 49	43	19	29	
1.9.9a			60, түүнээс дээш 60 and older	5	24	7	
1.9.1b		Эмэгтэй, насаар Females aged	0-9 настай 0 to 9	0	0	0	
1.9.2b			10-14 настай 10 to 14	0	0	0	
1.9.3b			15-17 настай 15 to 17	0	0	3	
1.9.4b			18-19 настай 18 to 19	0	0	5	
1.9.5b			20-24 настай 20 to 24	0	0	4	
1.9.6b			25-29 настай 25 to 29	5	3	1	
1.9.7b			30-44 настай 30 to 44	10	12	0	
1.9.8b			45-59 настай 45 to 49	1	1	0	
1.9.9b			60, түүнээс дээш 60 and older	6	4	1	

<b>1.10 Санаатай аллагын гэмт хэрэгтэн, иргэншил, хүйсээр(Cit/SP) Intentional homicide perpetrators by citizenship and sex (Cit/SP)</b>						
1.10.1a	Санаатай аллагын хэрэгт холбогдсон хүн (0101): Persons brought into formal Contact for intentional homicide:	Дотоодын иргэн National citizens	Эрэгтэй Male			178
1.10.1b			Эмэгтэй Female			14
1.10.2a	Persons brought into formal Contact for intentional homicide:	Гадаадын иргэн Foreign citizens	Эрэгтэй Male			
1.10.2b			Эмэгтэй Female			
<b>1.11 Санаатай аллагын ХЭРЭГТЭН, рецидив статусаар, хүйсээр (Rec/SP) Intentional homicide perpetrators by recidivist status and sex (Rec/SP)</b>						
1.11.1	Санаатай аллагын хэрэгт холбогдсон хүн (0101): Persons brought into formal Contact for intentional homicide:	Өмнө ямар нэг төрлийн гэмт хэргээр ял шийтгүүлсэн Previously convicted for any type of crime	Эрэгтэй Male	0	0	23
			Эмэгтэй Female	0	0	0
1.11.2		Өмнө ямар нэгэн гэмт хэргээр ял шийтгүүлж байгаагүй Not previously convicted for any type of crime	Эрэгтэй Male	0	0	169
			Эмэгтэй Female	0	0	0
1.11.3		Өмнө нь ял шийтгэгдсэн нь тогтоогдоогүй Recidivism unknown	Эрэгтэй Male	0	0	0
			Эмэгтэй Female	0	0	0
2-Хүчирхийллийн гэмт хэргийн мэдээлэл 2-Violent Crimes data				Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага Police or other law enforcement		

**Жилийн үзүүлэлт**  
Annual variables

		2014	2015	2016	Нэмэлт тайлбар Additional comments
<b>2.1</b>	<b>Хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан гэмт хэрэг Acts causing harm or intending to cause harm to the person</b>				
2.1.1	Хүнд хэлбэрийн танхайн (020111) гэмт хэргийн тоо Serious assault (020111) number of offences	8,132	8,064	1,892	
2.1.2	Хүн хулгайлах (020221), гэмт хэргийн тоо Kidnapping(020221) number of offences	0	0	3	
<b>2.2</b>	<b>Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл Injurious acts of a sexual nature</b>				
2.2.1	<b>Бэлгийн хүчирхийлэл (0301), гэмт хэргийн тоо Sexual violence(0301) number of offences</b>	353	359	290	
2.2.1.1	Хүчин (03011), гэмт хэргийн тоо Rape(03011) number of offences	300	279	290	
2.2.1.2	Бэлгийн дарамт (03012), гэмт хэргийн тоо Sexual assault (03012)number of offences	0	0	0	
2.2.1.3	Бэлгийн хүчирхийллийн бусад төрөл (03019), гэмт хэргийн тоо Other acts of sexual violence(03019)number of offences	0	0	0	
<b>2.3</b>	<b>Хүчирхийлэх, айлган сүрдүүлэх зэргээр бусдын эд хөрөнгийг дээрэмдэх Acts against property involving violence or threat against a person</b>				
2.3.1	Дээрэм (0401), гэмт хэргийн тоо Robbery(0401) number of offences	686	537	474	

Солигддог үзүүлэлт  
Rotating variables

				2014	2015	2016	Нэмэлт тайлбар Additional comments
<b>2.4</b>	<b>Хүнд хэлбэрийн танхайн хэргийн ХОХИРОГЧ, хохирогч-хэрэгтний хамаарал, хүйсээр (VIP/SV)</b> <b>Serious assault VICTIMS by victim-perpetrator relationship and sex(VIP/SV)</b>						
2.4.1a	Хүнд хэлбэрийн танхайн хэргийн хохирогч (020111): Victims serious assault(020111)	Ойр дотны хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүн (IPFM)	Эрэгтэй Male	0	0	8	
2.4.1b		Intimate partner or family member(IPFM)	Эмэгтэй Female	0	0	14	
2.4.2a		Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн	Эрэгтэй Male	0	0	354	
2.4.3a		Other perpetrator know to the victim	Эмэгтэй Female	0	0	145	
2.4.3b		Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн	Эрэгтэй Male	0	0	1,290	
		Perpetrator unknow to the victim	Эмэгтэй Female	0	0	149	
2.4.4a		Гэмт хэрэгтэн нь тодорхойгүй хамаарал нь тодорхой бус хэрэг	Эрэгтэй Male	0	0	25	
2.4.4b		Relationship to perpetrator is not know	Эмэгтэй Female	0	0	14	
<b>2.6</b>	<b>Бэлгийн хүчирхийллийн ХОХИРОГЧ, хохирогч-хэрэгтний хамаарал, хүйсээр (VIP/SV)</b> <b>Sexual violence VICTIMS by victim-perpetrator relationship and sex(VIP/SV)</b>						
2.5.1a	Бэлгийн хүчирхийллийн хохирогч (0301): Victims of sexual violence(0301) by	Ойр дотны хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүн (IPFM)	Эрэгтэй хохирогч	0	0	0	
2.5.1b		Intimate partner or family member(IPFM)	Эмэгтэй хохирогч	0	0	17	
2.5.2a		Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн	Эрэгтэй хохирогч	0	0	0	
2.5.2b		Other perpetrator know to the victim	Эмэгтэй хохирогч	0	0	121	
2.5.3a		Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн	Эрэгтэй хохирогч	0	0	0	
2.5.3b		Perpetrator unknow to the victim	Эмэгтэй хохирогч	0	0	116	
2.5.4a		Гэмт хэрэгтэн нь тодорхойгүй хамаарал нь тодорхой бус хэрэг	Эрэгтэй хохирогч	0	0	0	
2.5.4b		Relationship to perpetrator is not know	Эмэгтэй хохирогч	0	0	36	
2017 онд **2532** эмэгтэй гэмт хэрэгт холбогдон шалгагдсан бол **18148** эмэгтэй гэмт хэргийн улмаас хохирчээ.



2017 оны байдлаар **2942** хүн хорих ял эдэлж байгаагаас

**78.2%** (Хүнийг алах)  
**90.3%** (Халаасны хулгай)  
**85.0%** (Дээрэмдэх)

нь ажил эрхлээгүй байхдаа дээрх гэмт хэргийг үйлджээ.

**Хүчиндэх гэмт хэргээр 220** хүн хорих ял эдэлж байгаагаас

**76.0%** нь согтуугаар дээрх гэмт хэргийг үйлджээ.

## 4.1 ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ

## 4.1.1 ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-189	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан - 2002 оны ЭХТА-н 91 дүгээр зүйл-463 хэрэг - 2015 оны ЭХТА-н 10.1 дүгээр зүйл-109 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн - 2002 оны ЭХТА-н 91 дүгээр зүйл-168 хэрэг Шийдвэрлэлт-122 хэрэг - 2015 оны ЭХТА-н 10.1 дүгээр зүйл-101 хэрэг Шийдвэрлэлт-74 хэрэг


## Бүртгэгдсэн гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 189 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 15 хэргээр буюу 8.6 хувиар, Нийслэлийн хэмжээнд 27 хэргээр буюу 29.7 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	83	71	-14.5	47.7	37.6
Нийслэлд	91	118	29.7	52.3	62.4

Нийт 196 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 буюу 2.1 хувиар өссөн байна.

Үүнээс 25 буюу 12.7 хувь нь эмэгтэй, 171 буюу 87.3 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 78.6 хувь, эрэгтэй 4.1 хувиар тус тус өссөн байна.



Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 191 иргэн хохирч, үүнээс 169 хүн нас барж, 15 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 2 буюу 1.2 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 10 буюу 3.0 дахин өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 529.6 сая төгрөгийн хохирлоос 381.6 сая төгрөг буюу нийт хохирлын 72.0 хувийг нөхөн төлүүлж, 106.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор			Шүүх		
			91	10.1	Нийт	91	10.1	Нийт
<b>Орон нутаг</b>		<b>71</b>	<b>178</b>	<b>36</b>	<b>214</b>	<b>41</b>	<b>31</b>	<b>72</b>
1	Архангай	1	11	1	12	4	0	4
2	Баян-Өлгий	1	0	2	2	0	0	0
3	Баянхонгор	3	9	2	11	2	3	5
4	Булган	2	10	1	11	3	0	3
5	Говь-Алтай	0	0	0	0	0	0	0
6	Говьсүмбэр	1	2	1	3	2	0	2
7	Дархан-Уул	5	12	0	12	5	3	8
8	Дорноговь	5	14	4	18	2	0	2
9	Дорнод	6	11	3	14	3	0	3
10	Дундговь	3	6	1	7	0	0	0
11	Завхан	2	7	1	8	0	2	2
12	Орхон	2	13	2	15	5	3	8
13	Өвөрхангай	5	9	2	11	4	1	5
14	Өмнөговь	6	10	2	12	2	3	5
15	Сүхбаатар	2	4	2	6	2	3	5
16	Сэлэнгэ	10	13	3	16	3	5	8
17	Төв	2	17	0	17	0	4	4
18	Увс	1	3	0	3	1	0	1
19	Ховд	1	6	1	7	1	0	1
20	Хөвсгөл	8	12	4	16	0	3	3
21	Хэнтий	5	9	4	13	2	1	3
<b>Улаанбаатар хот</b>		<b>118</b>	<b>285</b>	<b>73</b>	<b>368</b>	<b>75</b>	<b>50</b>	<b>125</b>
1	Тээврийн ПГ	-	1	0	1	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	11	4	15	-	-	-
3	Багануур	1	5	1	6	0	0	0
4	Налайх, Багахангай	6	6	5	11	1	1	2
5	Баянгол	16	36	10	46	8	8	16
6	Баянзүрх	25	67	12	79	16	15	31
7	Сонгинохайрхан	32	63	11	74	26	11	37
8	Сүхбаатар	14	47	11	58	9	2	11
9	Хан-Уул	7	16	7	23	5	2	7
10	Чингэлтэй	17	33	12	55	10	11	21
<b>Улсын дүн</b>		<b>189</b>	<b>463</b>	<b>109</b>	<b>582</b>	<b>116</b>	<b>81</b>	<b>197</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан “Хүнийг санаатай алах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 463 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 285, орон нутагт нийт 178 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 294 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн 257, өөр хэрэгт нэгтгэгдсэн 26, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 3 байх бөгөөд нийт 6 хэрэг үлдэгдлээр тоологдсон байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 10.1 зүйлд заасан “Хүнийг алах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 109 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 73, орон нутагт нийт 36 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 92 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн 80, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 2 байх бөгөөд үлдэгдэл 10 хэрэг байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Хүнийг санаатай алах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 168 хэргийг шүүх хүлээн авснаас 122 хэргийг, “Хүнийг алах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 101 хэргийг хүлээн авснаас 74 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд нийт 269 хэргийг шүүхийн байгууллага шүүн таслахаар хүлээн авсанаас 1 хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож, 196 хэргийг эцэслэн шийдвэрлэжээ.

Үүнээс 2002 оны Эрүүгийн хуульд хамаарах 25 хэргийг мөрдөн байцаалтанд, 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 9 хэргийг прокурорт буцаасан бөгөөд нийт 30 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 208 хүн ял шийтгэгдсэн бөгөөд үүнээс 117 нь согтуугаар үйлдсэн байна. Нийт 206 хүнд хорих ял оногдуулсан бөгөөд үүнээс хүйсийн байдлаар авч үзвэл 13 эмэгтэй ял шийтгүүлсэн байна.

Улсын хэмжээнд “Хүнийг санаатай алах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд зааснаар 40, “Хүнийг алах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд зааснаар 1276 хүн хорих ял эдэлж байна.

“Хүнийг санаатай алах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд зааснаар 40 хоригдол ял эдэлж байгаагаас 11 нь буюу 27,5% нь ажил эрхэлж байсан бол 29 хоригдол буюу 72,5% нь ажилгүй байх үедээ дээрх гэмт хэргийг үйлдсэн байна. “Хүнийг алах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд зааснаар 1276 хүн хорих ял эдэлж байгаагаас 275 хоригдол буюу 21,6% нь ажил хөдөлмөр эрхэлж байхдаа, 1001 хоригдол буюу 78,4% нь ажилгүй байх үедээ дээрх гэмт хэргийг үйлдсэн байна.

## 4.1.2 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-8812	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан: - 2002 оны ЭХТА-н 15 дугаар бүлэг-14418 хэрэг - 2015 оны ЭХТА-н 11 дүгээр бүлэг-4061 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн: - 2002 оны ЭХТА-н 15 дугаар бүлэг-1511 хэрэг Шийдвэрлэлт-1403 хэрэг - 2015 оны ЭХТА-н 11 дүгээр бүлэг-2916 хэрэг Шийдвэрлэлт-2589 хэрэг

### Бүртгэгдсэн гэмт хэрэг


Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 8812 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 564 хэргээр буюу 6.8 хувиар, Нийслэлийн хэмжээнд 5392 бүртгэгдэж 434 хэргээр буюу 8.8 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	3282	3406	3.8	39.8	38.7
Нийслэлд	4958	5392	8.8	60.1	61.2
Бусад	8	14	75.0	0.1	0.1

Нийт 7267 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1236 буюу 14.5 хувиар буурсан байна.



Үүнээс 937 буюу 12.9 хувь нь эмэгтэй, 6330 буюу 87.1 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 15.7 хувь, эрэгтэй 14.4 хувиар тус тус буурсан байна.



Энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийт 8980 иргэн хохирч, үүнээс 22 хүн нас барж, 8024 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 15 буюу 3.1 дахин, гэмтсэн хүний тоо 93 буюу 1.0 хувиар тус тус өссөн байна.

Иргэдэд учирсан 7225.4 сая төгрөгийн хохирлоос 5150.1 сая төгрөг буюу нийт хохирлын 71.3 хувийг нөхөн төлүүлж, 1384.8 сая төгрөг битүүмжилсэн байна.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор			Шүүх		
			96-99	11.1-11.6	Нийт	96-99	11.1-11.6	Нийт
<b>Орон нутаг</b>		<b>3406</b>	<b>5362</b>	<b>1426</b>	<b>6788</b>	<b>763</b>	<b>1429</b>	<b>2192</b>
1	Архангай	158	265	73	338	15	59	74
2	Баян-Өлгий	171	253	94	347	18	77	95
3	Баянхонгор	231	245	94	339	40	93	133
4	Булган	120	164	66	230	9	52	61
5	Говь-Алтай	73	116	47	163	9	26	35
6	Говьсүмбэр	82	138	10	148	14	25	39
7	Дархан-Уул	233	396	102	498	53	88	141
8	Дорноговь	171	327	99	426	64	86	150
9	Дорнод	208	287	40	327	26	72	98
10	Дундговь	110	161	61	222	15	39	54
11	Завхан	68	122	24	146	9	38	47
12	Орхон	284	373	113	486	89	140	229
13	Өвөрхангай	139	237	31	268	42	50	92
14	Өмнөговь	176	272	91	363	47	84	131
15	Сүхбаатар	121	213	44	257	12	48	60
16	Сэлэнгэ	216	369	62	431	59	94	153
17	Төв	209	396	135	531	91	98	189
18	Увс	153	233	85	318	17	69	86
19	Ховд	126	215	43	258	27	54	81
20	Хөвсгөл	250	395	40	435	83	82	165
21	Хэнтий	107	185	72	257	24	55	79
<b>Улаанбаатар хот</b>		<b>5392</b>	<b>9056</b>	<b>2635</b>	<b>11691</b>	<b>535</b>	<b>1159</b>	<b>1694</b>
1	Тээврийн ПГ	-	40	20	60	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	27	8	35	-	-	-

3	Багануур	106	173	15	188	19	44	63
4	Налайх, Багахангай	167	322	120	442	32	36	68
5	Баянгол	985	1613	528	2141	105	181	286
6	Баянзүрх	1344	2245	586	2831	116	298	414
7	Сонгинохайрхан	876	1591	288	1879	77	137	214
8	Сүхбаатар	796	1182	443	1625	61	137	198
9	Хан-Уул	533	878	319	1197	65	122	187
10	Чингэлтэй	585	985	308	1293	60	204	264
<b>Улсын дүн</b>		<b>8798</b>	<b>14418</b>	<b>4061</b>	<b>18479</b>	<b>1298</b>	<b>2588</b>	<b>3886</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэгт заасан “Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96-99 дүгээр зүйлд холбогдуулан улсын хэмжээнд нийт 14418 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна.


Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 9056, орон нутагт нийт 5362 хэрэгт хяналт тавьжээ.

Нийт 13415 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 3458, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 9741, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 175, хэрэгсэхгүй болгосон хэрэг 5 байх бөгөөд үлдэгдлээр 29 хэрэг тоологдсон байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1-11.6 дугаар зүйлд холбогдуулан улсын хэмжээнд нийт 4061 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна.

### Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

(2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1-11.6 дугаар зүйл)



Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 2635, орон нутагт нийт 1426 хэрэгт хяналт тавьжээ.

Нийт мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьсан хэргээс хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан 972, хэрэг бүртгэлтэнд үлдэгдлээр 603 тоологдсон байна. Харин мөрдөн байцаалт явуулсан 2528 хэргээс шүүхэд шилжүүлсэн хэрэг 2315, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 53, хэрэгсэхгүй болгосон хэрэг 6, түдгэлзүүлсэн хэрэг 3 байх бөгөөд үлдэгдлээр 112 хэрэг тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

“Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 234 хэргийг хүлээн авснаас 189, 97 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 46 хэргийг хүлээн авснаас 44, 98 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 257 хэргийг хүлээн авснаас 242, 99 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 974 хэргийг хүлээн авснаас 928 буюу нийт 1511 хэргийг хүлээн авснаас 1403 хэргийг тус тус эцэслэн шийдвэрлэсэн байна.

“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлд зааснаар

зүйлчилсэн 194 хэргийг хүлээн авснаас 151, 11.2 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 7 хэргийг хүлээн авснаас 5, 11.3 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 35 хэргийг хүлээн авснаас 28, 11.4 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 347 хэргийг хүлээн авснаас 293, 11.5 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 7 хэргийг хүлээн авснаас 4, 11.6 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 2326 хэргийг хүлээн авснаас 2108 хэргийг буюу нийт 2916 хэргийг хүлээн авснаас 2589 хэргийг эцэслэн шийдвэрлэж, 14 хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгосон байна.

Мөн 2002 оны Эрүүгийн хуульд хамаарах 84 хэргийг мөрдөн байцаалтанд, хэрэг бүртгэлтэнд 9 хэргийг буцаасан бол 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 95 хэргийг прокурорт буцаасан байх бөгөөд нийт 238 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 3606 хүн шүүхээс ял шийтгэгдсэн бөгөөд гэмт хэрэг согтуугаар үйлдсэн 1338, эмэгтэй 354, хүүхэд 62 байна. Үүнийг ялын төрлөөр нь авч үзвэл хорих ял 518, баривчлах ял 126, нийтэд тустай ажил хийлгэх ял 443, албадан ажил хийлгэх ял 204, торгох ял 2274 тус тус оногдуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2017 оны байдлаар “Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлд зааснаар 35, 97 дугаар зүйлд зааснаар 3, 98 дугаар зүйлд зааснаар 1, 99 дүгээр зүйлд зааснаар 1 буюу нийт 40 хүн,

“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлд зааснаар 238, 11.2 дугаар зүйлд зааснаар 0, 11.3 дугаар зүйлд зааснаар 1, 11.4 дүгээр зүйлд зааснаар 5, 11.5 дугаар зүйлд зааснаар 0, 11.6 дугаар зүйлд зааснаар 3 буюу нийт 247 хүн хорих ял эдэлж байна.

## 4.1.3 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-1286	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан: - 2002 оны ЭХТА-н 120 <sup>1</sup> дугаар зүйл – 111 хэрэг - 2015 оны ЭХТА-н 11.7 дугаар зүйл – 199 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн: - 2002 оны ЭХТА-н 120 <sup>1</sup> дугаар зүйл – 0 хэрэг - 2015 оны ЭХТА-н 11.7 дугаар зүйл – 65 хэрэг Шийдвэрлэлт – 59 хэрэг


### Бүртгэгдсэн гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 1286 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 163 хэргээр буюу 11.2 хувиар буурч, бүх хэрэгт эзлэх хувийн жин 4.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгжээр буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	611	529	-13.4	42.2	41.1
Нийслэлд	838	757	-9.7	57.8	58.9


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 456 буюу 35.5 хувь нь согтуугаар, 75 буюу 5.8 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.

Улсын хэмжээнд 1269 буюу нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.9 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний учир холбогдон шалгагдсан ба тэдгээрийн 39.1 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.



- 3.3 хувь нь боловсролгүй,
- 7.3 хувь нь бага,
- 21.0 хувь нь суурь,
- 46.3 хувь нь бүрэн дунд,
- 3.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд,
- 18.3 хувь нь дээд боловсролтой хүн байна.

Мөн онд гэр бүлийн хүчирхийлэлд 1120 иргэн өртөж хохирсны 92.8 хувь нь эмэгтэй хүн байна.



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 599, хамтран амьдрагч 191, нөхөр 52, дагавар хүүхэд 39, төрсөн хүүхэд 38, төрсөн эцэг, эх 21, төрсөн дүү 10, төрсөн ах, эгч 7, хадам эцэг, эх 5, үрчилж авсан хүүхэд 1, бусад 157 хүн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 936 хүн гэмтэж, иргэдэд 640.6 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирснаас 69.3 хувийг нь нөхөн төлүүлжээ.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор			Шүүх		
			120 <sup>1</sup>	11.7	Нийт	120 <sup>1</sup>	11.7	Нийт
<b>Орон нутаг</b>		<b>529</b>	<b>62</b>	<b>56</b>	<b>118</b>	<b>7</b>	<b>37</b>	<b>44</b>
1	Архангай	21	4	3	7	0	2	2
2	Баян-Өлгий	30	0	1	1	0	0	0
3	Баянхонгор	34	0	1	1	0	4	4
4	Булган	15	2	10	12	0	3	3
5	Говь-Алтай	7	1	1	2	0	1	1
6	Говьсүмбэр	12	0	3	3	0	1	1
7	Дархан-Уул	50	11	4	15	2	2	4
8	Дорноговь	25	4	2	6	0	1	1
9	Дорнод	13	0	2	2	0	0	0
10	Дундговь	18	0	4	4	0	1	1
11	Завхан	11	0	1	1	1	3	4
12	Орхон	36	9	2	11	0	1	1
13	Өвөрхангай	31	6	4	10	0	5	5
14	Өмнөговь	17	4	8	12	2	5	7
15	Сүхбаатар	42	7	0	7	0	1	1
16	Сэлэнгэ	46	4	4	8	0	6	6
17	Төв	37	8	2	10	1	0	1
18	Увс	21	0	2	2	0	0	0
19	Ховд	15	0	0	0	0	0	0
20	Хөвсгөл	42	2	2	4	1	0	1
21	Хэнтий	6	0	0	0	0	1	1
<b>Улаанбаатар хот</b>		<b>757</b>	<b>49</b>	<b>143</b>	<b>192</b>	<b>3</b>	<b>18</b>	<b>21</b>
1	Тээврийн ПГ	-	0	0	0	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	0	0	0	-	-	-
3	Багануур	16	3	1	4	0	3	3
4	Налайх, Багахангай	19	2	10	12	0	2	2
5	Баянгол	120	6	20	26	1	1	2
6	Баянзүрх	196	10	9	19	2	1	3
7	Сонгинохайрхан	136	12	25	37	0	5	5
8	Сүхбаатар	84	2	27	29	0	1	1
9	Хан-Уул	114	5	32	37	0	2	2
10	Чингэлтэй	72	9	19	28	0	3	3
<b>Улсын дүн</b>		<b>1286</b>	<b>111</b>	<b>199</b>	<b>310</b>	<b>10</b>	<b>55</b>	<b>65</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дүгээр зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 111 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 49, орон нутагт нийт 62 хэрэгт хяналт тавьжээ.

Нийт 106 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 68, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 34, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 2 байх бөгөөд үлдэгдлээр 2 хэрэг тоологдсон байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 199 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 143, орон нутагт нийт 56 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 93 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 75, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 3, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн хэрэг 2 байх бөгөөд үлдэгдлээр 10 хэрэг тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн хэрэг хүлээн аваагүй бөгөөд харин 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 65 хэргийг хүлээн авснаас 59 хэргийг эцэслэн шийдвэрлэж, 2 хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Үүнээс 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 3 хэргийг прокурорт буцаасан бөгөөд нийт 6 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 29 хүн ял шийтгэгдсэн бөгөөд үүнээс 6 нь согтуугаар үйлдсэн байна. Үүнээс хорих ял 21, торгох ял 1, нийтэд тустай ажил хийлгэх ял 1, баривчлах ял 4-ийг тус тус оногдуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дугаар зүйлд зааснаар ял эдэлж байгаа хүн байхгүй бөгөөд 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд зааснаар 2 хүн хорих ял эдэлж байна.

## 4.1.4 ХУЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-376	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан: - 2002 оны ЭХТА-н 126 дугаар зүйл-649 хэрэгт - 2015 оны ЭХТА-н 12.1 дүгээр зүйл-255 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн: - 2002 оны ЭХТА-н 126 дугаар зүйл – 124 хэрэг Шийдвэрлэлт – 100 хэрэг - 2015 оны ЭХТА-н 12.1 дүгээр зүйл-132 хэрэг Шийдвэрлэлт-91 хэрэг



### Бүртгэгдсэн гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 376 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 86 хэргээр буюу 29.7 хувиар, Нийслэлийн хэмжээнд 62 хэргээр буюу 47.0 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	158	182	15.2	54.5	48.4
Нийслэлд	132	194	47.0	45.5	51.6

Нийт 304 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 буюу 6.2 хувиар буурсан байна.

Үүнээс 2 буюу 0.7 хувь нь эмэгтэй, 302 буюу 99.3 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 6.2 хувиар буурч, эмэгтэй өмнөх оны мөн үеийн түвшинд байна.



“Хүчиндэх” гэмт хэргийн улмаас 368 иргэн хохирч, үүнээс 1 хүн нас барж, 89 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 1 буюу 50.0 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 8 буюу 9.9 дахин өссөн байна.

Хохирогч иргэнд гэмт хэргийн улмаас учирсан 478.4 сая төгрөгийн хохирлоос 324.6 сая төгрөг буюу 67.9 хувийг нөхөн төлүүлж, 65.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор			Шүүх		
			126	12.1	Нийт	126	12.1	Нийт
<b>Орон нутаг</b>		<b>182</b>	<b>290</b>	<b>121</b>	<b>411</b>	<b>69</b>	<b>60</b>	<b>129</b>
1	Архангай	6	12	4	16	0	1	1
2	Баян-Өлгий	3	5	3	8	0	2	2
3	Баянхонгор	10	10	7	17	5	5	10
4	Булган	7	12	5	17	3	0	3
5	Говь-Алтай	4	4	6	10	2	1	3
6	Говьсүмбэр	2	7	1	8	3	1	4
7	Дархан-Уул	13	14	9	23	7	4	11
8	Дорноговь	11	16	8	24	6	0	6
9	Дорнод	9	19	6	25	9	2	11
10	Дундговь	3	3	3	6	1	0	1
11	Завхан	1	11	3	14	3	3	6
12	Орхон	22	28	14	42	6	4	10
13	Өвөрхангай	6	9	6	15	0	2	2
14	Өмнөговь	7	17	5	22	5	2	7
15	Сүхбаатар	3	11	0	11	0	2	2
16	Сэлэнгэ	14	31	4	35	11	5	16
17	Төв	19	33	13	46	5	11	16
18	Увс	11	10	9	19	3	6	9
19	Ховд	8	11	6	17	0	4	4
20	Хөвсгөл	18	17	5	22	0	3	3
21	Хэнтий	5	10	4	14	0	2	2
<b>Улаанбаатар хот</b>		<b>194</b>	<b>359</b>	<b>134</b>	<b>493</b>	<b>39</b>	<b>24</b>	<b>63</b>
1	Тээврийн ПГ	-	1	0	1	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	1	1	2	-	-	-
3	Багануур	5	12	3	15	2	0	2
4	Налайх, Багахангай	5	11	5	16	3	0	3
5	Баянгол	26	51	16	67	4	5	9
6	Баянзүрх	51	80	32	112	8	8	16
7	Сонгинохайрхан	41	88	26	114	7	0	7
8	Сүхбаатар	23	46	22	68	4	3	7
9	Хан-Уул	19	28	10	38	5	7	12
10	Чингэлтэй	24	41	19	60	6	1	7
<b>Улсын дүн</b>		<b>376</b>	<b>649</b>	<b>255</b>	<b>904</b>	<b>108</b>	<b>84</b>	<b>192</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлд заасан “Хүчиндэх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 649 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 359, орон нутагт нийт 290 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 476 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 343, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 98, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 22, хэрэгсэхгүй болгосон хэрэг 3 байх бөгөөд үлдэгдлээр 9 хэрэг тоологдсон байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан “Хүчиндэх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 255 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 134, орон нутагт нийт 121 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 111 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 89, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 6, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн хэрэг 1, хэрэгсэхгүй болгосон хэрэг 1 байх бөгөөд үлдэгдлээр 11 хэрэг тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Хүчиндэх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 124 хэргийг шүүх хүлээн авснаас 100 хэргийг, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 132 хэргийг хүлээн авснаас 91 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд нийт 256 хэргийг шүүхийн байгууллага шүүн таслахаар хүлээн авсанаас 2 хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож, 191 хэргийг эцэслэн шийдвэрлэжээ.


Үүнээс 2002 оны Эрүүгийн хуульд хамаарах 16 хэргийг мөрдөн байцаалтанд, 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 9 хэргийг прокурорт буцаасан бөгөөд нийт 37 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 220 хүн ял шийтгэгдсэн бөгөөд үүнээс 76 нь согтуугаар үйлдсэн байна. Нийт 216 хүнд хорих ял оногдуулсан бөгөөд үүнээс 16 хүүхдэд ял шийтгэл шийтгүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2017 оны байдлаар “Хүчиндэх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлд зааснаар 38, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд зааснаар 443 хүн хорих ял эдэлж байна. Үүнээс 94 хоригдол буюу 19,6% нь ажил хөдөлмөр эрхэлж байсан бол 387 хоригдол буюу 80,4% нь ажилгүй байсан байна. Гэрлэлтийн байдлыг харвал 113 хоригдол огт гэр бүлгүй байсан бол 201 нь хоригдол гэр бүлтэй, 44 хоригдол хамтран амьдардаг, 36 хоригдол гэр бүл салсан, 7 хоригдол бэлбэсэн байжээ.

*Зураг. Хүчиндэх гэмт хэргээр хорих ял эдэлж буй хоригдлууд, насны бүлэг, боловсролын түвшнээр*





## 4.1.5 ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-12	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан: - 2002 оны ЭХТА-н 113 дугаар зүйл-10 хэрэг - 2015 оны ЭХТА-н 13.1 дүгээр зүйл-6 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн: - 2002 оны ЭХТА-н 113 дугаар зүйл-1 хэрэг Шийдвэрлэлт-1 хэрэг - 2015 оны ЭХТА-н 13.1 дүгээр зүйл - 2 хэрэг Шийдвэрлэлт - 0 хэрэг

**Бүртгэгдсэн гэмт хэрэг**

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 12 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 9 хэргээр өссөн байх ба Нийслэлийн хэмжээнд 7, бусад газарт 5 тус тус бүртгэгдсэн байна.


	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Бусад газарт	1	5	5 дахин	33.3	41.6
Нийслэлд	2	7	3.5 дахин	66.6	58.3

Нийт 4 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2-оор буюу 33.3 хувь буурсан. Харин 2016 онд энэ төрлийн гэмт хэрэгт хүүхэд холбогдсон тохиолдол 1 бүртгэгдэж байсан бол энэ онд бүртгэгдээгүй байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 9 иргэнд нийт 1.5 сая төгрөгийн хохирол учирсан байна.

**Прокурорын хяналт**

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 10 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна.

**Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг**

Үүнээс нийт 9 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 5, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 2, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 1, үлдэгдлээр 1 хэрэг тоологдсон байх ба хэрэгсэхгүй болгосон хэрэг байхгүй байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 6 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна.

Үүнээс хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан 4, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж байгаа буюу үлдэгдлээр 1 хэрэг тоологдсон байна.

Харин 1 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж шүүхэд шилжүүлсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийг өөр хэрэгт нэгтгэсэн, хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн тохиолдол гараагүй байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 1 хэргийг шүүхэд шилжүүлсэн боловч шүүхээс мөрдөн байцаалтанд буцааж шийдвэрлэсэн байна. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 2 хэргийг хүлээн авсан бөгөөд үүнээс 1 хэргийг прокурорт буцааж, 1 хэрэг үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2017 оны байдлаар “Хүн худалдаалах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд зааснаар 0, “Хүн худалдаалах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд зааснаар 6 хүн хорих ял эдэлж байна.

## 4.1.6 ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-12222	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан:  - 2002 оны ЭХТА-н 145 дугаар зүйл-17948 хэрэг  - 2015 оны ЭХТА-н 17.1 дүгээр зүйл-7193 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн:  - 2002 оны ЭХТА-н 145 дугаар зүйл-1098 хэрэг Шийдвэрлэлт-995 хэрэг  - 2015 оны ЭХТА-н 17.1 дүгээр зүйл-565 хэрэг Шийдвэрлэлт-421 хэрэг

### Бүртгэгдсэн гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 12222 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3157 хэргээр буюу 34.8 хувиар, Нийслэлийн хэмжээнд 309 хэргээр буюу 26.4 хувиар тус тус өссөн бөгөөд 2017 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хэргийн 37.9 хувийг эзэлж байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	2966	3549	19.7	32.7	29.1
Нийслэлд	6098	8667	42.1	67.3	70.9
Бусад	1	6	6.0 дахин	0.0	0.0

### Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 9942 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2639 хэргээр буюу 36.1 хувиар, Нийслэлийн хэмжээнд 2187 хэргээр буюу 41.1 хувиар тус тус өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг нутаг дэвсгэрийн байдлаар авч үзвэл 2017 онд орон нутагт 2431 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 447 хэргээр буюу 22.5 хувиар, нийслэлд 7506 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 2187 хэргээр буюу 41.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн орон нутагт үйлдэгдсэн нийт

хэргийн 19.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 2 хувиар буурсан, нийслэл үйлдэгдсэн нийт хэргийн 61.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 2.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 901 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 96 хэргээр буюу 11.9 хувиар өсч, Нийслэлийн хэмжээнд 32 хэргээр буюу 28.3 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг нутаг дэвсгэрийн байдлаар авч үзвэл 2017 онд орон нутагт 820 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 129 хэргээр буюу 18.7 хувиар өссөн, нийслэлд 81 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 32 хэргээр буюу 28.3 хувиар буурсан бусад газарт 2016 онд 1 хэрэг бүртгэгдэж байсан бол 2017 онд бүртгэгдээгүй үзүүлэлттэй байна. Энэ нь эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн орон нутагт үйлдэгдсэн нийт хэргийн 6.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.9 хувиар, нийслэл үйлдэгдсэн нийт хэргийн 0.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал


Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 369 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 35 хэргээр буюу 8.7 хувиар буурч, Нийслэлийн хэмжээнд 24 хэргээр буюу 18.5 хувиар өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг нутаг дэвсгэрийн байдлаар авч үзвэл 2017 онд орон нутагт 215 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 59 хэргээр буюу 21.5 хувиар буурсан, нийслэлд 154 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 24 хэргээр буюу 18.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн орон нутагт үйлдэгдсэн нийт хэргийн 1.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.3 хувиар, нийслэл үйлдэгдсэн нийт хэргийн 1.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### Халаасны хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 873 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 335 хэргээр буюу 62.3 хувиар, Нийслэлийн хэмжээнд 311 хэргээр буюу 58.5 хувиар тус тус өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг нутаг дэвсгэрийн байдлаар авч үзвэл 2017 онд орон нутагт 29 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 23 хэргээр буюу 4.8 дахин, нийслэлд 843 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 311 хэргээр буюу 58.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн орон нутагт үйлдэгдсэн нийт хэргийн 0.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.14 хувиар, нийслэл үйлдэгдсэн нийт хэргийн 6.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хулгайлах гэмт хэрэгт холбогдуулан нийт 4497 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1646 буюу 26.8 хувиар буурсан байна.

Үүнээс 377 буюу 8.4 хувь нь эмэгтэй, 4120 буюу 91.6 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 33.7 хувиар, эрэгтэй 26.1 хувиар тус тус буурсан байна.



Хулгайлах гэмт хэргийн улмаас 11378 иргэн, 17 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 2204 буюу 24.0 хувиар өсч, хуулийн этгээд 1 буюу 5.6 хувиар буурсан байна.

Хэргийн улмаас учирсан 19034.4 сая төгрөгийн хохирлын 32.1 хувийг нөхөн төлүүлж, 1057.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор			Шүүх		
			145	17.1	Нийт	145	17.1	Нийт
<b>Орон нутаг</b>		<b>3549</b>	<b>5561</b>	<b>1468</b>	<b>7029</b>	<b>567</b>	<b>245</b>	<b>812</b>
1	Архангай	227	439	73	512	29	5	34
2	Баян-Өлгий	69	104	40	144	5	5	10
3	Баянхонгор	191	244	74	318	35	10	45
4	Булган	130	226	61	287	0	5	5
5	Говь-Алтай	69	116	36	152	14	14	28
6	Говьсүмбэр	46	83	7	90	0	2	2
7	Дархан-Уул	268	396	124	520	52	24	76
8	Дорноговь	206	355	88	443	38	17	55
9	Дорнод	193	281	68	349	9	9	18
10	Дундговь	51	149	22	171	12	1	13
11	Завхан	89	173	33	206	19	5	24
12	Орхон	313	370	178	548	46	20	66
13	Өвөрхангай	214	417	64	481	18	12	30
14	Өмнөговь	80	117	39	156	24	8	32
15	Сүхбаатар	125	147	68	215	12	21	33
16	Сэлэнгэ	178	274	53	327	38	15	53
17	Төв	313	466	130	596	51	12	63
18	Увс	116	214	34	248	20	10	30
19	Ховд	162	229	44	273	41	18	59
20	Хөвсгөл	300	475	144	619	60	12	72
21	Хэнтий	209	286	88	374	44	20	64
<b>Улаанбаатар хот</b>		<b>8667</b>	<b>12387</b>	<b>5725</b>	<b>18112</b>	<b>360</b>	<b>176</b>	<b>536</b>
1	Тээврийн ПГ	-	58	20	78	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	95	3	98	-	-	-
3	Багануур	74	126	32	158	7	2	9
4	Налайх, Багахангай	133	189	95	284	10	1	11
5	Баянгол	829	1588	532	2120	33	18	51
6	Баянзүрх	2694	3325	1849	5174	81	35	116
7	Сонгинохайрхан	1645	1901	1067	2968	61	26	87
8	Сүхбаатар	1479	2225	1080	3305	54	23	77
9	Хан-Уул	645	1031	401	1432	39	23	62
10	Чингэлтэй	1168	1849	646	2495	75	48	123
<b>Улсын дүн</b>		<b>12216<sup>1</sup></b>	<b>17948</b>	<b>7193</b>	<b>25141</b>	<b>927</b>	<b>421</b>	<b>1348</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 17948 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 12387, орон нутагт нийт 5561 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 10403 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 2067, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 4786, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 3428, хэрэгсэхгүй болгосон 20 байх бөгөөд үлдэгдлээр 72 хэрэг тоологдсон байна.

<sup>1</sup> Цагдаагийн байгууллагын бүртгэлд бусад газарт 6 гэмт хэрэг гэж бүртгэгдсэн.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 7193 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 5725, орон нутагт нийт 1471 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 2231, үлдэгдлээр хэрэг бүртгэлтэнд 4087 хэрэг тоологдсон байна. Харин нийт 913 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 569, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 28, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн хэрэг 116, хэрэгсэхгүй болгосон хэрэг 6 байх бөгөөд үлдэгдлээр 158 хэрэг тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 1098 хэргийг шүүх хүлээн авснаас 995 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шатанд 110 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Харин “Хулгайлах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд зааснаар зүйлчилсэн 565 хэргийг шүүх хүлээн авснаас 421 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шатанд 1 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Мөн 2002 оны Эрүүгийн хуульд хамаарах 65 хэргийг мөрдөн байцаалтанд, 11 хэргийг хэрэг бүртгэлтэнд буцаасан бол 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 46 хэргийг прокурорт буцааж 6 хэргийг түдгэлзүүлсэн байх бөгөөд нийт 111 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.


### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 1862 хүн ял шийтгэгдсэн бөгөөд үүнээс 128 нь согтуугаар үйлдсэн, 104 нь эмэгтэй хүн үйлдсэн, 230 нь хүүхэд үйлдсэн байна. Үүнээс хорих ял 1329, баривчлах ял 268, нийтэд тустай ажил хийлгэх ял 153, албадан ажил хийлгэх ял 24, торгох ял 29 тус тус оногдуулсан байна.

2017 оны байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд зааснаар 153, “Хулгайлах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд зааснаар 239 хүн хорих ял эдэлж байна. Үүнээс 38 хоригдол буюу 9,7% нь ажил хөдөлмөр эрхэлж байсан бол 354 хоригдол буюу 90,3% нь ажилгүй байсан байна.

Гэрлэлтийн байдлыг авч үзвэл 216 хоригдол огт гэр бүлгүй байсан бол 118 нь хоригдол гэр бүлтэй, 36 хоригдол хамтран амьдардаг, 20 хоригдол гэр бүл салсан, 2 хоригдол тусгаарласан, 1 хоригдол бэлбэсэн байжээ.

Зураг. Хулгайлах гэмт хэргээр хорих ял эдэлж буй хоригдлууд, насны бүлэг, боловсролын түвшнээр



## 4.1.7 ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГ

**ЦАГДАА**

Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-1233

**ПРОКУРОР**

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан:

- 2002 оны ЭХТА-н 146 дугаар зүйл-353 хэрэг
- 2002 оны ЭХТА-н 147 дугаар зүйл-1748 хэрэг
- 2015 оны ЭХТА-н 17.2 дугаар зүйл – 985 хэрэг

**ШҮҮХ**

Хүлээн авч шийдвэрлэсэн:

- 2002 оны ЭХТА-н 147 дугаар зүйл – 135 хэрэг
- Шийдвэрлэлт – 118 хэрэг
- 2015 оны ЭХТА-н 17.2 дугаар зүйл – 97 хэрэг
- Шийдвэрлэлт – 70 хэрэг



**Бүртгэгдсэн гэмт хэрэг**

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 1233 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 759 хэргээр буюу 2.6 дахин, Нийслэлийн хэмжээнд 677 хэргээр буюу 2.7 дахин тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	70	152	2.2 дахин	14.8	12.3
Нийслэлд	404	1081	2.7 дахин	85.2	87.7

Нийт 473 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39 буюу 7.6 хувиар буурсан байна.

Үүнээс 16 буюу 3.4 хувь нь эмэгтэй, 457 буюу 96.6 хувь нь эрэгтэй, тэдний 141 буюу 29.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 8.8 хувиар буурсан, эмэгтэй 45.4 хувиар, хүүхэд 8.5 хувиар тус тус өссөн байна.



Дээрэмдэх гэмт хэргийн улмаас 1062 иргэн хохирч, үүнээс 161 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмтсэн хүний тоо 12 буюу 6.9 хувиар буурсан байна.

Иргэдэд 862.8 сая төгрөгийн хохирол учирснаас 341.9 сая төгрөг буюу нийт хохирлын 39.6 хувийг нөхөн төлүүлж, 26.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор				Шүүх		
			146	147	17.2	Нийт	146, 147	17.2	Нийт
	<b>Орон нутаг</b>	<b>152</b>	<b>35</b>	<b>179</b>	<b>91</b>	<b>305</b>	<b>45</b>	<b>31</b>	<b>76</b>
1	Архангай	3	0	7	3	10	2	1	3
2	Баян-Өлгий	2	0	2	1	3	0	1	1
3	Баянхонгор	10	1	7	5	13	2	1	3
4	Булган	1	0	3	1	4	1	0	1
5	Говь-Алтай	0	1	2	2	5	1	1	2
6	Говьсүмбэр	1	1	1	0	2	1	0	1
7	Дархан-Уул	32	10	48	23	81	5	6	11
8	Дорноговь	5	3	7	4	14	4	3	7
9	Дорнод	16	3	14	8	25	3	3	6
10	Дундговь	3	0	2	3	5	0	0	0
11	Завхан	1	1	1	1	3	0	0	0
12	Орхон	31	3	20	24	47	10	3	13
13	Өвөрхангай	7	2	10	4	16	3	0	3
14	Өмнөговь	3	0	4	0	4	1	0	1
15	Сүхбаатар	1	0	5	1	6	2	2	4
16	Сэлэнгэ	8	3	15	2	20	6	3	9
17	Төв	7	2	8	4	14	1	1	2
18	Увс	0	0	2	1	3	0	0	0
19	Ховд	0	0	2	0	2	0	0	0
20	Хөвсгөл	18	1	16	3	20	2	2	4
21	Хэнтий	3	4	3	1	8	1	4	5
	<b>Улаанбаатар хот</b>	<b>1081</b>	<b>318</b>	<b>1570</b>	<b>894</b>	<b>2782</b>	<b>87</b>	<b>50</b>	<b>137</b>
1	Тээврийн ПГ	-	0	2	3	5	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	2	6	0	8	-	-	-
3	Багануур	3	0	4	2	6	1	0	1
4	Налайх, Багахангай	3	1	2	5	8	3	0	3
5	Баянгол	206	86	241	163	490	13	8	21
6	Баянзүрх	337	69	494	259	822	18	17	35
7	Сонгинохайрхан	190	45	304	144	493	16	11	27
8	Сүхбаатар	181	53	251	185	489	11	6	17
9	Хан-Уул	51	13	82	54	149	4	3	7
10	Чингэлтэй	110	49	184	79	312	21	5	26
	<b>Улсын дүн</b>	<b>1233</b>	<b>353</b>	<b>1749</b>	<b>985</b>	<b>3087</b>	<b>132</b>	<b>81</b>	<b>213</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг булаах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 353 хэрэгт прокурорын хяналт байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 318, орон нутагт нийт 35 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 262 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 34, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 165, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 43 байх бөгөөд үлдэгдэл хэрэг байхгүй тоологдсон байна.

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 1748 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 1570, орон нутагт нийт 178 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 640 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 298, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 157, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 162, хэрэгсэхгүй болгосон хэрэг 5 байх бөгөөд үлдэгдлээр 14 хэрэг

тоологдсон байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлд заасан “Дээрэмдэх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 985 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 894, орон нутагт нийт 91 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 157 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 95, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 5, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн хэрэг 12, хэрэгсэхгүй болгосон хэрэг 1 байх бөгөөд үлдэгдлээр 41 хэрэг тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 135 хэргийг шүүх хүлээн авснаас 118 хэргийг, харин “Дээрэмдэх” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 97 хэргийг хүлээн авснаас 70 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд нийт 232 хэргийг шүүхийн байгууллага шүүн таслахаар хүлээн авсанаас 2 хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож, 188 хэргийг эцэслэн шийдвэрлэжээ.

Үүнээс 2002 оны Эрүүгийн хуульд хамаарах 14 хэргийг мөрдөн байцаалтанд, 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 6 хэргийг прокурорт буцаасан бөгөөд нийт 22 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.


### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 355 хүн ял шийтгэгдсэн бөгөөд үүнээс 47 нь согтуугаар үйлдсэн, 11 нь эмэгтэй хүн үйлдсэн, 56 нь хүүхэд үйлдсэн байна. Нийт 19 хүнд хорих ял оногдуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2017 оны байдлаар “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлд зааснаар 23, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлд зааснаар 178 хүн хорих ял эдэлж байна. Үүнээс 31 хоригдол буюу 15,4% нь ажил хөдөлмөр эрхэлж байсан бол 170 хоригдол буюу 85,6% нь ажилгүй байсан байна. Гэрлэлтийн байдлыг харвал 146 хоригдол огт гэр бүлгүй байсан бол 37 нь хоригдол гэр бүлтэй, 12 хоригдол хамтран амьдардаг, 5 хоригдол салсан, 1 хоригдол тусгаарласан байсан байна.

Харин хорих ял эдэлж буй хоригдлуудыг боловсролын байдлаар авч үзвэл дээд боловсролтой 5, техник мэргэжлийн 12, бүрэн дунд 98, бүрэн дунд бус 44, бага 20, боловсролгүй 21 байна.

Зураг. Дээрэмдэх гэмт хэргээр хорих ял эдэлж буй хоригдлууд, насны бүлгээр





## 4.1.8 ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГ

ЦАГДАА	ПРОКУРОР	ШҮҮХ
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-2996	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан: - 2002 оны ЭХТА-н 148 дугаар зүйл – 4362 хэрэг - 2015 оны ЭХТА-н 17.3 дугаар зүйл – 2030 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн: - 2002 оны ЭХТА-н 148 дугаар зүйл-220 хэрэг Шийдвэрлэлт-142 хэрэг - 2015 оны ЭХТА-н 17.3 дугаар зүйл- 223 хэрэг Шийдвэрлэлт -131 хэрэг



## Бүртгэгдсэн гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 2996 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 831 хэргээр буюу 38.4 хувиар, Нийслэлийн хэмжээнд 751 хэргээр буюу 39.4 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2016	2017		2016	2017
Орон нутагт	254	330	29.9	11.7	11.0
Нийслэлд	1908	2659	39.4	88.2	88.8
Бусад газарт	3	7	2.3 дахин	0.1	0.2

Нийт 1064 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 746 буюу 41.2 хувиар буурсан байна.

Үүнээс 405 буюу 38.1 хувь нь эмэгтэй, 659 буюу 61.9 хувь нь эрэгтэй, тэдний 34 буюу 3.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 40.7 хувь, эмэгтэй 42.0 хувь, хүүхэд 22.7 хувиар тус тус буурсан байна.



Энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийт 9275 иргэн, 4 хуулийн этгээд хохирч, өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 7039 буюу 4.1 дахин өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан 123178.6 сая төгрөгийн хохирлоос 48403.6 сая төгрөг буюу нийт хохирлын 39.3 хувийг нөхөн төлүүлж, 26555.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

№	Нутаг дэвсгэр	Цагдаа	Прокурор			Шүүх		
			148	17.3	Нийт	148	17.3	Нийт
<b>Орон нутаг</b>		<b>340</b>	<b>389</b>	<b>236</b>	<b>625</b>	<b>46</b>	<b>41</b>	<b>87</b>
1	Архангай	14	21	8	29	0	1	1
2	Баян-Өлгий	7	11	5	16	1	4	5
3	Баянхонгор	14	12	9	21	2	0	2
4	Булган	9	2	11	13	0	0	0
5	Говь-Алтай	8	7	8	15	1	0	1
6	Говьсүмбэр	2	9	1	10	1	0	1
7	Дархан-Уул	44	97	26	123	18	12	30
8	Дорноговь	24	24	12	36	1	0	1
9	Дорнод	15	18	10	28	3	0	3
10	Дундговь	3	14	5	19	2	0	2
11	Завхан	2	3	2	5	0	0	0
12	Орхон	71	35	51	86	5	7	12
13	Өвөрхангай	17	7	5	12	0	0	0
14	Өмнөговь	17	21	13	34	1	3	4
15	Сүхбаатар	11	7	12	19	1	1	2
16	Сэлэнгэ	21	16	11	27	1	3	4
17	Төв	19	33	18	51	4	2	6
18	Увс	4	3	3	6	1	1	2
19	Ховд	6	14	1	15	2	2	4
20	Хөвсгөл	21	13	15	28	1	3	4
21	Хэнтий	11	22	10	32	1	2	3
<b>Улаанбаатар хот</b>		<b>2659</b>	<b>3973</b>	<b>1795</b>	<b>5768</b>	<b>95</b>	<b>94</b>	<b>189</b>
1	Тээврийн ПГ	-	3	4	7	-	-	-
2	Нийслэлийн ПГ	-	278	45	323	-	-	-
3	Багануур	17	14	12	26	0	2	2
4	Налайх, Багахангай	24	45	21	66	1	3	4
5	Баянгол	511	810	314	1124	22	16	38
6	Баянзүрх	635	774	404	1178	19	19	38
7	Сонгинохайрхан	286	329	187	516	4	4	8
8	Сүхбаатар	613	800	424	1224	21	20	41
9	Хан-Уул	196	301	154	455	3	9	12
10	Чингэлтэй	377	619	230	849	25	21	46
<b>Улсын дүн</b>		<b>2999</b>	<b>4362</b>	<b>2031</b>	<b>6393</b>	<b>141</b>	<b>135</b>	<b>276</b>

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 4362 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 3973, орон нутагт нийт 389 хэрэгт прокурорын хяналт тавьжээ.

Үүнээс нийт 3309 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 407, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 1794, мөрдөн байцаалтын ажиллагаа түдгэлзүүлсэн хэрэг 1015, хэрэгсэхгүй болгосон хэрэг 14 байх бөгөөд үлдэгдэл 69 хэрэг байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 2030 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 1795, орон нутагт нийт 235 хэрэгт хяналт тавьжээ.

Үүнээс нийт 303 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьснаас шүүхэд шилжүүлсэн хэрэг 176, өөр хэрэгт нэгтгэгдсэн хэрэг 19, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн хэрэг 23, хэрэгсэхгүй болгосон хэрэг 1 байх бөгөөд үлдэгдлээр 56 хэрэг тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 220 хэргийг шүүх хүлээн авснаас 142 хэргийг, “Залилах” буюу 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 223 хэргийг хүлээн авснаас 131 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд нийт 443 хэргийг шүүхийн байгууллага шүүн таслахаар хүлээн авсанаас 26 хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож, 273 хэргийг эцэслэн шийдвэрлэжээ.

Үүнээс 2002 оны Эрүүгийн хуульд хамаарах 61 хэргийг мөрдөн байцаалтанд, 2 хэргийг хэрэг бүртгэлтэнд, 2015 оны Эрүүгийн хуульд хамаарах 43 хэргийг прокурорт буцаасан бөгөөд нийт 30 хэрэг дараа онд үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож нийт 237 хүн ял шийтгэгдсэн бөгөөд үүнээс 19 нь согтуугаар үйлдсэн байна. Нийт 153 хүнд хорих ял, 46 хүнд торгох ял, 2 хүнд албадан ажил хийлгэх, 12 хүнд нийтэд тустай ажил хийлгэх, 19 хүнд баривчлах ял тус тус оногдуулсан бөгөөд 97 эмэгтэй хүнд, 1 хүүхдэд ял шийтгэл шийтгүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2017 оны байдлаар “Залилах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд зааснаар 7, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд зааснаар 50 хүн тус тус хорих ял эдэлж байна. Үүнээс 25 хоригдол буюу 43,9% нь ажил хөдөлмөр эрхэлж байсан бол 32 хоригдол буюу 56,1% нь ажилгүй байсан байна. Гэрлэлтийн байдлыг харвал 14 хоригдол огт гэр бүлгүй байсан бол 24 хоригдол гэр бүлтэй, 7 хоригдол хамтран амьдардаг, 7 хоригдол гэр бүл салсан, 3 хоригдол тусгаарласан, 2 хоригдол бэлбэсэн байсан байна.

Зураг. Залилах гэмт хэргээр хорих ял эдэлж буй хоригдлууд, насны бүлгээр



## 4.1.9 ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРЭГ

### ЦАГДАА

Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-20

### ПРОКУРОР

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан:

- 2002 оны ЭХТА-н 166 дугаар зүйл-52 хэрэг
- 2015 оны ЭХТА-н 18.3 дугаар зүйл-16 хэрэг

### ШҮҮХ

Хүлээн авч шийдвэрлэсэн:

- 2002 оны ЭХТА-н 166 дугаар зүйл-168 хэрэг Шийдвэрлэлт-122 хэрэг
- 2015 оны ЭХТА-н 18.3 дугаар зүйл-1 хэрэг Шийдвэрлэлт-0 хэрэг

### Бүртгэгдсэн гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 20 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 13 хэргээр буюу 2.8 дахин, Нийслэлийн хэмжээнд 17 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 12 хэргээр буюу 3.4 дахин өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2016	2017	
Орон нутагт	2	3	1.5 дахин
Нийслэлд	5	17	3.4 дахин

Улсын хэмжээнд 2016 оны байдлаар нийт 71 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан бол 2017 онд 12 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59 буюу 5.9 дахин буурсан байна.

Үүнээс 7 буюу 58.3 хувь нь эмэгтэй, 5 буюу 41.6 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 9 буюу 1.2 дахин буурсан байна.

### Прокурорын хяналт

Прокурорын байгууллагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан “Татвар төлөхөөс зайлсхийх” гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 52 хэрэгт прокурорын хяналт тавьсан байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 47, орон нутагт нийт 5 хэрэгт хяналт тавьжээ.

### Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг



Үүнээс хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан 13, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж байгаа буюу үлдэгдлээр 2 хэрэг тоологдсон байна. Харин мөрдөн байцаалт явуулсан 1 хэрэг үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас мөрдөн байцаалт явуулж дуусгасан “Татвар төлөхөөс зайлсхийх” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 3 хэргийг шүүх хүлээн авснаас 1 хэргийг эцэслэн шийдвэрлэж, 2 хэргийг мөрдөн байцаалтанд буцаасан бол 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлд зааснаар зүйлчилсэн 1 хэргийг хүлээн авсан нь үлдэгдлээр тоологдсон байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн нийт 4 хэргийг шүүхийн байгууллага шүүн таслахаар хүлээн авсанаас 1 хэргийг эцэслэн шийдвэрлэж, 2 хэргийг мөрдөн байцаалтанд буцааж, 1 хэрэг нь үлдэгдлээр тоологдсон байна.

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож ял шийтгэгдсэн хүн байхгүй байна.

## 4.1.10 МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ

<b>ЦАГДАА</b>	<b>ПРОКУРОР</b>	<b>ШҮҮХ</b>
Шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг-4	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан: - 2002 оны ЭХТА-н 166 <sup>1</sup> дугаар зүйл-34 хэрэг - 2015 оны ЭХТА-н 18.6 дугаар зүйл-10 хэрэг	Хүлээн авч шийдвэрлэсэн: - 2002 оны ЭХТА-н 166 <sup>1</sup> дугаар зүйл-0 хэрэг Шийдвэрлэлт-0 хэрэг - 2015 оны ЭХТА-н 18.6 дугаар зүйл-1 хэрэг Шийдвэрлэлт-1 хэрэг

**Бүртгэгдсэн гэмт хэрэг**

Судалгааны байгууллагаас хийсэн 1994-2008 оны гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн суурь судалгаа, Засгийн газраас баталж хэрэгжүүлсэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цагдаа олон нийтийн хамтын ажиллагаатай холбоотой хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг “Сайн” гэж дүгнэж байсан бол 2012-2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдээгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн төлөвлөгөө байхгүй, энэ чиглэлээр нийслэл, орон нутагт зохион байгуулсан ажил 17-20 хувиар буурсан нь хуулийн хэрэгжилт хангагдаагүй мэт харагдаж байна.

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл дахин байгуулагдснаар 2017 онд 5 зорилтын хүрээнд 53 ажил төлөвлөн гүйцэтгэн ажиллажээ.

Гүйцэтгэсэн ажлаас дурдвал Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх, Хүн худалдаах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт батлуулсан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх”, “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” Дэд зөвлөлийг байгуулан тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж зохион байгуулж, салбар дундын зохицуулалтыг сайжруулснаар тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн олон салбарын хамтын ажиллагааг хангах бодит хэрэгцээ шаардлага бий болсон байна. Учир нь ямар нэгэн шийдвэр чиглэлийг үл харгалзан иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнээс урган гарсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэж байна.

Жишээ нь: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарим төрийн бус байгууллагууд хангалттай түвшинд мэргэшсэн, зарим талаар хууль сахиулах, төрийн байгууллагуудад зөвлөх хэмжээнд хүрчээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь олон нийтийн хүчинд түшиглэх, ялангуяа иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцох, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах үүрэгтэй боловч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо туйлын хангалтгүй гагцхүү цагдаагийн байгууллагын хариуцан гүйцэтгэх үүрэг гэсэн хэвшмэл хандлага өнөөг болтол байсаар байна.

Энэ хандлага нь иргэд, байгууллагын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлт, дадал хэвшлийг бууруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр дүн хангалтгүй байх шалтгаан болж байна.

Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, иргэдийн санал, санаачлагыг дэмжих, идэвхижүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгцээ шаардлагыг судалсны эцэст эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийгмийн олон салбарын хамтын ажиллагааг хангах, төсөв зардлыг шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал юм. Тухайлбал:

Жилд дунджаар гэмт хэргийн улмаас 25000 орчим хүн хохирч, 150 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч байгаа боловч урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах зардлын үнэлгээ, төсөв зардлын нэгдсэн төсөөлөл одоог хүртэл шинжлэх ухааны үндэслэлтэй хийгдээгүй байна.


## 6.2 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг Засгийн газар жил бүр улсын төсөвт тусгайлан тусгаж байхаар заажээ. Үүний дагуу 2015 онд 607.9 сая төгрөг, 2016 онд 1,367.0 сая төгрөг, 2017 онд 1,800.8 сая төгрөгийг тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсөвт тусгажээ.


Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх”-ээр заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд орон, нутгийн төсвөөс санхүүжүүлэн олгосон хөрөнгийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, зарцуулж иржээ.

Энэ заалтын дагуу 2015 онд 4,720.4 сая, 2016 онд 6,830.8 сая, 2017 онд 6,655.0 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт тусгажээ.

**График 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, сая.төг**



“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэхэд зориулан зарцуулах хөрөнгийн хувийг шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял оногдуулж төсөвт тушаасан мөнгөтэй харьцуулан тооцоход дунджаар 10-12 хувийг энэ ажилд зарцуулж байна.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад тавих хяналтын талаар хуульд нарийвчилсан зохицуулалт байдаггүйгээс аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсвийг өөрөө батлан зарцуулж, өөртөө хяналт тавих боломжийг олгож байгаа учраас батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах байдал гарч байна. Жишээ нь:

- Баян-Өлгий аймаг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Өлгий сумын Дружба ууланд 30 метрийн өндөртэй, Монгол төрийн Соёмбыг байршуулахад 2.0 сая төгрөгийг;

- Архангай аймаг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Цагдаагийн газрын даргыг ОХУ-д 10 хоногийн терроризм, экстернизмийн гэмт хэрэгтэй тэмцэх сургалтанд хамруулахад 1.8 сая төгрөгийг;

- Баянхонгор аймаг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн газрын дарга, ажилтныг Япон улсад сургалтад хамруулахад 6.0 сая төгрөгийг;

- Төв аймаг нь Цагдаагийн Ерөнхий газрын сургалтын төвөөс зохион байгуулагдсан үнэ төлбөргүй сургалтад цагдаагийн 2 алба хаагчийг хамруулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.5 сая төгрөгийг;

- Булган аймаг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Цагдаагийн газрын дэд болон Мөрдөн байцаах тасгийн дарга нарыг ОХУ-д сургалтанд хамруулахад 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасан “Хэв журмын урамшилтай эргүүл жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил тутам тогтооно” 19 дүгээр зүйлийн 19.3.2 заалтад энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах”-аар заасан байдаг.

Гэтэл Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэгт “Аймаг нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олон нийтийн цагдаагийн тоог жил бүр тогтооно”, олон нийтийн цагдаатай холбоотой зардлыг тухайн шатны Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлж ажиллуулахаар тус хуулиар зохицуулсан. Гэтэл орон нутагт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны

зардал нь Засаг даргын захиран зарцуулах төсөвт тусгагддаггүйгээс Засаг дарга олон нийтийн цагдаатай холбоотой зардлыг шууд захиран зарцуулах боломжгүй.

Үүнээс гадна мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.11-д “Олон нийтийн цагдааг сургаж, дадлагажуулах үүргийг цагдаагийн байгууллага хүлээнэ” гэж заасны дагуу улсын хэмжээний олон нийтийн цагдаагийн 21 хоногийн сургалтыг тухай бүрд зохион байгуулах нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын төсөвт хүндрэлтэй байдаг бөгөөд олон нийтийн цагдааг ажиллуулахтай холбоотой үүрэг хариуцлагыг цагдаагийн байгууллагад оногдуулсан боловч урамшуулал, хувцас, тусгай хэрэгсэл, сургалтын зардлыг шийдвэрлэх эрх хуулиар цагдаагийн байгууллагад олгогдоогүй.

Өнөөдрийн байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах санхүүгийн гол эх сурвалж нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дахь заалт боловч түүнийг хэрэгжилт хангалтгүй байна.

Хуулийн заалтыг жигд бус зарим газарт огт хэрэгжүүлэхгүй байгаагаас олон нийтийн цагдаа ажиллуулах, иргэдийг нийтийн эргүүлд гаргах, хэв журмын урамшилтай эргүүл, гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах зэрэг олон ажлыг хэрэгжүүлэхэд санхүүгийн хүндрэл учирч байгаа тухай зарим аймгийн сумын засаг дарга нараас илэрхийлж байв.

Хуулийг хэрэгжүүлж төсвөөс хөрөнгө гаргадаг боловч аймаг, дүүргийн Иргэдийн хурлын төлөөлөгчдийн дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар зөвлөлүүд нь цагдаагийн байгууллагын саналыг харгалзалгүй зарцуулах явдал байдаг байна. Тээврийн зардал, хуучин тоног төхөөрөмж авч өгсөнөөр хуулийн заалтыг хэрэгжүүлсэнд тооцож байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх талаар заасан хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байгаа юм. Сумдад хувиарлаж байгаа мөнгөн хөрөнгөнөөс үзвэл нэг суманд дунджаар 2.0 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулжээ.

Сумдад гэмт хэргийн гаралт, тухайн жил хийгдэх ажил, арга хэмжээг төлөвлөхгүйгээр тэгшитгэн санхүүжилт олгож байгаа нь ажил, арга хэмжээ хүчгүйдэх, үр дүнгүй болоход хүргэж байна.

Аймаг, нийслэл, дүүргүүдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайлан мэдээллээс үзэхэд Баян-Өлгий аймагт 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 20 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бол Чингэлтэй дүүрэг 415 сая төгрөгийг төлөвлөн зарцуулжээ. Өөрөөр хэлбэл энэ нь тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний дарга, Засаг дарга нарын санаачилга, идэвхи зүтгэлээс шууд хамаарч байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төсөв мөнгө хангалттай төлөвлөж зарцуулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх томоохон алхам юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгө нэмэгдэх тусам энэ ажил үр дүнтэй байх боломж нэмэгдэх билээ. Гэхдээ энэ нь үргүй их зардал гаргахын нэр биш бөгөөд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шаардлагатай ажил арга хэмжээнд зарцуулахын талаар яригдаж байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй.

### 6.3 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ САНАА, ИННОВАЦИ, ҮР ДҮН, ДЭВШИЛТЭТ ТАЛУУД

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2017 онд урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой үр дүнд хүрэхүйц шинэ санаа, шинэлэг ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулснаас дурьдвал:

-Дэлхийн олон улсад жил бүр гэмт хэргийн байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийсэн Гэмт хэргийн цагаан номыг (white paper on crime book) тухайн улсынхаа онцлогт нийцүүлэн эрдэмтэн, судлаачаас бүрдсэн судалгааны мэргэжлийн байгууллага эрхлэн гаргадаг

туршлагыг нэвтрүүлэн “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”-г Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монголын криминологичдын холбоотой хамтран гаргав.

-Орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, нарийн бичгийн дарга, энэ чиглэлээр ажиллаж буй алба хаагч нарт зориулж “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй” номыг мэргэжлийн судлаачидтай хамтран боловсруулж, хэвлүүлэн холбогдох газруудад хүргэлээ.



-Нийслэлийн гудамж, талбайд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллага, аж ахуй нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Нийслэлийн цагдаагийн газар хамтран орон сууц, түүний гадна орчин, гэр хорооллын гудамж, талбайг камержуулах болзолт уралдааныг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулсан.

Энэхүү уралдаанд 15 хороо, 102 Сууц өмчлөгчдийн холбоо, 28 хөршийн хяналтын бүлэг, 108 иргэн идэвхтэй оролцож нийт 2211 ширхэг камер бүхий 534.431.328 төгрөгийн үнэ бүхий техник, хэрэгслийг суурилууллаа.

**КАМЕРЖУУЛАЛТЫН АЯН**  
2017.04.01-2017.06.01

**Нийслэлийн Засаг даргын Тамгын газар**

**Нийслэлийн цагдаагийн газартай хамтран**

- 15 хороо
- 102 сөх
- 28 хөршийн хяналтын бүлэг
- 108 иргэн

**534,431,328**  
төгрөгийн үнэ бүхий  
**2211** камер

-“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд талуудын оролцоо” сэдэвт чуулганыг 2017 оны 06 дугаар сарын



29-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулж, чуулганаас төр, төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хэвлэл мэдээллийн байгууллага болон иргэдэд хандан Зөвлөмж гарган, холбогдох газруудад хүргүүлсэн.



-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгаас урьдчилан сэргийлэх, нийгмийн болон эрүүл мэндийн чиглэлээр ажиллах холбогдох алба хаагч нарыг чадавхжуулах, мэргэшүүлэн сургах зорилгоор АНУ-ын Кломбо план хөтөлбөртэй хамтран үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, бэлтгэгдсэн сургагч багш нар энэ чиглэлээр ажилладаг ажилтнуудыг сургаж эхлээд байна.

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХОР  
УРШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НИЙГМИЙН БОЛОН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ**



-“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Азийн сантай хамтран “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй мөрдөн байцаалт, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслөөр энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар нэг мөр ойлголттой болгох сургалтад шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын мөрдөгч нар хамрагдаж эхлээд байна.

-Улсын хэмжээнд үйлдэгдэж буй зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулах, орон нутгийн зам дахь осол, хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” аяныг 06 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны

хооронд зохион байгууллаа.




### “ОРОН НУТГИЙН ЗАМ-ХӨДӨЛГӨӨНИЙ СОЁЛ” АЯН

Хууль зүйн салбараас 2017 оныг “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний жил” болгон хэрэгжүүлж байгаа ажлын хүрээнд Орон нутагт гарч буй зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулахад чиглэсэн дээрх ажил, арга хэмжээг 6 сараас 10 сарын хооронд зохион байгуулсан

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд хүргэх, мэдээ мэдээллээр хангах зорилгоор Зохицуулах зөвлөлийн албан ёсны цахим хуудас болох [www.ccsr.mn](http://www.ccsr.mn) цахим хаягийг нээж, аймаг, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон иргэд, олон нийтэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэв.

-Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, ялангуяа гар утас, цахим төхөөрөмжийн хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ухаалаг гар утас, төхөөрөмжийг бүртгэлжүүлэх ажлыг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран Үндэсний дата төв дээр эхлүүллээ.



-Улсын хэмжээнд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжээс заавал дагаж мөрдөх “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ MNS 5274:2003 Монгол Улсын стандарт”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулан Стандарт, хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр батлуулан 2018 оны 1 дүгээр сарын 01-нээс мөрдүүлсэн.



#### 6.4 АЛДАА, ДУТАГДАЛ, АНХААРАХ АСУУДЛУУД

Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурахгүй шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг бүрэн дүүрэн хамгаалж чадахгүй байгаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль бүрэн хэмжээгээр зохицуулж чадахгүй байгааг сүүлийн арваад жилд хийгдсэн криминологийн судалгааны дүн харуулж байна.

Тухайлбал: Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2005 онд хийсэн “Монгол Улсын хэмжээнд 1995-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа” болон Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль (Цагдаагийн академи) зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны төв, их сургууль, хүрээлэнгүүдээс улсын хэмжээний болон тодорхой бүс нутаг, гэмт хэргийн тодорхой төрлүүдээр хийгдсэн криминологи судалгааны тайлангуудад, гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах эрх зүйн орчинг шинэчлэн бүрдүүлэх, гэмт явдалтай нэгдсэн бодлого, стратегитэйгээр төр засаг, хувийн хэвшил, иргэд бүхий л субъектүүд жигд оролцоотойгоор тэмцэх, урьдчилан сэргийлэх, криминологийн шинэ арга, туршлагыг нэвтрүүлэх зэрэг санал, дүгнэлтүүд тусгагдсан байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт нь нийслэл, аймаг, дүүргийн салбар зөвлөлийн эдийн засгийн боломж, нөхцөл бололцоо, боловсон хүчний дутагдалтай байдал, ажлын ачаалал гэх мэт янз бүрийн шалтгаантай ч бодлогын түвшинд энэ асуудлыг авч үзэж, шийдвэрлэсэн нь хомс аж.

Түүнчлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн үнэлэх, дүгнэх талаар үнэлэмж, хэмжүүр байхгүй байгаа, орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гэмт хэрэг, зөрчлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцөлийг тодорхойлсон, үнэлэлт дүгнэлт өгсөн танилцуулга, мэдээлэл, тайлан хомс төдийгүй зөвхөн хууль сахиулах байгууллагын хүчээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэх төдийгөөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд ажлаа тайлагнадаг нийтлэг дутагдал байна.

Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайлан мэдээнээс үзвэл нутаг дэвсгэрийн хэмжээнд урьдчилан сэргийлэх ажил, хэсэгчилсэн болон нэгдсэн арга

хэмжээг хуучин явж ирсэн практик, ажлын туршлага дээр үндэслэн ерөнхий таамгаар ажлаа төлөвлөж, зохион байгуулдаг нь ажиглагдав. Түүнчлэн, тодорхой бодитой судалгаанд үндэслэн ажлаа төлөвлөх, зохион байгуулах хуулийн шаардлагад нийцээгүй үйл ажиллагаа явуулдаг байдал байсаар байна.

#### **Цаашид:**

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд суурилсан байх, олон талт хамтын ажиллагаанд тулгуурласан, олон нийтийн оролцоо, дэмжлэгт түшиглэсэн байх зарчимд үндэслэсэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх субъект нь зөвхөн цагдаагийн алба мэтээр ойлгогддог хандлагыг халж, "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" гэдэг түүнтэй хийж буй тэмцлийн томоохон бүрдэл хэсэг, төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгө, амь насыг хамгаалах хэрэгсэл бөгөөд уг ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх;
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дүгнэдэг шалгуур, үйл ажиллагааны арга зүйг орчин үеийн нөхцөл шаардлагад нийцүүлж өөрчлөх;
4. Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх;
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулахад шаардлагатай шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн сангийн давхардлыг арилгаж нэг урсгалд оруулан түүнд дүн шинжилгээ хийдэг мэргэжлийн багийг бүрдүүлж, тэндээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах;
6. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулахад анхаарах нь зүйтэй байна.

ХАВСРАЛТ 1. ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах 91/10.1	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 95/10.4	Хүний эрүүл мэндэд хохирол учруулах 96-100/11.1-11.6	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 120 <sup>1</sup> /11.7	Хүчиндэх 126/12.1	Хулгайлах 145/17.1	Дээрэмдэх 146,147/17.2	Залилах 148/17.3	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 181/20.16	Хүрээлэн байгаа орчны эсрэг 202-214 <sup>1</sup> /24.1-24.9	ХАБТХАЖЭ 215-225/27.1-27.11
Баганын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<b>ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА</b>											
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг бүгд, үүнээс:</b>	<b>189</b>	<b>470</b>	<b>8530</b>	<b>225</b>	<b>376</b>	<b>12222</b>	<b>1233</b>	<b>2996</b>	<b>727</b>	<b>330</b>	<b>1525</b>
Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг	101	9	4982	194	252	11719	1186	2490	467	237	847
ял сонсгосон	91	1	2964	95	119	3043	261	510	318	124	558
<b>ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА</b>											
<b>2002 оны Эрүүгийн хуулиар</b>											
Нийт ХБМБ явуулсан хэрэг	463	2432	14556	111	649	17946	2101	4362	3200	327	3190
Мөрдөн байцаалт явуулсан хэрэг, үүнээс:	294	2224	13551	106	476	10403	902	3309	2244	284	3004
Түдгэлзүүлсэн	3	7	186	2	22	3428	205	1015	74	19	39
Өөр хэрэгт нэгтгэгдсэн	26	2163	9783	34	98	4786	342	1794	960	96	1694
Хэрэгсэхгүй болгосон	0	0	5	0	3	20	5	14	7	0	2
Шүүхэд шилжүүлсэн	257	48	3540	68	343	2067	332	407	1183	161	1253
Үлдэгдэл	6	6	30	2	9	72	14	69	14	8	13
<b>2015 оны Эрүүгийн хуулиар</b>											
Нийт ХБМБ явуулсан хэрэг	109	1196	4060	199	255	7193	985	2030	68	226	1074
Мөрдөн байцаалт явуулсан хэрэг, үүнээс:	92	27	2528	93	111	913	157	303	26	124	546
Түдгэлзүүлсэн	0	0	3	2	1	116	12	23	1	0	0
Өөр хэрэгт нэгтгэгдсэн	2	1	53	3	6	28	5	19	1	12	8
Хэрэгсэхгүй болгосон	0	0	6	0	1	6	1	1	0	0	1
Шүүхэд шилжүүлсэн	80	20	2315	75	89	569	95	176	18	105	514
Үлдэгдэл	10	3	112	10	11	158	41	56	6	7	20
<b>ШҮҮХ</b>											
<b>2002 оны Эрүүгийн хуулиар</b>											
бүгд	168	2	1511	0	124	1098	135	220	412	68	464
хэрэгсэхгүй болгосон	1	0	643	1	2	110	2	25	7	1	44
шийдвэрлэсэн	122	1	1403	3	100	995	118	142	359	60	427
үлдэгдэл	8	0	12	0	6	20	3	14	3	0	5
Ял шийтгэгдсэн хүн бүгд	129	1	847	2	110	1430	215	125	509	102	399
<b>2002 оны Эрүүгийн хуулиар</b>											
бүгд	101	0	2916	65	132	565	97	223	32	90	514
хэрэгсэхгүй болгосон	0	0	14	1	0	1	0	1	1	1	1
шийдвэрлэсэн	74	0	2589	56	91	421	70	131	28	78	410
үлдэгдэл	22	0	226	6	31	91	19	49	4	7	71
Ял шийтгэгдсэн хүн бүгд	79	0	2753	27	110	432	140	112	9	42	212

ХАВСРАЛТ 2. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Нутаг дэвсгэр	ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА					ШҮҮХ								Ял шийтгэгдсэн хүн бүгд
	бүртгэгдсэн гэмт хэрэг, үүнээс:	Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй	ял сонгосон	илрүүлэлтийн хувь	илрээгүй хэрэг	хүлээн авсан хэрэг, бүгд	ХБ, МБ буцаасан	прокурорт буцаасан	түдгэлзүүлсэн	харьяаллын дагуу шилжүүлсэн	хэрэгсэхгүй болгосон	хянан шийдвэрлэсэн	үлдэгдэл	
Баганын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
<b>УЛСЫН ХЭМЖЭЭНД</b>	<b>32259</b>	<b>24853</b>	<b>8856</b>	<b>35.6</b>	<b>15997</b>	<b>10390</b>	<b>481</b>	<b>299</b>	<b>10</b>	<b>48</b>	<b>885</b>	<b>8839</b>	<b>681</b>	<b>9019</b>
<b>ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД</b>	<b>10273</b>	<b>6527</b>	<b>3574</b>	<b>54.8</b>	<b>2953</b>	<b>5752</b>	<b>192</b>	<b>118</b>	<b>6</b>	<b>42</b>	<b>572</b>	<b>5114</b>	<b>309</b>	<b>4927</b>
Архангай	514	368	169	45.9	199	241	34	5	0	7	12	174	21	199
Баян-Өлгий	319	154	101	65.6	53	168	6	3	0	0	13	150	9	142
Баянхонгор	563	338	151	44.7	187	296	8	19	0	0	31	259	10	281
Булган	362	258	132	51.2	126	201	4	19	1	6	14	174	16	168
Говь-Алтай	200	141	88	62.4	53	110	5	3	0	4	8	95	3	95
Говьсүмбэр	171	112	73	65.2	39	89	0	2	0	0	9	83	4	91
Дархан	768	536	281	52.4	255	400	1	1	1	0	42	374	23	364
Дорноговь	654	362	203	56.1	159	438	15	10	0	5	76	383	20	335
Дорнод	582	395	198	50.1	197	272	4	1	0	4	12	233	30	256
Дундговь	216	156	100	64.1	56	121	12	6	1	0	3	95	7	95
Завхан	221	155	104	67.1	51	119	5	5	0	5	29	121	5	123
Орхон	881	524	230	43.9	294	469	20	0	0	0	0	426	23	482
Өвөрхангай	492	367	198	54.0	169	290	1	1	0	5	29	260	23	266
Өмнөговь	462	257	169	65.8	88	299	8	7	0	0	27	267	13	259
Сүхбаатар	338	155	103	66.5	52	177	1	3	0	1	10	166	6	148
Сэлэнгэ	729	397	267	67.3	130	484	11	2	0	1	50	444	26	378
Төв	810	514	269	52.3	245	511	14	18	0	0	95	447	32	380
Увс	356	263	186	70.7	77	177	0	2	0	0	10	169	6	168
Ховд	433	213	129	60.6	84	258	21	2	0	0	35	224	11	198
Хөвсгөл	749	536	252	47.0	284	371	7	8	2	1	43	338	15	289
Хэнтий	453	326	171	52.5	155	261	15	1	1	3	24	232	6	210
<b>УЛААНБААТАР ХОТ</b>	<b>21947</b>	<b>18297</b>	<b>5272</b>	<b>28.8</b>	<b>13025</b>	<b>4638</b>	<b>289</b>	<b>181</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>313</b>	<b>3725</b>	<b>372</b>	<b>4092</b>
Багануур	254	168	83	49.4	85	117	4	2	0	0	12	106	5	96
Багахангай, Налайх	424	289	111	68.4	178	162	16	9	0	3	16	126	8	123
Баянгол	3204	2376	786	33.1	1590	1016	44	28	1	0	77	841	102	679
Баянзүрх	5939	5149	1159	22.5	3990	646	63	25	2	0	52	495	61	890
Сонгинохайрхан	3691	3191	958	30.0	2233	739	24	22	0	0	33	612	81	626
Сүхбаатар	3816	3444	975	28.3	2469	759	74	27	1	2	59	594	61	533
Хан-Уул	1900	1415	414	29.3	1001	725	34	34	0	0	23	569	27	410
Чингэлтэй	2719	2265	786	34.7	1479	474	30	34	0	1	41	382	27	735

## ХАВСРАЛТ 3. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ СТАТИСТИК, 2017

Үзүүлэлт		Мөр	Дүн
<b>1. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ</b>			
<b>НИЙТ ШИНЖИЛГЭЭ</b>		<b>1</b>	<b>13202</b>
шинжилгээний төрөл	Гарын мөр	2	9541
	Мөр судлал	3	1545
	Бичиг баримт	4	1066
	Галт зэвсэг	5	222
	Тэсрэх төхөөрөмж	6	7
	Дүр зураг	7	98
	Дүрс бичлэг	8	265
	Авто техник	9	235
	Компьютер судлал	10	131
	Бусад	11	92
хэргийн төрөл	Эрүүгийн хэрэг	12	12724
	Иргэний хэрэг	13	384
	Захиргааны хэрэг	14	94
шинжилгээ хийсэн үндэслэл:	Шүүгчийн захирамжаар	15	397
	Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоолоор	16	12722
	Эрх бүхий бусад байгууллагын хүсэлтээр	17	83
Шинжилгээний объектын тоо		18	214018
Шинжилгээ хийхээс татгалзсан		19	315
<b>Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо</b>		<b>20</b>	<b>36886</b>
Үүнээс:	Хүний амь нас хохирсон	21	4488
	Хулгайлах	22	16861
	Дээрэмдэх	23	565
	Зам тээврийн осол	24	7891
	Бусад	25	7081
Ул мөр илрээгүй		26	510
ЭБШ бусад ажиллагаанд:	Цогцосны үзлэг	27	4671
	Задлан шинжилгээ	28	2658
	Эксгумац	29	18
Шинжээчийн ур чадвараар нотолсон хэрэг:	Мөрдөн байцаалтын туршилт болон бусад ажиллагаа	30	1568
	Халуун мөрөөр нь холбогдогчийг тогтоосон хэрэг	31	330
	Шинжилгээгээр нотолсон эзэнгүй хэрэг	32	1037
<b>Гэрэл зургийн ажил</b>		<b>33</b>	<b>905959</b>
<b>2. ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ</b>			
<b>НИЙТ ШИНЖИЛГЭЭ</b>		<b>1</b>	<b>38090</b>
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ		2	27934
Үүнээс:	Анхны	3	27861
	Дахин	4	73
	Хүнд	5	1402
Үзлэгээр тогтоогдсон гэмтэл:	Хүндэвтэр	6	2364
	Хөнгөн	7	15048
	Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	8	4804
	Гэмтэл тогтоогдоогүй	9	4316
Хүний биед хийсэн бусад шинжилгээ		10	1220
Цогцост хийсэн шинжилгээ		11	4016
Хавтаст хэргийн материалаар хийсэн шинжилгээ		12	1409
Эд эсийн шинжилгээ		13	3492
Хэргийн төрөл:	Эрүүгийн хэрэг	14	34050
	Иргэний хэрэг	15	548
Шүүх хуралд эмч оролцсон		16	427
Үүнээс:	Хөдөө орон нутагт	17	149
	Нийслэлд	18	278

Үзүүлэлт		Мөр	Дүн
<b>3. ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭ</b>			
<b>НИЙТ ШИНЖИЛГЭЭ</b>		<b>1</b>	<b>14002</b>
Үүнээс. шинжилгээний төрөл	Хими	2	5894
	Физик	3	170
	Биологи	4	5679
	ДНХ-ээр эцэг тогтоох шинжилгээ	5	294
	ДНХ-ийн бусад шинжилгээ	6	971
	Бактериологи	7	994
Хэргийн төрөл	Эрүүгийн хэрэг	8	13696
	Иргэний хэрэг	9	299
	Захиргааны хэрэг	10	7
<b>4. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭ</b>			
<b>НИЙТ ШИНЖИЛГЭЭ</b>		<b>1</b>	<b>231</b>
Үүнээс:	Эрүүгийн хэрэг	2	194
	Иргэний хэрэг	3	32
	Захиргааны хэрэг	4	5
Томилолгүй буцаасан шинжилгээ		5	5
Үүнээс:	Тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн	6	
	Мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлтгүй	7	
	Объектийн бүрдэлгүй	8	
	Бусад	9	5
Томилогдсон шинжилгээний шийдвэрлэлт:		10	226
Үүнээс:	Санхүүгийн баримт ирүүлээгүйгээс буцсан	11	52
	Шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр буцсан	12	30
	Одоо хийж байгаа	13	8
	Шинжээчийн дүгнэлт гарсан	14	136
Хэргийн холбогдогч, бүгд:		15	136
Үүнээс:	Байгууллага	16	38
	Хүмүүс	17	98
Тогтоогдсон зөрчил, дутагдал:		18	136
Зөрчлийн шалтгаан:	Бүртгэл тайланд тусгаагүйгээс	19	61
	Хууль тогтоомж зөрчсөн	20	41
	Төсөв, норм, үнэлгээ хэтрүүлсэн	21	34
	Бусад	22	
	Татвар	23	18
	Цалин, НД-ын шимтгэл	24	24
Зөрчлийн хэлбэр	Бэлэн мөнгө	25	48
	Эд хогшил, бараа	26	46
	Бусад	27	
Холбогдогчийн албан тушаал	Дарга, захирал	28	29
	Нягтлан бодогч	29	26
	Эд хариуцагч	30	78
Дүгнэлтээр тогтоосон хохирол	Мянган төгрөгөөр	32	526.794.658.9
	Валютаар	33	4.142.373.3



ХАВСРАЛТ 4. АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ЭСРЭГ ЗАРИМ ГЭМТ ХЭРГИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Гэмт хэргийн төрөл	Шийдвэрлэлтийн төрөл						
	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг						
	нийт	Хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтайгаар	Өөр хэрэгт нэгтгэсэн	Түдгэлзүүлсэн	Харьяалалын дагуу шилжүүлсэн	Шүүхэд шилжүүлсэн	Үлдэгдэл
<b>Нийт</b>	<b>452</b>	<b>72</b>	<b>14</b>	<b>2</b>	<b>28</b>	<b>118</b>	<b>218</b>
Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	168	51	8	0	15	32	62
Хахууль авах	115	7	3	1	5	41	58
Хахууль өгөх	110	7	3	1	8	41	50
Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх	0	0	0	0	0	0	0
Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	28	6	0	0	0	0	22
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	30	0	0	0	0	4	26
Дураараа аашлах	1	1	0	0	0	0	0

## ХАВСРАЛТ 5. ХОРИХ ЯЛЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Гэмт хэргийн төрөл	Хоригдлын тоо	Насны бүлэг												
		16-17	18-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
баганын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
<b>Хүнийг алах ба Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх</b>	<b>1323</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>44</b>	<b>192</b>	<b>212</b>	<b>253</b>	<b>234</b>	<b>172</b>	<b>119</b>	<b>59</b>	<b>32</b>	<b>3</b>	<b>1</b>
Хүнийг санаатай алах 91	40	0	2	2	5	8	13	5	3	2	1	1	0	0
Хүнийг алах 10.1	1276	0	2	42	184	203	238	229	168	117	58	31	3	1
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 94.1	1	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 10.6	5	0	0	0	2	1	1	0	1	0	0	0	0	0
Бусдыг амиа хорлоход хүргэх 95		0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 10.4		0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Хүний эрүүл мэндэд хохирол учруулах 96-99/11.1-11.6</b>	<b>287</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>32</b>	<b>50</b>	<b>58</b>	<b>47</b>	<b>31</b>	<b>36</b>	<b>20</b>	<b>8</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>
Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах 96	35	0	0	2	7	11	3	4	6	1	1	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 11.1	238	0	3	29	42	40	44	25	28	18	7	0	1	1
Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах 11.2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын биемахбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах 97	3	0	0	1	0	2	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах 11.3	1	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0
Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах 98	1	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.4	5	0	0	0	1	2	0	1	1	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах 11.5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах 99	1	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 11.6	3	0	0	0	0	1	0	0	1	1	0	0	0	0
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 11.7	2	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	0	0
Хүчиндэх 126	38	0	1	8	6	7	8	2	2	2	2	0	0	0
Хүчиндэх 12.1	443	0	5	41	106	71	81	53	38	24	11	7	2	4
Хүн худалдаалах 113	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүн худалдаалах 13.1	6	0	0	2	2	1	1	0	0	1	0	0	0	0
Хулгайлах 145	153	0	4	26	41	29	26	12	10	5	0	0	0	0
Хулгайлах 17.1	239	2	4	41	46	47	42	28	15	4	10	0	0	0
Дээрэмдэх 147	23	0	2	4	8	4	4	1	0	0	0	0	0	0
Дээрэмдэх 17.2	178	0	9	66	43	31	15	9	5	0	0	0	0	0
Залилах 148	7	0	0	3	0	1	1	0	0	0	1	1	0	0
Залилах 17.3	50	0	0	4	11	10	8	3	5	3	3	1	1	1
Татвар төлөхөөс зайласхийх 166	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Татвар төлөхөөс зайласхийх 18.3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 166	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 18.6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Танхайрах 181	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 20.16	26	0	0	7	3	7	2	4	2	1	0	0	0	0
<b>Авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг</b>	<b>10</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг</b>	<b>46</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>10</b>	<b>13</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>
<b>Хүрээлэн байгаа орчны эсрэг</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

## ХАВСРАЛТ 5. ХОРИХ ЯЛЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Гэмт хэргийн төрөл	Боловсролын түвшин							Ял эдлэхийн өмнөх ажил эрхлэлт	
	дээд	ТМ бүрэн бус дунд	техник мэргэжлийн	бүрэн дунд	Бүрэн дунд бус	бага	боловсролгүй	ажилтай байсан	ажилгүй байсан
баганын дугаар	15	16	17	18	19	20	21	22	23
<b>Хүнийг алах ба Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх</b>	<b>104</b>	<b>41</b>	<b>35</b>	<b>395</b>	<b>427</b>	<b>168</b>	<b>153</b>	<b>286</b>	<b>1037</b>
Хүнийг санаатай алах 91	2	0	15	11	0	7	5	11	29
Хүнийг алах 10.1	100	40	20	381	426	161	148	275	1001
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 94.1	0	1	0	0	0	0	0	0	1
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 10.6	2	0	0	2	1	0	0	0	5
Бусдыг амиа хорлоход хүргэх 95	0	0	0	1	0	0	0	0	1
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 10.4	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Хүний эрүүл мэндэд хохирол учруулах 96-99/11.1-11.6</b>	<b>25</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>114</b>	<b>72</b>	<b>42</b>	<b>23</b>	<b>82</b>	<b>205</b>
Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах 96	4	1	0	13	7	4	6	9	26
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 11.1	21	4	4	97	63	34	15	70	168
Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах 11.2	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын биемахбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах 97	0	0	0	0	0	2	1	1	2
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах 11.3	0	0	0	1	0	0	0	0	1
Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах 98	0	0	0	0	0	1	0	0	1
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.4	0	0	0	2	2	1	0	0	5
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах 11.5	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах 99	0	0	0	1	0	0	0	0	1
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 11.6	0	0	1	0	0	0	1	2	1
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 11.7	1	0	0	0	0	0	1	1	1
Хүчиндэх 126	1	1	0	11	14	7	4	6	32
Хүчиндэх 12.1	14	10	4	121	137	79	78	88	355
Хүн худалдаалах 113	0	0	0	0	0	0	0	0	0
Хүн худалдаалах 13.1	0	1	0	1	3	0	2	1	6
Хулгайлах 145	4	4	0	40	52	28	25	17	136
Хулгайлах 17.1	8	6	4	70	68	46	37	21	218
Дээрэмдэх 147	0	1	3	7	5	3	4	1	22
Дээрэмдэх 17.2	5	6	2	91	39	17	18	30	148
Залилах 148	4	1	0	1	0	1	0	4	3
Залилах 17.3	30	2	0	13	4	1	0	21	29
Татвар төлөхөөс зайласхийх 166	0	0	0	0	0	0	0	0	0
Татвар төлөхөөс зайласхийх 18.3	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 166	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 18.6	0	0	0	0	0	0	0	0	0
Танхайрах 181	0	0	0	0	0	0	0	0	0
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 20.16	1	1	0	11	7	2	4	3	23
<b>Авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг</b>	<b>9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>9</b>	<b>1</b>
<b>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>13</b>	<b>14</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>16</b>	<b>30</b>
<b>Хүрээлэн байгаа орчны эсрэг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>1</b>

ХАВСРАЛТ 5. ХОРИХ ЯЛЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Үзүүлэлт	Хэдэн удаа шийтгэгдсэн										
	анх	2	3	4	5	6	7	8	9	10	10-аас дээш удаа
баганын дугаар	24	25	26	27	28	29	30	31	32	33	34
<b>Хүнийг алах ба Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх</b>	<b>796</b>	<b>272</b>	<b>124</b>	<b>53</b>	<b>35</b>	<b>19</b>	<b>17</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>
Хүнийг санаатай алах 91	33	3	2	1	0	1	0	0	0	0	0
Хүнийг алах 10.1	757	268	122	52	35	18	17	5	1	1	0
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 94.1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 10.6	4	1	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдыг амиа хорлоход хүргэх 95	1	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 10.4	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Хүний эрүүл мэндэд хохирол учруулах 96-99/11.1-11.6</b>	<b>188</b>	<b>47</b>	<b>27</b>	<b>12</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах 96	23	7	4	1	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 11.1	161	33	21	9	5	5	2	2	0	0	0
Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах 11.2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын биемахбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах 97	1	1	1	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах 11.3	0	0	1	0	0	0	0	0	0	0	0
Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах 98	1	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.4	1	2	0	2	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах 11.5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах 99	0	2	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 11.6	1	2	0	0	1	0	0	0	0	0	0
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 11.7	2	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүчиндэх 126	30	4	3	1	0	0	0	0	0	0	0
Хүчиндэх 12.1	297	74	26	20	13	8	1	2	2	0	0
Хүн худалдаалах 113	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүн худалдаалах 13.1	6	0	1	0	0	0	0	0	0	0	0
Хулгайлах 145	20	32	30	24	19	16	4	4	3	0	1
Хулгайлах 17.1	61	45	33	35	19	20	9	4	7	4	2
Дээрэмдэх 147	11	5	2	4	1	0	0	0	0	0	0
Дээрэмдэх 17.2	92	42	17	14	6	5	0	0	0	1	1
Залилах 148											
Залилах 17.3											
Татвар төлөхөөс зайласхийх 166	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Татвар төлөхөөс зайласхийх 18.3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 166	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 18.6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Танхайрах 181	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 20.16	11	2	7	6	0	0	0	0	0	0	0
<b>Авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг</b>	<b>34</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Хүрээлэн байгаа орчны эсрэг</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

## ХАВСРАЛТ 5. ХОРИХ ЯЛЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, 2017

Үзүүлэлт	Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа, жилээр															
	0-1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15-19	20-с дээш
баганын дугаар	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50
<b>Хүнийг алах ба Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>24</b>	<b>29</b>	<b>156</b>	<b>120</b>	<b>83</b>	<b>62</b>	<b>138</b>	<b>116</b>	<b>73</b>	<b>328</b>	<b>175</b>
Хүнийг санаатай алах 91	0	2	1	1	0	5	12	2	0	2	1	1	1	0	11	1
Хүнийг алах 10.1	0	1	0	2	5	19	17	154	120	81	61	137	115	73	317	174
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 94.1	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 10.6	0	1	1	2	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдыг амиа хорлоход хүргэх 95	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 10.4	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Хүний эрүүл мэндэд хохирол учруулах 96-99/11.1-11.6</b>	<b>21</b>	<b>117</b>	<b>48</b>	<b>26</b>	<b>34</b>	<b>16</b>	<b>13</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах 96	0	8	15	4	5	2	0	0	0	1	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 11.1	16	105	32	22	29	14	13	2	2	2	0	1	0	0	0	0
Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах 11.2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын биемахбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах 97																
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах 11.3																
Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах 98	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.4	3	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах 11.5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах 99	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 11.6	2	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 11.7	1	1	0													
Хүчиндэх 126	3	1	4	3	6	0	1	1	1	12	3	2	0	1	0	0
Хүчиндэх 12.1	9	27	38	15	14	15	9	9	6	18	11	74	60	35	84	26
Хүн худалдаалах 113	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хүн худалдаалах 13.1	0	0	0	0	3	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
Хулгайлах 145	6	75	47	14	5	3	1	1	0	1	0	0	0	0	0	0
Хулгайлах 17.1	30	78	52	18	20	17	7	11	1	3	2	0	0	0	0	0
Дээрэмдэх 147	2	3	3	2	4	5	1	1	0	0	1	0	0	1	0	0
Дээрэмдэх 17.2	28	67	32	20	12	8	5	4	1	0	0	1	0	0	0	0
Залилах 148	1	2	0	4	0	2	0	0	0	0	0	0	0	0	0	0
Залилах 17.3	8	12	11	2	9	4	1	0	2	1	0	0	0	0	0	0
Татвар төлөхөөс зайлсхийх 166	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Татвар төлөхөөс зайлсхийх 18.3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 166	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгө угаах 18.6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Танхайрах 181	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 20.16	7	11	2	1	3	1	1	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг</b>	<b>13</b>	<b>8</b>	<b>11</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Хүрээлэн байгаа орчны эсрэг</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**ДАА 340**  
**ННА 67**  
**М-Г-92**

#### СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ НЭГТГЭСЭН:

Б.Мөнхдорж (Ph.D)  
Г.Оюунболд  
Ц.Гантулгабат  
Б.Баяндүүрэн  
М.Цэдэвсүрэн  
О.Мөнхцэцэг  
Б.Ариунтуяа  
Б.Мөнхсэргэлэн  
О.Уулзахжаргал

#### ХЯНАН РЕДАКТОРЛАСАН:

Г.Эрдэнэбат  
Л.Нямгэрэл  
Ж.Болдбаатар (Sc.D)  
Д.Зүмбэрэллхам (Ph.D)  
Б.Батзориг (Ph.D)  
Б.Хишигсайхан

#### ДИЗАЙНЕР:

Я.Цэрэндэжид

Цаасны хэмжээ: А4  
Хэвлэлийн хуудас: 29.75

**МӨНХИЙН ҮСЭГ ХХК-д хэвлэв.**  
**ISBN 978-99978-4-964-9**